



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
БИЗНЕСИЙН ЭРХ ЗҮЙН МАСТЕРЫН ХӨТӨЛБӨР

АЯХАН

ГЭРЛЭЛТ ЦУЦЛАХ МАРГААНД ХҮҮХДИЙН
ЭРХИЙГ ХАМГААЛАХ
(МОНГОЛ БОЛОН БНХАУ-ЫН ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛАЛТ)



Мэргэжлийн индекс
042103

Бизнесийн эрх зүй
Мастерын зэрэг горилсон судалгааны ажил

Удирдсан
Ж.Даваасүрэн /LL.M/

Улаанбаатар. 2026



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
БИЗНЕСИЙН ЭРХ ЗҮЙН МАСТЕРЫН ХӨТӨЛБӨР

АЯХАН

**ГЭРЛЭЛТ ЦУЦЛАХ МАРГААНД ХҮҮХДИЙН
ЭРХИЙГ ХАМГААЛАХ
(МОНГОЛ БОЛОН БНХАУ-ЫН ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛАЛТ)**



Мэргэжлийн индекс
042103

Бизнесийн эрх зүйн
Мастерын зэрэг горилсон судалгааны ажил

Удирдагч : Ж.Даваасүрэн\LLM\

ГАРЧГИЙН ТОВЬЁГ

МЭДЭГДЭХ ХУУДАС	i
ТАЛАРХАЛ.....	ii
ТОВЧ ХУРААНГУЙ.....	iii
ABSTRACT	v
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	vii
ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ	viii
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	ix
НЭР ТОМЬЁНЫ ТАЙЛБАР	x
УДИРТГАЛ	1
Сэдвийн үндэслэл	1
Судалгааны зорилго:	3
Судалгааны ажлын зорилт:.....	3
Хүлээгдэж буй үр дүн	4
Сэдвийн судлагдсан байдал, Эрдэм шинжилгээний тойм.....	5
БҮЛЭГ 1. ОНОЛЫН ТОЙМ.....	12
1.1 Хүүхдийн эрхийг хамгаалах онолын үндэс	12
1.1.1 Хүүхдийн эрхийн эрх зүйн онолын хөгжил	12
1.1.2 “Хүүхдийн эрх ашиг нэн тэргүүнд байх” зарчмын онол.....	12
1.1.3 Эцэг, эхийн хариуцлагын орчин үеийн өөрчлөлт	13
1.1.4 Хүүхдийн эрхийг хамгаалахад асран хамгааллын тогтолцооны чиг үүрэг.....	14
1.2 Уулзалтын эрхийн эрх зүйн шинжилгээ	14
1.2.1 Хүүхдийн асрамж хамгаалалт болон тэжээн тэтгэлгийн онолын үндэс.....	14
1.2.2 Хүүхдийн тэтгэлэг тогтоох шалгуур болон бүс нутгийн ялгаатай байдал: Монгол ба БНХАУ-ын харьцуулалт.....	15
1.2.3 Уулзалтын эрхийн ойлголт, эрх зүйн шинж чанар	17
1.2.4 Уулзалтын эрхийг хэрэгжүүлэхэд учир буй сорилт, бэрхшээл	19
1.3 Харьцуулсан эрх зүйн онолын үндэс.....	20
1.3.1 Эрх зүйн рецепци буюу эрх зүйг нутагшуулах онол.....	20
1.3.2 Хууль зүйн бодит үр нөлөөний онол.....	21
1.3.3 Соёл хоорондын харьцуулсан эрх зүйн арга зүй.....	22
БҮЛЭГ 2. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙАЛ	23

2.1 Монгол Улсын уулзалтын эрхийн эрх зүйн тогтолцоо.....	23
2.1.1 Монгол Улсын гэр бүлийн эрх зүйн хөгжлийн тойм.....	23
2.1.2 Монгол Улс дахь хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн механизм (Асрамж, тэжээн тэтгэлэг, уулзах эрх).....	25
2.1.3 Монгол Улсыншүүхийн практикт уулзалтын эрхийн асуудал.....	28
2.1.4 Нийгэм-соёлын орчин дахь уулзалтын эрх.....	30
2.1.5 Монгол Улсын уулзалтын эрхийн тогтолцооны асуудлын оношлогоо.....	32
2.2 Хятад Улсын уулзалтын эрхийн эрх зүйн тогтолцоо ба практик шинжилгээ.....	34
2.2.1 Хятад улсын гэр бүлийн эрх зүйн хөгжлийн тойм	34
2.2.2 БНХАУ-ын Иргэний хууль дахь хүүхдийн эрхийн зохицуулалт (Асрамж, тэжээн тэтгэлэг, уулзах эрх).....	37
2.2.3 Шүүхийн практик, гүйцэтгэлийн асуудлууд	39
2.2.4 Хятад улсын нийгэм-соёлын орчин, нийгмийн дэмжлэгийн тогтолцоо.....	42
2.2.5 Хятад улсын уулзалтын эрхийн тогтолцооны давуу ба сул тал	44
БҮЛЭГ 3. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ.....	47
3.1 Судалгааны дизайн	47
3.1.1 Судалгааны арга зүй.....	47
3.1.2 Судалгааны алхам	48
3.1.3 Судалгааны харьцуулалтын үзүүлэлт ба хэмжигдэхүүн.....	49
3.2 Мэдээлэл, өгөгдөл цуглуулах үйл явц.....	50
3.2.1 Шүүхийн шийдвэрийн түүвэр судалгаа.....	50
3.2.2 Цуглуулсан тоон өгөгдлийн анхны бүтэц.....	51
3.2.3 Чанарын судалгааны мэдээлэл цуглуулах үйл явц	51
3.3 Судалгааны хувьсагчийн тайлбар (Explanation of Variables and Indicators).....	51
3.3.1 Үл хамаарах хувьсагчид (Independent Variables).....	52
3.3.2 Хамаарах хувьсагчид (Dependent Variables)	52
3.4 Өгөгдөл боловсруулах ба шинжилгээний арга зүй.....	53
3.4.1 Статистикийн дүрслэл болон харьцуулсан анализын арга	53
3.4.2 Эрх зүйн баримт бичгийн агуулгын шинжилгээ.....	54
3.4.3 Шүүхийн практикийн кэйс-лоо анализ	54
3.4.4 Шинжээчдийн ярилцлагын логик нэгтгэл	54
БҮЛЭГ 4. ЭМПИРИК СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ Ба ҮР ДҮН	55
4.1 Гэрлэлт цуцлах маргаан дахь хүүхдийн уулзалтын эрхийн хэрэгжилтийн харьцуулсан анализ	55
4.1.1 Хууль эрх зүйн зохицуулалтын нарийвчлал (X ₁)-ийн харьцуулсан үнэлгээ.....	55
4.1.2 Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албадлага ба дэмжлэгийн механизм (X ₂)-ийн харьцуулсан үнэлгээ	58
4.1.3 Нийгэм-соёлын орчны харьцуулалт	61

4.1.4 Харьцуулсан судалгааны онолын дүгнэлт.....	63
4.1.5 Нийтлэг сорилт, онцлог шинж, харилцан суралцах боломж	65
4.1.6 Төлөөлөх кейсүүдийн харьцуулсан шинжилгээ ба судалгааны үр дүнг нотлох нь.....	67
4.2. Монгол Улсын эрх зүйн шинэчлэл, бодлогын санал	68
4.2.1 Монгол Улсын уулзалтын эрхийн эрх зүйн шинэчлэлийн санал.....	68
4.2.2 Хятад улсын туршлагыг Монголд нутагшуулах боломж, хязгаар	71
4.2.3 Бүс нутгийн шүүхийн хамтын ажиллагааны механизм.....	73
4.2.4 Урт хугацааны хөгжлийн чиглэл	74
ДҮГНЭЛТ.....	77
САНАЛ ЗӨВЛӨМЖ.....	80
ХАВСРАЛТ	iii
НОМ ЗҮЙ.....	i

МЭДЭГДЭХ ХУУДАС

Энэхүү дипломын төслийг өөрийн оюуны бүтээл болохыг баталгаажуулж, зохиогчийн эрхийн аливаа зөрчилгүй болохыг баталж байна. Энэхүү дипломын төслийн зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг би дангаар эзэмшинэ.

Санхүү, Эдийн Засгийн Их Сургууль (СЭЗИС) энэхүү бүтээлийг сургалт, судалгаа, ашгийн бус зорилгоор, зохиогчийн эрхийн зөрчлөөс сэргийлэх үүндээс олон улсын creative commons attribution-noncommercial-noderivs (cc by-nc-nd) лицензийн дагуу ашиглах эрхтэй.

Нэр: Аяхан

Гарын үсэг:

Огноо: 2026 /06/04

ТАЛАРХАЛ

Мастерын дипломын төсөл бичихэд удирдсан багш Ж.Даваасүрэн болон зөвлөсөн хүмүүс, хамтран ажилласан СЭЗИС-ийн Хууль зүйн сургууль, Ахисан түвшний сургуульд дэмжин тусалсанд талархлаа илэрхийлье.

ТОВЧ ХУРААНГУЙ

Сүүлийн жилүүдэд Монгол Улс болон БНХАУ-д гэрлэлт цуцлуулахтай холбоотой маргаан нэмэгдэх тусам “хүүхдийн эрхийг хамгаалах” нь тулгамдсан асуудал болсон билээ. Ялангуяа гэрлэлт цуцлагдсаны дараа хүүхэдтэй хамт амьдрахгүй байгаа эцэг, эхтэй нь хүүхдийг уулзуулахгүй байх нь хүүхдийн ашиг сонирхлыг зөрчиж буй үйлдэл гэж үзэхээр байна.

Энэ судалгаагаар Монгол Улс болон БНХАУ-ын гэр бүлийн эрх зүйн тогтолцоонд гэрлэлт цуцлах маргаанд хүүхдийн эцэг, эхтэйгээ саадгүй, чөлөөтэй уулзах ашиг сонирхлыг хэрхэн хангах, уг харилцааг хэрхэн зохицуулж, шүүхийн практикт хэрхэн хэрэгжүүлж байгааг харьцуулан судалж, санал дүгнэлт гаргахыг зорьсон болно. Судалгааны хүрээнд хүүхдийн асрамж хамгаалалт, тэжээн тэтгэлэг болон уулзалтын эрхийн зохицуулалтыг цогцоор нь авч үзэж, хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн механизмыг харьцуулан шинжилсэн болно.

Судалгаанд харьцуулсан эрх зүйн судалгааны арга, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх, баримт бичгийн харьцуулан судлах зэргээр хууль зүйн судалгааны аргуудыг ашиглав.Юуны өмнө хүүхдийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд хамгаалах зарчим, эцэг, эхийн орчин үеийн хариуцлага талаарх судалгаа, тэдгээрийн хууль зүйн онцлог, хоёр улсын ард түмний үнэт зүйлсийг шалгуур болгон авч үзсэн.

Үүний дараа Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль болон холбогдох дүрэм, журам, шүүхийн практик, нийгэм-соёлын нөхцөлийг судлан хүүхдийн эцэг, эхтэйгээ уулзах ашиг сонирхлыг хангахад тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг тодруулан дүгнэлт өгөв.

Улмаар БНХАУ-ын Иргэний хууль болон шүүхийн шийдвэр, Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тусгай журам, гүйцэтгэлийг хангах механизмыг судалж, тэдгээрийн үр нөлөө, давуу болон сул талыг дүгнэлээ.

Харьцуулсан судалгааны үр дүнд хууль, тогтоомжид хүүхдийн ашиг сонирхлыг хангах зохицуулалтыг хангалттай тусгасан ч шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх хууль арга, хэрэгсэл тодорхойгүй, хэрэгжилт сул байгаа нь хүүхдийн ашиг сонирхлыг бодит амьдралд хэрэгжихгүй байх үндсэн шалтгаан болж байна.

Нөгөөтээгүүр, БНХАУ-д гэрлэлт цуцалсны дараа хүүхдийн эцэг, эхтэйгээ уулзах харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалт илүү нарийвчилсан, гүйцэтгэлийг хангах арга хэрэгсэл харьцангуй олон, гэр бүлийн хэрэгт мэргэшсэн шүүх, эвлэрүүлэн зуучлал, нийгмийн үйлчилгээний оролцоо өргөн байгааг тогтоов.

Харин Монгол Улсын хувьд эрх зүйн зохицуулалтын тодорхойгүй байдал, шүүхийн шийдвэрийн гүйцэтгэлийг хангах механизм олон төрлөөр хөгжөөгүй зэрэг нь хүүхдийн ашиг сонирхлыг хангахад хүндрэл учруулж байна.

Эдгээр дүн шинжилгээнд үндэслэн Монгол Улс дахь гэрлэлт цуцлах маргааны дараа хүүхдийг эцэг, эхтэй нь уулзуулахтай холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар “гэрлэлт цуцалсны дараа хүүхдийн эцэг, эхтэйгээ уулзах харилцааг хүүхдийн эрхийн түвшинд хуульчлах, гүйцэтгэлийн шатанд албадлага болон дэмжлэгийг хослуулсан шинэ механизм нэвтрүүлэх” зэрэг саналыг дэвшүүлсэн, Мөн БНХАУ-ын

институтийн туршлагыг Монгол Улсын нийгэм-соёлын онцлогт нийцүүлэн нутагшуулах боломжийг эрэлхийлж, онол-практикийн түвшинд судалсан нь энэхүү судалгааны ач холбогдол илэрхийлэх юм.

Эдгээр дүн шинжилгээнд үндэслэн Монгол Улс дахь гэрлэлт цуцлах маргааны дараа хүүхдийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар “гэрлэлт цуцалсны дараа хүүхдийн асрамж хамгаалалт, тэжээн тэтгэлэг болон эцэг, эхтэйгээ уулзах харилцааг хүүхдийн эрхийн түвшинд хуульчлах, гүйцэтгэлийн шатанд албадлага болон дэмжлэгийг хослуулсан шинэ механизм нэвтрүүлэх” зэрэг саналыг дэвшүүлсэн. Мөн БНХАУ-ын институтийн туршлагыг Монгол Улсын нийгэм-соёлын онцлогт нийцүүлэн нутагшуулах боломжийг эрэлхийлж, онол-практикийн түвшинд судалсан нь энэхүү судалгааны ач холбогдол илэрхийлэх юм.

Түлхүүр үг: *Гэрлэлт цуцлах маргаан, хүүхдийн эрх, гэр бүлийн эрх зүй, хүүхдийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд хамгаалах зарчим*

ABSTRACT

In recent years, as disputes related to divorce have increased in Mongolia and the People's Republic of China (PRC), "protecting children's rights" has become a pressing issue. In particular, preventing a child from meeting with the parent who does not live with them after a divorce is considered an act that violates the best interests of the child.

This study aims to examine and compare how the family law systems of Mongolia and the PRC ensure the child's interest in meeting with their parents without obstacles and freely in divorce disputes, how this relationship is regulated, and how it is implemented in judicial practice, in order to propose recommendations and conclusions. Within the scope of the study, the regulations governing child custody, maintenance, and visitation rights are considered comprehensively, and the legal mechanisms for protecting children's rights are analyzed comparatively.

The study utilizes legal research methods such as comparative legal analysis, judicial decision analysis, and comparative document analysis. First and foremost, the principle of protecting the child's best interests, the modern responsibility of parents, their legal characteristics, and the values of the peoples of the two countries were taken as criteria.

Following this, the Family Law of Mongolia, relevant rules, regulations, judicial practice, and socio-cultural conditions were studied to identify and draw conclusions on the difficulties and challenges faced in ensuring the child's interest in meeting with their parents.

Furthermore, the Civil Code of the PRC, judicial decisions, special procedures for resolving family cases, and enforcement mechanisms were studied, and their impact, advantages, and disadvantages were evaluated.

The results of the comparative study indicate that although regulations to ensure the best interests of the child are sufficiently reflected in the laws and legislations, the legal methods and means to enforce judicial decisions are uncertain and their implementation is weak, which is the primary reason why the best interests of the child are not realized in real life.

On the other hand, it was established that in the PRC, the legal regulations governing the relationship and visitation of a child with their parents after a divorce are more detailed, the means of ensuring enforcement are relatively numerous, and there is a broad involvement of specialized family courts, mediation, and social services.

However, for Mongolia, the uncertainty of legal regulations and the fact that mechanisms to ensure the enforcement of judicial decisions have not developed into diverse forms are causing difficulties in ensuring the best interests of the child.

Based on these analyses, regarding the improvement of the legal environment related to visitation between a child and their parents after a divorce dispute in Mongolia, proposals were put forward such as "legislating the interaction and visitation of a child with their parents after a divorce at the level of children's rights, and introducing a new mechanism combining enforcement and support at the execution stage". Furthermore, exploring the possibility of adapting the institutional experience of the PRC to the socio-cultural characteristics of Mongolia and studying it at the theoretical and practical levels demonstrates the significance of this research.

Based on these analyses, regarding the improvement of the legal environment for children after a divorce dispute in Mongolia, proposals were put forward such as "legislating the child custody, maintenance, and interaction with parents after a divorce at the level of

children's rights and introducing a new mechanism combining enforcement and support at the execution stage". Furthermore, exploring the possibility of adapting the institutional experience of the PRC to the socio-cultural characteristics of Mongolia and studying it at the theoretical and practical levels demonstrates the significance of this research.

Keywords: *Divorce disputes, children's rights, family law, the principle of protecting the child's best interests first.*

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1Түүвэрлэн авсан шүүхийн шийдвэрүүдийн ерөнхий бүтэц (Монгол ба Хятад Улс) 51

Хүснэгт 2Судалгааны хувьсагчдын матриц болон хэмжих индикаторуудын хураангуй53

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт 1 Асуулгын судалгааны нээлттэй хариултаудын нэгтгэл.....	iii
Хавсралт 2 Судалгааны ярилцлагын удирдамж	iv

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товчлол	Тайлбар
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГБТХ	Гэр бүлийн тухай хууль (Монгол Улсын)
ИХШХШТХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ХЭК	Хүүхдийн эрхийн конвенц (НҮБ-ын)
ХЭҮК	Хүний эрхийн Үндэсний Комисс
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ШШГТХ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль

НЭР ТОМЬЁНЫ ТАЙЛБАР

Нэршил	Тайлбар
Асран хамгаалах эрх/асран хамгаалалт	Насанд хүрээгүй хүүхдийн амь нас, эрүүл мэнд, боловсрол, хүмүүжил, эд хөрөнгийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах үүрэг бүхий эцэг, эх эсхүл шүүхээр томилогдсон асран хамгаалагчийн эрх, үүргийн нийлбэр.
Найдваргүй гүйцэтгэгчийн жагсаалт	БНХАУ-ын шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хэрэглэгддэг, шүүхийн шийдвэрийг хүндэтгэхгүй, санаатайгаар биелүүлэхгүй байгаа этгээдийг бүртгэж, нийгэм, эдийн засаг, зорчих эрхийн хувьд хязгаарлалт тогтоодог цахим мэдээллийн нэгдсэн систем.
Уулзалтын эрх	Гэрлэлт цуцалсны дараа хүүхэдтэй хамт амьдардаггүй эцэг, эх нь хүүхэдтэйгээ биечлэн уулзах, харилцах, холбоотой байх эрх, мөн хүүхэд тухайн эцэг, эхтэйгээ харилцаагаа хадгалах эрх.
Хүүхдийн санал бодлоо илэрхийлэх эрх	Хүүхэд өөртэй нь холбоотой аливаа асуудлаар (ялангуяа гэрлэлт цуцлах маргаанд хэнтэй нь амьдрах, нөгөө талтай хэрхэн уулзах зэрэг) өөрийн нас, сэтгэхүйн онцлогт тохируулан санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, шүүх түүнийг нь шийдвэр гаргахдаа харгалзан үзэх олон улсын болон дотоодын хуулиар баталгаажсан эрх.
Хүүхдийн эрх ашиг нэн тэргүүнд байх зарчим	Хүүхэдтэй холбоотой аливаа шийдвэр, ажиллагаа бүрт хүүхдийн одоогийн болон ирээдүйн амьдрал, хөгжлийн хэрэгцээг хамгийн түрүүнд харгалзан үзэх, бусад сонирхолд захируулах суурь эрх зүйн зарчим.
Хүүхэдтэй хамт амьдарч буй тал	Гэрлэлт цуцалсны дараа шүүхийн шийдвэр эсвэл эцэг, эхийн хэлцлийн дагуу хүүхдийн өдөр тутмын амьдралыг авч явах, хүүхэдтэй байнгын хамт амьдрах эрх, үүргийг хүлээсэн эцэг эсхүл эх.
Эрх зүйн нутагшуулалт	Нэг улсын эрх зүйн тогтолцоо, хууль тогтоомжийн тодорхой институт, хэм хэмжээг нөгөө улсын эрх зүйн систем, нийгэм-соёлын хөрсөнд дасан зохицуулж, шилжүүлэн нэвтрүүлэх онол, практик үйл ажиллагаа.

УДИРТГАЛ

Сэдвийн үндэслэл

Сүүлийн хэдэн жилүүдэд дэлхийн олон улс оронд гэрлэлт, гэр бүлийн харилцаанд гүнзгий өөрчлөлт гарч, гэрлэлт цуцлах маргаан тоо өсөх хандлага болсон нь хүүхдийн ашиг сонирхлыг хамгаалах шинэ сорилтуудыг бий болгож байна.

Зүүн Азийн соёл-түүхийн ижил төстэй орчинд орших Монгол Улс болон БНХАУ нь социалист тогтолцооноос зах зээлийн эдийн засагт шилжсэн, нийгмийн бүтцийн гүнзгий өөрчлөлт, хотжилт, хөдөлмөрийн шилжилт эрчимтэй өрнөж буйтай холбогдуулан гэр бүл цуцлам маргаан нэмэгдэж, гэр бүлийн уламжлалт загвар, эрх, үүргийн хуваарь өөрчлөгдөж байна.

Үүний нэг илрэл нь гэрлэлт цуцлах маргаан, түүний дотор хүүхдийг асран хамгаалах, уулзалтын эрхийг тойрсон маргаан жилээс жилд нэмэгдэж, хууль тогтоомж, шүүхийн практик, нийгмийн дэмжлэгийн тогтолцоонд ноцтой сорилт учруулж буй явдал юм.

Олон улсын түвшинд хүүхдийн эрхийн баталгааг хангах эрх зүйн тогтолцоо харьцангуй эрт төлөвшиж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Хүүхдийн эрхийн тухай конвенц”-оор дамжин бүх хүүхэд аливаа улс орны нутаг дэвсгэр дээр төрөлхөөсөө эдлэх ёстой үндсэн эрхийг тодорхойлогдсон.

Энэхүү конвенцын гол тулгуур зарчмын нэг нь “хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд хамгаалах” зарчим бөгөөд гэр бүл, асран хамгаалалт, салалт, уулзалтын эрхтэй холбоотой аливаа шийдвэр гаргахдаа тухайн хүүхдийн бодит эрх ашиг, хөгжлийн хэрэгцээг хамгийн түрүүнд харгалзан үзэхийг улс орнуудаас шаардаж байна.

Монгол Улс 1990 онд тус конвенцод нэгдэн орж, улмаар Үндсэн хууль болон “Гэр бүлийн тухай”, “Хүүхдийн эрхийн хамгааллын тухай” болон төрийн бусад бодлого, хөтөлбөрт хүүхдийн эрхийн хамгаалалтын суурь зарчмуудыг тусгаж эхэлсэн.

БНХАУ мөн адил уг конвенцод нэгдэн орж, хүүхдийн эрхийн хамгаалалтыг иргэний хууль тогтоомж, гэр бүлийн эрх зүйн зохицуулалт, хүүхэд хамгааллын тусгай хуулиараа баталгаажуулсан байдаг.

Ийнхүү олон улсын гэрээ, конвенц болон үндэсний хууль, тогтоомжид уг харилцааг хуульчлан зааж, баталгаажуулсан хэдий ч бодит амьдралд дээр хүүхдийн эрх бодитой хамгаалагдахгүй байна.

Энэ нь зөвхөн эрх зүйн маргаан төдий бус, хүчтэй сэтгэл хөдлөл, хувийн өш хонзон, эдийн засгийн ашиг сонирхол, нийгмийн байр суурийн өөрчлөлт зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг, хүүхдийн хамгийн ихээр зөрчигдөх эрсдэлтэй орчин юм. Энэ нөхцөлд хүүхдийн асран хамгаалалт, уулзалтын эрхийн талаар гарч буй хууль зүйн шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт нь хүүхдийн сэтгэлзүйн хөгжил, нийгэмших үйл явц, ирээдүйн амьдралд урт хугацааны гүн нөлөө үзүүлдэг.

Монгол Улсын хувьд зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойш, нийгмийн шилжилтийн явцад ядуурал, ажилгүйдэл, шилжилт хөдөлгөөн, архидалт зэрэг нийгмийн асуудлууд нэмэгдэж, гэр бүлийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлсөн.

Үүнтэй зэрэгцэн жендерийн тэгш байдал, гэр бүлийн доторх эрх мэдлийн бүтэц өөрчлөгдөж, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, боловсролын түвшин өсөхийн хэрээр гэр бүлийн харилцаанд уламжлалт “тэвчих” загварын оронд харилцан тохиролцох, шаардлагатай үед гэрлэлтээ цуцлуулах замаар асуудлыг шийдвэрлэх хандлага нэмэгдэж байна.

Статистикийн албан ёсны бүртгэл, шүүхийн мэдээллээс харахад гэр бүл цуцлах хүсэлт, түүнтэй холбоотой асран хамгаалалт, тэжээн тэтгэх, гэр бүлийн эд хөрөнгийн хуваарилалт, уулзалтын эрхийн маргааны тоо нэмэгдэх хандлагатай байгаа хэдий ч хүүхдийн эрхийн хамгаалалтын үр нөлөө, ялангуяа эцэг, эхээс тусдаа амьдрах болсон талын уулзалтын эрхийг хэрэгжүүлэх байдал санаа зовоосон хэвээр байна.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Монгол Улсын “Гэр бүлийн тухай” хуульд эцэг, эхийн эрх, үүрэг, хүүхдийн эрхийг ерөнхий түвшинд тодорхойлж, дараах асран хамгаалалт, уулзалтын талаар зарим зохицуулалт оруулсан хэдий ч уулзалтын эрхийн ойлголтыг нарийвчлан тодорхойлсон, эрхийн агуулга, хэрэгжүүлэх хэлбэр, хугацаа, давтамж, талуудын эрх, үүргийг тодорхой заагласан цогц зохицуулалт харьцангуй дутмаг байна.

Түүнчлэн уулзалтын эрхийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг хэрхэн хэрэгжүүлэх, талуудын хууль ёсны үүргийг биелүүлэхээс татгалзсан тохиолдолд ямар хариуцлагын арга хэмжээ авах, ямар төрлийн албадлагын механизм ашиглах зэрэг гүйцэтгэлийг хангах зохицуулалт сул хөгжсөн байна.

Үүний улмаас практикт уулзалтын эрхээ эдлэх гэж оролдож буй эцэг, эхийн нэг тал шүүхийн шийдвэр авсан ч нөгөө тал санаатайгаар саад учруулах, хүүхдийг уулзуулахгүй байх, эсхүл уулзах хугацаа, нөхцөлийг дур мэдэн өөрчлөх зэрэг зөрчил гарч, хүүхдийн амьдралын хэвийн дэглэм, сэтгэлзүйн байдалд сөрөг нөлөө үзүүлдэг.

БНХАУ -ын эрх зүйн практик үүнтэй тодорхой хэмжээгээр төстэй, нөгөө талаар зарим онцлог шинжийг харуулдаг. Хятадад 1980-аад оноос хойш гэр бүлийн тухай хууль тогтоомж үе шаттайгаар шинэчлэгдэж, 2020 онд баталсан Иргэний хуулиар гэр бүлийн эрх зүйн зохицуулалт илүү системтэй болжээ.

Уулзалтын эрхийн тухай тусгай заалтуудыг бий болгож, эцэг, эхийн уулзалтын эрхийг хүүхдийн эрхтэй уялдуулан зохицуулах, цаг хугацаа, газар, хэлбэрийн хувьд тодорхойлох, хүүхдийн эрх ашигт харш нөлөө байвал шүүх уулзалтын эрхийг түр хугацаагаар хязгаарлах, зогсоох боломжтой байхыг хуульчилсан.

Мөн зарим бүс нутагт гэр бүлийн хэрэгт эвлэрүүлэн зуучлал, гэр бүлийн шүүхийн тусгай журам, уулзалтын эрхийн гүйцэтгэлийг хангах нэмэлт арга хэрэгсэл (жишээлбэл, торгууль, шийдвэр биелүүлээгүй этгээдийг зээлийн мэдээллийн санд бүртгэх гэх мэт)-ийг туршиж байна.

Энэ нь уулзалтын эрхийн гүйцэтгэлтэй холбоотой бэрхшээлийг бууруулах, хүүхдийн эрх ашгийг бодит амьдралд илүү үр дүнтэй хамгаалах зорилготой юм.

Гэвч Монгол Улс болон БНХАУ-д нийтлэг ажиглагддаг гол асуудал бол хууль тогтоомжид хүүхдийн эрхийг хамгаалах зарчим, уулзалтын эрхийн талаарх зохицуулалт тодорхой хэмжээгээр тусгагдсан ч шүүхийн практик, гүйцэтгэл, нийгмийн дэмжлэгийн тогтолцооны түвшинд бодит үр дүн хангалтгүй байгаа явдал юм.

Шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх явцад хүүхдийн хүсэл зоригоор далимдуулан уулзалтыг саатуулах, эсхүл эцэг, эхийн хоорондын эдийн засгийн болон хувийн зөрчлийг “уулзалтын эрхээр дамжуулан” илэрхийлэх, шийдвэрийг удаашруулах, биелүүлэхээс зайлсхийх байдал түгээмэл тохиолдож байна.

Энэ нь нэг талаас хууль тогтоомжийн тодорхой бус байдал, гүйцэтгэлийг хангах механизмын сул талыг харуулж байгаа бол нөгөө талаас хүүхдийн эрхийн талаарх нийгмийн ухамсар, гэр бүлийн харилцааны соёл, уламжлалт үзэл хандлагын нөлөөг илтгэнэ.

Судалгааны зорилго:

Энэхүү судалгааны ажлын үндсэн зорилго нь Монгол Улс болон БНХАУ-ын гэр бүлийн эрх зүйн хүрээнд гэрлэлт цуцалсны дараах хүүхэдтэй уулзах эрхийн зохицуулалтыг харьцуулан шинжлэхэд оршино. Үүний үндсэн дээр Монгол Улсын практикт тулгамдаж буй эрх зүйн болон институцийн асуудлуудыг илрүүлж, БНХАУ-ын туршлагыг Монгол Улсын нөхцөлд нутагшуулах чиг баримжаатай, Монгол Улсын онцлогт тохирсон эрх зүйн шинэчлэлийн чиглэл, бодлогын тодорхой санал боловсруулахад оршино.

Судалгааны ажлын зорилт:

Дээрх зорилгод хүрэхийн тулд энэхүү судалгаанд дараах тодорхой зорилтуудыг дэвшүүлэв.

- 1. Монгол Улсын эрх зүйн орчин ба практикт дүн шинжилгээ хийх:** Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Гэр бүлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид хүүхэдтэй уулзах эрхийн ойлголт, хэрэгжүүлэх журам, түүнийг хязгаарлах, сэргээх нөхцөлийг хэрхэн тусгасныг шинжлэх, шүүхийн практик болон шийдвэр гүйцэтгэлийн шатанд үүсэж буй хүндрэл, хуулийн хийдлийг тогтоох;
- 2. БНХАУ-ын эрх зүйн зохицуулалт, туршлагыг судлах:** БНХАУ-ын Иргэний хууль, дээд шүүхийн тайлбар, гэр бүлийн маргаан хянан шийдвэрлэх журмын хүрээнд уулзах эрхийн зохицуулалт, гүйцэтгэлийг хангах механизм болон үүнтэй уялдсан нийгмийн үйлчилгээний тогтолцоог системтэйгээр судалж, давуу болон сул талыг дүгнэх;
- 3. Харьцуулсан судалгаа хийх:** Монгол Улс болон БНХАУ-ын Хууль зүйн зохицуулалт, шүүхийн практик, шийдвэр гүйцэтгэлийн механизм, нийгэм-соёлын орчин, хүүхэдтэй уулзах эрхийн тогтолцоог хууль эрх зүй, шүүхийн практик, шийдвэр гүйцэтгэлийн механизм, нийгэм-соёлын орчны түвшинд харьцуулан шинжилж, нийтлэг сорилт, ялгаатай тал болон харилцан суралцах боломжийг илрүүлэх;
- 4. Хууль зүйн нутагшуулалтын боломжийг үнэлэх:** Хууль зүйн шилжилт, нутагшуулалтын онолыг удирдлага болгон БНХАУ-ын уулзах эрхийн

тогтолцооны аль элементүүдийг Монгол Улсад нэвтрүүлэх нийгэм-соёлын орчинд үл зохицох, эрсдэл дагуулах байдлыг онолын болон практикийн түвшинд үнэлэх;

- 5. Бодлогын зөвлөмж боловсруулах:** Судалгааны үр дүнд тулгуурлан Монгол Улсад гэрлэлт цуцлах маргааны дараах хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн үр нөлөөг дээшлүүлэх, институцийн шинэчлэл болон нийгмийн дэмжлэгийн тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн хууль тогтоомжийн өөрчлөлтийн санал, зөвлөмж гаргах.

Хүлээгдэж буй үр дүн

Энэхүү судалгааны ажил нь онлын болон практик түвшинд дараах үр дүнд хүрэх ач холбогдолтой гэж үзэж байна.

Онолын ач холбогдлын хувьд: Монгол Улс болон БНХАУ-ын хүүхэдтэй уулзах эрхийн зохицуулалт, шүүхийн практик, нийгэм-соёлын орчныг системтэйгээр харьцуулсан анхны судалгаануудын нэг болж бүс нутгийн хэмжээнд гэр бүлийн эрх зүйн харьцуулсан судалгаа болон хүүхдийн эрхийн онолын судалгаанд ашиглах суурь эх сурвалжийг бүрдүүлэх:

- Гэрлэлт цуцлах маргааны хүрээнд "хүүхдийн эрх ашиг нэн тэргүүнд байх" зарчмыг гэрлэлт цуцлах маргаан, уулзалтын эрхийн хүрээнд хэрхэн тайлбарлаж, хэрэглэх онолын суурийг баяжуулж, хүүхдийн эрхийн тунхаглалын шинжтэй зарчмыг "бодит амьдрал дээр хэрэгжиж буй эрх" болгон хувиргах талаархи ойлголтыг гүнзгийрүүлэх;
- Монгол Улс болон БНХАУ-ын жишээн дээр гэр бүлийн эрх зүйн салбар дахь "хууль зүйн шилжилт, нутагшуулалтын онол"-ыг хэрэглэснээр ижил төстэй нийгэм-соёлын суурьтай улс орнуудын хооронд эрх зүйн институцийг шилжүүлэн нутагшуулах үйл явцыг тайлбарлах аналитик загварыг боловсруулна. Энэхүү загварт тулгуурлан эрх зүйн шилжилтийн давуу тал болон эрсдэлийг илрүүлсэн жишээчилсэн судалгааг бий болгоно.

Практик ач холбогдлын хувьд: Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид хүүхэдтэй уулзах эрхийн агуулга, хэрэгжүүлэх журам, хязгаарлах болон сэргээх механизмыг тодорхой болгох хууль зүйн үндэслэлтэй бодлогын санал, институцийн загварыг боловсруулах бөгөөд энэ нь уулзах эрхийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг практикт бодитойгоор сайжруулахад ашиглаж болох, хууль зүйн үндэслэлтэй бодлогын санал, институцийн зохион байгуулалтын загвар боловсруулах;

- Гэр бүлийн маргаан шийдвэрлэхэд оролцдог шүүгч, өмгөөлөгч, шийдвэр гүйцэтгэгч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарт зориулсан эрх зүйн болон практик лавлагааны материалыг бэлтгэж, хүүхдийн эрхэд ээлтэй шийдвэр гаргах, гүйцэтгэх үйл ажиллагаанд ашиглах боломжийг бүрдүүлэх;
- Монгол Улс болон БНХАУ-ын гэр бүл, хүүхдийн эрхийн салбар дахь шүүхийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, хил дамнасан гэр бүлийн маргаанд эрх зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоог хөгжүүлэх харьцуулсан судалгааны үндэс бий болгох;

- Хүүхдийн эрх болон гэр бүлийн бодлогын чиглэлээр ажилладаг төрийн байгууллага, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод хэлэлцүүлэг, бодлого боловсруулахад ашиглаж болох судалгааны дүн, санал, зөвлөмжийг гаргаж, олон нийтийн дунд хүүхдийн уулзалтын эрхийн талаарх ойлголт, хандлагыг өөрчлөхөд тодорхой хувь нэмэр оруулах;

Судалгааны хязгаарлалт: Судалгаа нь дараах хязгаарлалтыг агуулна

Нэг. Эх сурвалж, мэдээллийн хүртээмжийн хязгаарлалт: Монгол Улсын шүүхийн шийдвэр, статистикийн мэдээлэл, БНХАУ-ын шүүхийн маргаанүүдийн бүрэн хэмжээний, нарийвчилсан мэдээлэлд нэвтрэх боломж хязгаарлагдмал байсан тул судалгаанд ашигласан маргаан, тоон мэдээлэл нь бүхэл тогтолцоог бүрэн төлөөлж чадахгүй байх эрсдэлтэй. Иймээс тоон дүгнэлтээс илүү чанарын, тайлбарлах шинжилгээнд түлхүү анхаарсан.

Хоёр. Соёлын онцлогийг ойлгох, тайлбарлах хязгаарлалт: Монгол Улс ба БНХАУ - д ижил төстэй талтай ч өөрийн гэсэн онцлог бүхий соёл, уламжлал, гэр бүлийн үнэт зүйлстэй. Судалгаанд эдгээрийг аль болох харгалзан үзэхийг зорьсон боловч бичиг баримтад тулгуурласан шинжилгээний арга давамгайлж байгаа тул хоёр улсын гэр бүлийн амьдралын өдөр тутмын амьдрал, соёлын нарийн ялгааг бүрэн илэрхийлж чадаагүй байх магадлал бий.

Гурав. Судалгаанд сонгосон маргаан, жишээний төлөөлөх чадварын хязгаарлалт: Шүүхийн шийдвэрүүдийг сонгон авахдаа нийтлэг хандлагыг баримталсан ч сонголт хийхэд зайлшгүй “субъектив” шинжийг агуулдаг. Иймээс маргаанийн шинжилгээнд гарсан дүгнэлтийг бүх тохиолдолд хамаарна гэж үзэх боломжгүй, харин чиг хандлага, нийтлэг дүр зураг гэж ойлгох нь зүйтэй.

Эдгээр хязгаарлалтыг цаашдын гүнзгийрүүлсэн, өргөтгөсөн судалгааны ажлуудаар нөхөх боломжтой бөгөөд энэхүү магистрын ажил нь уг чиглэлийн цаашдын судалгааны суурь эхлэл болох зорилготой юм.

Сэдвийн судлагдсан байдал, Эрдэм шинжилгээний тойм

Судалгааны чиглэл

Иймд дээрх нөхцөл байдлыг харгалзан үзвэл, Монгол Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улс дахь хүүхэдтэй уулзах эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалт, шүүхийн практик практик, нийгэм-соёлын нөхцөл байдлыг харьцуулан судлах нь дараах хэд хэдэн бодит шалтгаан, шаардлагад тулгуурлаж байна.

Нэгдүгээрт, Монгол Улсын өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй “Гэр бүлийн тухай” хууль тогтоомж, түүнийг дагалдан гарсан журам болон шүүхийн практикт хүүхэдтэй уулзах эрхийн бодит хэрэгжилттэй холбоотой үүсэж буй гол хүндрэл, эрх зүйн хийдлийг нарийвчлан оношлох шаардлагатай байна.

Хоёрдугаарт, Бүгд Найрамдах Хятад Ард Улсад хүүхэдтэй уулзах эрхийн талаарх зохицуулалт түүхэн хугацаанд хэрхэн төлөвшиж ирсэн, ямар эрх зүйн шийдэл, шүүхийн тусгайлсан дэг журам, нийгмийн дэмжлэгийн цогц арга хэмжээнүүдийг практикт хэрэгжүүлж буйг судалснаар Монгол Улсын хувьд аль зохицуулалтыг үндэсний эрх зүйн

хөрсөнд нутагшуулах боломжтой, алийг нь шууд хуулбарлахад тохиромжгүй болохыг тодорхойлох боломжтой.

Гуравдугаарт, ижил төстэй нийгмийн шилжилтийн туршлага болон түүх-соёлын тодорхой ижилсэл бүхий хөрш орнуудын гэр бүлийн эрх зүйн тогтолцоог харьцуулан судлах нь бүс нутгийн хэмжээнд хүүхдийн эрхийг хамгаалах, гэр бүлийн маргааныг шийдвэрлэх эрх зүйн интеграцид онол-арга зүйн шинэ суурь тавих алсын хараатай ач холбогдолтой юм.

Энэ бүхнээс үзэхэд “ маргаанд хүүхдийн эрхийг хамгаалах нь: Монгол Улс ба БНХАУ -ын хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа” гэсэн сэдвийг сонгосон нь, нэг талаас Монгол Улсын гэр бүлийн эрх зүйн практикт тулгамдсан уулзалтын эрхийн хэрэгжилтийн асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судалж, тухайн тогтолцооны давуу болон сул талыг илрүүлэх, нөгөө талаас БНХАУ -ын туршлага, эрх зүйн шийдлийг шинжилж, нутагшуулах боломж, хязгаар, эрсдэлийг тодорхойлох зорилготой юм. Ийнхүү асуудлыг дэвшүүлж байгаа нь цаашид судалгааны зорилго, ач холбогдол, онол-аргазүйн суурийг тодорхойлох, харьцуулсан судалгааны хүрээг тогтоох эхлэл болно.

Энэ бүхнээс үзэхэд “Гэрлэлт цуцлах маргаанд хүүхдийн эрхийг хамгаалах” , “Монгол Улс болон БНХАУ-ын хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа” хэмээх сэдвийг сонгон авсан нь, нэг талаас Монгол Улсын гэр бүлийн эрх зүйн практикт тулгамдаж буй хүүхэдтэй уулзах эрхийн хэрэгжилтийн асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр шинжлэн судалж, тухайн тогтолцооны давуу болон сул талыг илрүүлэх бодит хэрэгцээг хангана. Нөгөө талаас БНХАУ-ын туршлага, эрх зүйн шийдлийг шинжилж, үндэсний эрх зүйн тогтолцоонд нутагшуулах боломж, хязгаарлалт, үүсэж болох эрсдэлийг урьдчилан тодорхойлох зорилготой юм. Ийнхүү асуудлыг цогц байдлаар дэвшүүлж байгаа нь цаашид судалгааны зорилго, практик ач холбогдол, онол-арга зүйн суурийг бататгах, харьцуулсан судалгааны хүрээ хязгаарыг нарийвчлан тогтоох үндсэн эхлэл болно.

Олон улсын судалгааны чиг хандлага

Хүүхдийн эрхийн онол ба “хүүхдийн эрх ашиг нэн тэргүүнд байх” зарчим: Олон улсын түвшинд хийгдсэн судалгаануудын ихэнх нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Хүүхдийн эрхийн конвенц” (CRC)-ийг суурь баримт бичил болгон авч үздэг. Freeman, van Bueren, Archard зэрэг эрдэмтэд хүүхдийн эрхийн ойлголтын түүхэн хувьслыг тайлбарлаж, хүүхдийг “хамгаалуулах объект” гэж үздэг байсан уламжлалт хандлагаас “бие даасан эрхийн субъект” гэж үзэх орчин үеийн үзэл баримтлал руу шилжсэн үйл явцыг тодорхойлсон байдаг. Тэд хүүхдийн эрхийг иргэний ба улс төрийн эрх, эдийн засаг, нийгэм, соёлын эрх, хамгаалалтын эрх, оролцооны эрх гэж ангилан, эдгээр эрхүүдийг гэр бүлийн маргааны хүрээнд хэрхэн хэрэгжүүлж болохыг нарийвчлан шинжилсэн байна.

“Хүүхдийн эрх ашиг нэн тэргүүнд байх” зарчмын тухайд Alston, Tobin, Zermatten зэрэг эрдэмтэд уг зарчим нь нэг удаагийн тунхаглал бус, хүүхэдтэй холбоотой аливаа шийдвэр гаргахдаа заавал баримтлах ёстой эрх зүйн стандарт гэж үздэг. Эдгээр судалгаанд хүүхдийн ашиг сонирхлыг үнэлэхдээ хүүхдийн нас, хөгжлийн түвшин, гэр бүлийн орчин, хүчирхийлэл эсхүл үл хайхрах байдал байгаа эсэх, түүнчлэн хүүхдийн урт

хугацааны хөгжлийн боломж зэрэг олон хүчин зүйлийг системтэйгээр харгалзан үзэх шаардлагатайг онцолдог.

Ерөнхийд нь авч үзвэл, олон улсын түвшний онол, судалгаанд хүүхдийн эрх зүйн байдлыг эрхийн субъект гэж ойлгох, “хүүхдийн эрх ашиг нэн тэргүүнд байх” зарчмыг шүүхийн шийдвэр гаргах үеийн бодит шалгуур, хэрэглээ болгон хэрэгжүүлэх хандлага давамгайлж байна.

Хүүхэдтэй уулзах эрхийн харьцуулсан судалгаа: Европ болон Хойд Америкийн улс орнуудын жишээн дээр Brinig, Parkinson, Eekelaar зэрэг судлаачид тусдаа амьдарч буй эцэг, эхийн хүүхэдтэйгээ уулзах эрхийн эрх зүйн шинж чанар, хүүхдийн эрх болон эцэг, эхийн эрхийн хоорондын тэнцвэрт байдлыг гүнзгийрүүлэн судалсан байна. Зарим эрдэмтэд уулзах эрхийг эцэг, эхийн “хувийн эрх” (substantive right) гэхээс илүүтэйгээр, хүүхдийн “эцэг, эхтэйгээ харилцаагаа хадгалах бодит эрх”-ийн салшгүй нэг хэсэг гэж үзэх хандлагыг дэвшүүлдэг.

Англи-Америкийн эрх зүйн уламжлал дахь “хамтарсан асран хамгаалалт” (joint custody), Хойд Европын “хамтран хүүхэд асрах” (shared parenting) зэрэг загварыг харьцуулсан судалгаанд дараах асуудлуудыг нарийвчлан авч үзсэн байдаг. Үүнд:

- хамтарсан асран хамгаалалтын хүрээнд уулзалтын эрхийг хэрхэн тодорхойлдог;
- шүүх уулзалтын журам, хуваарийг тогтоохдоо ямар шалгуур хэрэглэдэг;
- ямар нөхцөлд уулзалтыг хязгаарлах, түр зогсоох боломжтой;
- шүүхийн шийдвэр гаргах явцад хүүхдийн санал бодлыг хэрхэн тусгадаг зэргийг нарийвчлан авч үзсэн байдаг.

Эдгээр судалгаануудын дүгнэлтээс үзэхэд хүүхэдтэй уулзах эрхийг хүүхдийн урт хугацааны хөгжил, сэтгэл зүйн аюулгүй байдал, эцэг, эхийн хамтын хариуцлагатай нягт уялдуулан авч үзэх шаардлагатайг харуулж байна. Мөн эцэг, эхийн хоорондын хувийн зөрчлийг хүүхдийн эрхээр “манипуляци хийх” замаар шууд бус хэлбэрийн дарамт, ашиг сонирхлын зөрчил болгож хувиргах явдлаас тууштай зайлсхийх ёстойг онцгойлон анхааруулдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн механизмын судалгаа: Choudhry, Jänterä-Jareborg, Kruger зэрэг эрдэмтэд хүүхэдтэй уулзах эрхийн талаарх шүүхийн шийдвэрт “эрхийг тунхаглах” болон “эрхийг бодитоор хэрэгжүүлэх” хоёрын хооронд үүсдэг зөрчил, практик заагийг судалгааны гол объект болгон авч үзсэн байна. Тэдний судалгааны үр дүнгээс үзэхэд:

1. Шүүхээс хүүхэдтэй уулзах эрхийг баталгаажуулсан шийдвэр гаргасан хэдий ч тодорхой, үр нөлөөтэй шийдвэр гүйцэтгэлийн механизм байхгүй тохиолдолд тухайн эрх бодит амьдрал дээр хэрэгжихгүй байх, эсхүл зөрчигдөх өндөр эрсдэлтэй байдаг;
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн үр нөлөөт байдлыг хангахын тулд дэмжих шинжтэй зөөлөн арга хэмжээ (сэтгэл зүйн зөвлөгөө, эвлэрүүлэн зуучлал) болон хууль зүйн албадлагын арга хэмжээг (торгууль ногдуулах, шүүхийг үл хүндэтгэхэд хүлээлгэх хариуцлага гэх мэт) зохистой бөгөөд уян хатан хослуулах шаардлагатай;

3. Хүүхдийн эрхийн онол, шүүхийн практик болон нийгмийн дэмжлэгийн нэгдсэн тогтолцооны хоорондын уялдаа холбоо сул байвал хүүхэдтэй уулзах эрх нь амьдрал дээр амархан “цаасан дээрх эрх” төдий байдлаар үлдэх магадлалтай.

Иймээс олон улсын судалгааны чиг хандлагад хүүхэдтэй уулзах эрхийн асуудлыг зөвхөн хууль зүйн тунхаглалын түвшинд явцуу хүрээнд бус, харин шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа, институцийн бодит үйл ажиллагааны механизмаар дамжуулан цогц байдлаар судлах шинэ хандлага төлөвшиж байна.

БНХАУ-ын судалгааны байдал:

Гэр бүлийн эрх зүйн хөгжлийн судалгаа: БНХАУ-ын гэр бүлийн эрх зүйн судалгаанд (жишээлбэл, Sunguohua, Mayinan, Yanglixin гэх мэт) эрдэмтэд уламжлалт Конфуци гэр бүлийн загвараас эхлэн социалист үеийн “төрийн хамгаалалт дор буй гэр бүл”, зах зээлжсэн үеийн “гэрээт шинжтэй гэр бүл”, орчин үеийн “хүүхдийн эрхийг төвд тавьсан гэр бүл” рүү шилжсэн үйл явцыг тайлбарласан байдаг. Эдгээр судалгаанд 1950, 1980 оны “Гэрлэлтийн тухай хууль” болон 2020 оны “Иргэний хууль”-ийн холбогдох зохицуулалтыг харьцуулан үзэж, гэрлэлт цуцлалт, асран хамгаалалт, хүүхдийн эрхийг хамгаалах талаарх үзэл баримтлал, институцийн өөрчлөлтийг системтэйгээр шинжилсэн байна.

Гэр бүлийн хэрэг, хүүхдийн эрхийн шүүхийн практикийн судалгаа: БНХАУ -ын гэр бүлийн шүүх, гэр бүлийн танхимын хөгжилтэй холбоотойгоор Nehongfeng, Lijie зэрэг эрдэмтэд гэр бүлийн хэрэгт хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдэд ээлтэй шүүхийн орчныг бүрдүүлэхийн ач холбогдлыг онцолжээ. Эдгээр судалгаанд хүүхдийн санал бодлыг сонсох тусгай журам, шүүх хуралдааныг хаалттай явуулах зохицуулалт, сэтгэл зүйн мэргэжилтэн болон нийгмийн ажилтны оролцоо, шүүхийн гаднах эвлэрүүлэн зуучлалын механизмын үйл ажиллагааг судалж, эдгээр механизмууд шүүхийн практикт хэрхэн хэрэгжиж буйг шинжилсэн байдаг.

Уулзалтын эрхийн онол ба гүйцэтгэлийн хүндрэл: Сүүлийн жилүүдэд Бүгд Найрамдах Хятад Ард Улсад хүүхэдтэй уулзалтын эрх (探望权)-ийн талаархи тусгай судалгаа олширсон. Zhaojin, Chenwei зэрэг судлаачид “Иргэний хууль”-ийн хүүхэдтэй уулзах эрхийн холбогдох заалт, үзэл баримтлалыг түшиглэн, шүүхийн шийдвэр гаргах үйл ажиллагаа болон шийдвэр гүйцэтгэлийн практикт тулгарч буй гол бэрхшээлүүдийг эмпирик болон туршилт-судалгааны (эмпирик шинжилгээ) үндсэн дээр нарийвчлан шинжилсэн байдаг.

Тухайлбал, тэд уулзалтын эрхийг албадан гүйцэтгүүлэх асуудлын хүрээнд хүүхэдтэй хамт амьдарч буй талын "хяналтын давуу байдал", нөгөө эцэг/эхтэй нь уулзуулахгүй байх санаатай үйлдэл, хүүхдийн "уулзахыг хүсэхгүй байна" гэх илэрхийллийг шүүхээс хэрхэн үнэлж буйг голчлон авч үзжээ. Мөн торгууль оногдуулах, "найдваргүй гүйцэтгэгчийн жагсаалт"-д бүртгэх зэрэг албадлагын арга хэмжээний үр нөлөө, үүнээс үүдэн гарах эрсдэлийг тусгайлан шинжилсэн байна.

Түүнчлэн, “Иргэний хууль”-ийн түвшинд уулзалтын эрхийн агуулга, хязгаарлалт, эрхийг сэргээх тухай нарийвчилсан зохицуулалт тусгагдсан хэдий ч бодит хэрэгжилтийн явцад нийгмийн дэмжлэг хангалтгүй, мэргэшсэн үйлчилгээ дутмаг, бүс нутгийн ялгаа их, албадлагын арга хэмжээний сөрөг нөлөө зэрэг тулгамдсан асуудлууд хэвээр байгааг судлаачид онцолдог.

Үүнтэй холбогдуулан Бүгд Найрамдах Хятад Ард Улс судалгаанд уулзалтын эрхийг гурван түвшинд зэрэг авч үзэх хандлага төлөвшиж байна. Үүнд:

1. **Онолын түвшинд:** хүүхдийн эрх ба эцэг, эхийн эрхийн харилцаа,
2. **Хууль зүйн түвшинд:** “Иргэний хууль”-ийн тодорхой зохицуулалт,
3. **Практикийн түвшинд:** Шүүхийн шийдвэр, шийдвэр гүйцэтгэл, нийгмийн дэмжлэгийн тогтолцоо шинжилгээ хийх,

БНХАУ-ын эрдэмтдийн судалгаа нь уулзалтын эрхийн хэрэгжилтэд тулгарч буй практик хүндрэлийг ийнхүү онол, хууль эрх зүй болон нийгмийн хамгааллын системтэй нь уялдуулан, олон талт өнцгөөс цогцоор нь шинжилснээрээ онцлогтой байна.

Монгол Улсын судалгааны байдал:

Гэр бүлийн эрх зүйн судалгаа: Монгол Улсад “Гэр бүлийн тухай хууль”-ийн түүхэн хөгжил, гэрлэлтийн харилцаа, гэрлэлт цуцлалт болон гэр бүлийн эрх зүйн ерөнхий зарчмуудын талаар судалсан бүтээлүүд цөөнгүй бий. Эдгээр судалгаанд ихэвчлэн зах зээлийн эдийн засагт шилжсэн үйл явц нь гэр бүлийн бүтэц, зохион байгуулалтад хэрхэн нөлөөлсөн, гэрлэлт цуцлалт болон өрх толгойлсон эцэг, эхийн тоо өссөн шалтгаан, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд хамгааллын тулгамдсан асуудлуудыг голчлон авч үзсэн байдаг.

Гэвч эдгээр судалгаанд гэрлэлт цуцлах маргааны дараах хүүхэдтэй уулзах эрхийг бие даасан эрх зүйн институт болгон системтэй судалсан бүтээл цөөн байна. Ихэнх судалгаанд уулзалтын асуудлыг асран хамгаалалт, хүүхдийн тэтгэлэг эсвэл гэр бүлийн хүчирхийллийн өргөн хүрээний сэдвийн дунд "уулзах боломж" гэх ерөнхий түвшинд товч дурдаад өнгөрөх хандлага ажиглагддаг.

Хүүхэд хамгаалал ба хүүхдийн эрхийн судалгаа: Монгол Улсад хүүхэд хамгааллын чиглэлээр хийгдсэн судалгаанууд нь ихэвчлэн хүүхдийн эрхийг эрх зүйн хувьд хамгаалах, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, үл хайхрах байдал болон онцгой хамгаалалт шаардлагатай бүлгүүдэд (тухайлбал, эцэг, эх нь гадаадад хөдөлмөр эрхэлдэг хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд г.м) төвлөрдөг. Эдгээр судалгаанд “Хүүхдийн эрхийн конвенц” болон үндэсний хууль тогтоомжийн уялдаа холбоо, бодлого хэрэгжилтийн сул талыг шинжилж, хүүхэд хамгааллын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах саналуудыг дэвшүүлсэн байдаг.

Гэвч гэрлэлт цуцлах маргаан дахь хүүхдийн эрх, ялангуяа уулзалтын эрхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг судалгааны үндсэн сэдэв болгож, шүүхийн шийдвэр гүйцэтгэлд тулгарч буй практик бэрхшээлийг гүнзгийрүүлэн шинжилсэн дотоодын судалгаа дутмаг байна.

Монгол Улс ба БНХАУ-ын харьцуулсан эрх зүйн судалгааны орон зай: Одоогоор Монгол Улс болон БНХАУ-ын гэр бүлийн эрх зүй, хүүхдийн эрхийг хамгаалах тогтолцоог системтэйгээр харьцуулсан судалгаа маш ховор байна. Зарим өгүүлэл, эрдэм шинжилгээний хурлын илтгэлд БНХАУ-ын гэр бүлийн эрх зүйн хөгжлийг товч танилцуулсан байдаг ч уулзалтын эрхийн институтийг хоёр улсын шүүхийн практик, шийдвэр гүйцэтгэлийн механизм болон нийгэм-соёлын орчинтой нь уялдуулан гүнзгийрүүлэн харьцуулсан судалгаа хараахан хийгдээгүй байна.

Түүнчлэн Монгол улсад “эрх зүйн шилжилт” болон “эрх зүйн нутагшуулалт”-ын онолын үүднээс БНХАУ-ын туршлагыг Монгол Улсын хөрсөнд хэрхэн нутагшуулах, түүний зохист байдал, хязгаарлалт болон үүсэж болох эрсдэлийг системтэйгээр үнэлсэн судалгаа дутмаг байна. Энэ нь гэр бүл болон хүүхдийн эрхийн салбарт бүс нутгийн хэмжээнд харьцуулсан эрх зүйн судалгаа хангалтгүй байгааг илтгэх бөгөөд цаашид үүнийг өргөжүүлэх практик шаардлага байгааг харуулж байна.

Судалгааны дутагдал ба энэхүү сэдвийн шинэлэг тал

Дээрх судалгааны тоймоос үзвэл хууль зүйн шинжлэх ухааны салбарт дараах гол чиглэлүүдээр судалгааны хоосон орон зай байна гэж дүгнэж байна. Үүнд:

- **Дотоодын судалгааны нэгдмэл байдал алдагдсан:** Монгол Улсад хүүхэдтэй уулзах эрхийг бие даасан эрх зүйн институт гэхээсээ илүү “уулзах боломж” гэсэн ерөнхий түвшинд хязгаарлан авч үздэг. Түүнчлэн эрх зүйн зохицуулалт, шүүхийн практик, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа болон нийгмийн дэмжлэгийн тогтолцооны харилцан уялдааг цогцоор нь шинжилсэн системтэй судалгаа дутмаг байна.
- **Харьцуулсан судалгааны хоосон орон зай:** Монгол Улс болон БНХАУ нь социалист уламжлал, зах зээлийн эдийн засагт шилжсэн түүхэн туршлага, Зүүн Азийн соёлын суурь зэрэг олон талын ижил төстэй талтай боловч гэрлэлт цуцлах маргаан дахь уулзалтын эрхийн бодит хэрэгжилтийг харьцуулан судалсан бүтээл одоогоор байхгүй байна.
- **Нутагшуулах онолын үүднээс үнэлээгүй байдал:** БНХАУ-ын “Иргэний хууль”-д туссан уулзалтын эрхийн зохицуулалтыг Монгол Улсын практикт шүүлтүүргүйгээр шууд хуулбарлах нь дасан зохицох асуудал үүсгэх эрсдэлтэй. Гадаад улсын хууль тогтоомжийн ямар элементүүдийг Монгол Улсад нэвтрүүлэхэд зохистой, аль нь эрсдэл дагуулахыг эрх зүйн нутагшуулалтын онолын үүднээс шинжилсэн судалгаа хараахан хийгдээгүй байна.

Эдгээр судлагдаагүй орон зайд тулгуурлан энэхүү магистрын судалгааны ажлын шинэлэг талуудыг дараах байдлаар **тодорхойлогдоно:**

- **Судалгааны объектын шинэлэг байдал:** Монгол Улсад гэрлэлт цуцлах маргаан дахь хүүхдийн уулзалтын эрхийг судалгааны төвд тавьж, хүчин төгөлдөр хууль тогтоомж, шүүхийн практик, шийдвэр гүйцэтгэлийн бэрхшээлийг анх удаа системтэйгээр нэгтгэн шинжилж буй явдал юм.

- **Олон түвшний харьцуулсан дүн шинжилгээ:** Хуулийн текст, шүүхийн практик, нийгэм-соёлын орчин гэсэн гурван түвшинд Монгол Улс болон БНХАУ-ын уулзалтын эрхийн тогтолцоог харьцуулан судалж, зөвхөн хуулийн заалтыг бус, бодит хэрэгжилтийн байдлыг хамтад нь шинжилсэн болно.
- **Онол-практикийн шинэ хандлага:** “Эрх зүйн шилжилт”, “эрх зүйн нутагшуулалт”-ын онолыг ашиглан БНХАУ-ын уулзалтын эрхийн институтийн ололттой талуудаас Монгол Улсад нутагшуулахад тохиромжтой хэсэг болон түүний хязгаарлалт, эрсдэлийг онолын болон практикийн түвшинд тодорхой тусгаарласан.
- **Хэрэгжихүйц зөвлөмж, үр дүн:** Судалгааны үр дүнд үндэслэн Монгол Улсад хүүхдийн уулзалтын эрхийг хамгаалах эрх зүйн орчныг шинэчлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн үр нөлөөг нэмэгдүүлэх, нийгмийн дэмжлэгийн тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн тодорхой, хэрэгжихүйц бодлогын болон хууль зүйн саналыг дэвшүүлсэн.

Иймд энэхүү судалгаа нь Монгол Улсад уулзалтын эрхийн тогтолцоог бодит хэрэгцээнд нь нийцүүлэн шинэчлэхэд онол болон практикийн дэмжлэг үзүүлэхийг зорихын зэрэгцээ бүс нутгийн түвшинд хийгдэх харьцуулсан эрх зүй, хүүхдийн эрхийн судалгаанд жишээ болгон ашиглаж болохуйц шинжлэх ухааны ач холбогдолтой болно.

БҮЛЭГ 1. ОНОЛЫН ТОЙМ

1.1 Хүүхдийн эрхийг хамгаалах онолын үндэс

1.1.1 Хүүхдийн эрхийн эрх зүйн онолын хөгжил

Орчин үеийн хүүхдийн эрхийн онол нь хүний эрхийн нийтлэг үзэл баримтлалын нэг хэсэг боловч түүхэн үүсэл, хөгжлийн хувьд өөрийн гэсэн онцлогтой. Уламжлалт эрх зүйн тогтолцоонд хүүхдийг ихэвчлэн насанд хүрсэн хүний өмч, гэр бүлийн гишүүний хувьд гэр бүл, эцэг, эхийн эрх мэдлийн объект болгон хардаг байсан. Роман-германы болон Англи-Саксоны эрх зүйн уламжлалд хүүхэд нь “асрамж, хамгаалалт шаардсан сул талтай этгээд” буюу хамгаалалтын объект гэж ойлгогдож, эцэг, эхийн “эрх” давамгайл байр суурь эзэлж байв.

XX зууны дунд үеэс хүний эрхийн тухай ойлголт гүнзгийрч, нийгэм-улс төрийн асар том өөрчлөлтийн нөлөөгөөр хүүхдийн статусын талаарх хандлага аажмаар өөрчлөгдөж эхэлсэн. Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 1959 онд баталсан “Хүүхдийн эрхийн тунхаг”, 1989 онд баталсан “Хүүхдийн эрхийн тухай конвенц” нь хүүхдийг анх удаа дэлхийн түвшинд бие даасан эрхийн субъект хэмээн тодорхойлж, тэдэнд хамаарах эрхийн иж бүрэн багцыг хууль зүйн хувьд баталгаажуулсан чухал эргэлтийн үе байв.

Энэхүү конвенцын гол онцлог нь хүүхдийн эрхийг зөвхөн хамгаалалтын эрх (амьд явах, эрүүл мэнд, хамгаалалт, халамж авах гэх мэт)-ээр хязгаарлахгүй, мөн иргэний-улс төрийн эрх (санал бодлоо илэрхийлэх, асуултад хариулахдаа чөлөөтэй байх, итгэл үнэмшил, шашин шүтэх эрх гэх мэт) болон оролцооны эрх (өөрт нь хамааралтай шийдвэр гаргах үед нас, хөгжлийн түвшинд нь тохирсон хэмжээнд оролцох эрх)-ийг хүлээн зөвшөөрсөн явдал юм. Энэ утгаараа хүүхэд нь хамгаалал авах “объект” төдийгүй өөрийн эрх, сонирхол, санал бодол бүхий “субъект” болохыг онцлон тэмдэглэсэн.

Эрхийн субъект гэсэн ойлголт хөгжихийн хэрээр хүүхдийн эрх, эцэг, эхийн эрх, төрийн үүргийн хоорондын харилцааг шинээр тайлбарлах шаардлага үүссэн. Орчин үеийн онолд “гурван өнцөгт” загвар түгээмэл хэрэглэгддэг бөгөөд үүнд: (1) хүүхэд – эрхийн субъект; (2) эцэг, эх – хүүхдийн өмнө хүлээсэн үндсэн үүрэг, хариуцлага бүхий этгээд; (3) төр – хүүхдийн эрхийг хамгаалах эцсийн хяналт, баталгаа хэрэгжүүлэгч субъект хэмээн тодорхойлдог. Ийнхүү хүүхдийн эрхийг хамгаалах асуудал нь зөвхөн гэр бүлийн дотоод хэрэг бус, хүний эрхийн олон улсын хамгаалалтын тогтолцооны нэг хэсэг болж өргөжсөн.

1.1.2 “Хүүхдийн эрх ашиг нэн тэргүүнд байх” зарчмын онол

“Хүүхдийн эрх ашиг нэн тэргүүн” (best interests of the child) зарчим нь “Хүүхдийн эрхийн тухай конвенц”-ийн 3 дугаар зүйлийн төв агуулга бөгөөд хүүхэдтэй холбоотой аливаа шийдвэр, арга хэмжээ бүрт заавал баримтлах үндсэн зарчим гэж үздэг. Уг зарчмын утгыг задлан шинжлэхэд дараах зүйлс илэрхийлэгдэнэ: 1, уг зарчим нь үнэлэмжийн шинжтэй удирдах зарчим юм. Хүүхдийн эрх ашиг гэж юу болох, түүнийг хэрхэн үнэлэх вэ гэдэг нь нийтлэг, механик шалгуур биш бөгөөд тухайн хүүхдийн нас, хөгжлийн түвшин, гэр бүлийн нөхцөл, соёлын орчин, сэтгэлзүйн байдал болон ирээдүйн хөгжлийн боломж зэрэг олон хүчин зүйлээс хамаарна. Тиймээс “хүүхдийн эрх ашиг нэн

тэргүүн” нь нэг тогтсон хариу биш, харин тухайн хэрэг бүрт хүүхдийн бодит эрх ашигт хамгийн нийцэх шийдвэрийг эрэлхийлэх үйл явц юм. 2. Энэхүү зарчмыг хууль зүйн шинжтэй, заавал баримтлах шалгуур гэж онцолж үзэх нь чухал. Олон улсын болон үндэсний шүүхийн практикт маргаан, асран хамгаалал болон уулзалтын эрхийн маргааныг шийдвэрлэхэд шүүх “хүүхдийн эрх ашигт нийцэж байгаа эсэх”-ийг заавал шалгаж үзэх ёстой гэж тооцогддог. Энэ нь шүүх шийдвэрийн үндэслэлдээ хүүхдийн насыг, эрүүл мэндийг, сэтгэлзүйн байдлыг, гэр бүлийн орчныг, харилцааны чанарыг, хүчирхийлэл эсвэл үл хайхрах байдал байгаа эсэхийг, мөн ирээдүйн хөгжлийн боломжийг үнэлж дүгнэн тэдгээрийг бодитоор тайлбарлан тусгах үүрэгтэйг илэрхийлнэ. 3. Уг зарчим нь бусад эрх, зарчимтай харилцан уялдаатай байна. Жишээ нь, хүүхдийн санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, эцэг эхийн гэр бүл байгуулах, шийдвэр гаргах эрх болон гэр бүлийн амьдралд гадны оролцоог хязгаарлах зарчим зэрэг нь тодорхой хэмжээнд зөрчилдөж эсвэл давхцаж болно. Ийм нөхцөлд шүүх болон хууль хэрэгжүүлэгчид эдгээр эрх, зарчмын хооронд тэнцвэр олох, хүүхдийн эрх ашгийг бодитойгоор нэн тэргүүнд байршуулсан зохистой шийдлийг олох үүрэг хүлээнэ.

Маргаан, уулзалтын эрхийн хувьд “хүүхдийн эрх ашиг нэн тэргүүнд байх” зарчим нь хэд хэдэн түвшинд хэрэгжинэ. Нэгдүгээрт, асран хамгаалагчийг тогтоохдоо тухайн хүүхдийн аюулгүй байдал, тогтвортой байдал, сэтгэлзүйн дэмжлэг, боловсрол, эрүүл мэндийн хэрэгцээг иж бүрэн харгалзан үзэх. Хоёрдугаарт, уулзалтын эрхийн агуулга, давтамж, хэлбэрийг тогтоохдоо хүүхдийн нас, харилцааны чанар, сэтгэлзүйн байдал, зай газар, цаг хугацааны боломжийг үнэлэх. Гуравдугаарт, хүчирхийлэл, архидалт, асрал халамжийн ноцтой алдаа зэргээс хүүхдийг хамгаалах үүднээс уулзалтыг хязгаарлах, түр зогсоох, хяналттай уулзуулах зэргийг шийдэхдээ хүүхдийн урт хугацааны эрх ашгийг эрхэмлэх шаардлагатай.

1.1.3 Эцэг, эхийн хариуцлагын орчин үеийн өөрчлөлт

Эцэг, эхийн хүүхдийн өмнө хүлээх үүрэг, хариуцлагын тухай ойлголт нь хүүхдийн эрхийн онолын хөгжлийн нэгэн чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Уламжлалт гэр бүлийн эрх зүйд “эцэг, эхийн эрх” (parental authority) голчлон онцлогдож, хүүхдийн амьдралын гол шийдвэрүүдэд эцэг, эхийн нэг буюу хоёулангийнх нь эрх мэдэл давамгайлж байсан. Энэ загварт хүүхэд нь эцэг, эхийн “өмч”-ийн шинжтэй, гэр бүлийн шийдвэрт идэвхгүй байр суурь эзэлдэг.

Орчин үеийн хүүхдийн эрхийн онол, хүний эрхийн нийтлэг үзэл баримтлалын нөлөөгөөр энэхүү ойлголт аажмаар өөрчлөгдөж, “эцэг, эхийн эрх” гэсэн ойлголтыг “эцэг, эхийн хариуцлага” (parental responsibility) гэсэн ойлголтоор солих хандлага төлөвшсөн. Энэ нь эцэг, эх хүүхдийн өмнө тодорхой эрх эдэлдэг ч үүнээс илүүтэйгээр хүүхдийн амьдрал, хөгжил, хамгаалалт, боловсрол, сэтгэлзүйн сайн сайхан байдалд хариуцлага хүлээж байгааг онцолсон онолын шилжилт юм.

Энэхүү “хариуцлага” төвтэй загвар нь хэд хэдэн онцлогтой:

(1) Эцэг, эхийн үүрэг нь хүүхдийн ашиг сонирхолд чиглэнэ. Эцэг, эхийн шийдвэр гаргах эрх нь зорилго бус, харин хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахад үйлчлэх хэрэгсэл гэж үзнэ. Иймээс эцэг, эхийн хоорондын зөрчил, харилцааны асуудал илүү

давамгайлж, хүүхдийн эрх ашиг хоёрдогч байдалд орсон тохиолдолд төр, шүүх нь тодорхой хэмжээгээр оролцож, хүүхдийн эрхийг хамгаалах үүрэгтэй.

(2) Дараа ч эцэг, эхийн хариуцлага үргэлжилнэ. Хуучин загварт дараа хүүхдийг дангаар асран хамгаалж буй тал “үндсэн эцэг, эх” болж, нөгөө талын үүрэг тодорхойгүй, эсвэл зөвхөн тэтгэмж төлөгчийн дүрд шилжих хандлага байсан. Орчин үеийн загварт салалт нь зөвхөн эцэг, эх хоорондын гэр бүлийн эрх зүйн статуст өөрчлөлт оруулах бөгөөд хүүхдийн өмнө хүлээсэн хариуцлага, үүрэг хэвээр хадгалагдах ёстой гэж үздэг. Иймээс уулзалтын эрх нь зөвхөн “уулзах боломж” бус, эцэг, эхийн хүүхдийн өмнө хүлээсэн хариуцлагаа хэрэгжүүлэх нэг хэлбэр, мөн хүүхдийн эцэг, эхтэйгээ харилцаагаа хадгалах эрхийн чухал баталгаа болдог.

(3) Эцэг, эхийн хариуцлага нь “хамтын” шинжтэй. Орчин үеийн онолд “хамтарсан эцэг, эх” (co-parenting) гэсэн ойлголт түлхүү яригдах болсон бөгөөд энэ нь дараа ч эцэг, эх хүүхдийн хүмүүжил, боловсрол, асрамж, шийдвэр гаргалтад хамтран оролцох ёстой гэсэн агуулгатай. Энэ нь уулзалтын эрхийн зохицуулалтад шууд тусгалтай: уулзалтын давтамж, агуулга, хэлбэрийг тодорхойлохдоо зөвхөн эцэг, эхийн хоорондын зөрчлийг бус, хүүхдийн эрхийг нэгдүгээрт, хамтын хариуцлагын зарчмыг хоёрдугаарт тавих шаардлагатай болдог.

Ийнхүү хүүхдийн эрхийн онолын хөгжлийн хүрээнд хүүхдийн статусын тухай ойлголт, “хүүхдийн эрх ашиг нэн тэргүүнд байх” зарчим, эцэг, эхийн хариуцлагын загвар зэрэг суурь ойлголтууд өөрчлөгдөж, шинэчлэгдсэний үр дүнд маргаан, уулзалтын эрхийн эрх зүйн зохицуулалт, шүүхийн практикт шинэ шаардлага, шалгуур тавигдаж байна.

1.1.4 Хүүхдийн эрхийг хамгаалахад асран хамгааллын тогтолцооны чиг үүрэг

Асран хамгаалах үүрэг нь эцэг, эхийн хариуцлагыг эрх зүйн хэлбэрт оруулсны илрэл бөгөөд эцэг, эх нь насанд хүрээгүй хүүхдийнхээ аюулгүй байдал, сэтгэл зүйн эрүүл мэнд, боловсрол эзэмших, эд хөрөнгийн эрх ашгийг бүхэлд нь хамгаалах үндсэн үүрэг хүлээнэ. Мөн эцэг, эх нас нь барсан, сураггүй болсон, эрх зүйн чадамжгүй болсон, эсвэл асран хамгаалах үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд асран хамгаалах үүрэг нь ойрын хамаатан, төрийн болон төрийн бус байгууллагад шилждэг.

Асран хамгаалах үүрэг нь тэжээн тэтгэх, уулзалтын эрхээс ялгаатай атлаа тэдгээртэй нягт холбоотой: Тэжээн тэтгэх нь өдөр тутмын амьдрал, эдийн засгийн хангалтыг, уулзалтын эрх нь хамт амьдрахгүй эцэг, эхэд хүүхэдтэйгээ харилцаагаа хадгалах боломжийг тус тус баталгаажуулдаг бол асран хамгаалах эрх нь эдгээрийг багцлан насанд хүрээгүй хүүхдийн нийтлэг ашиг сонирхлыг төлөөлөх, хамгаалах дээд түвшний хууль зүйн хүрээг тогтоодог.

1.2 Уулзалтын эрхийн эрх зүйн шинжилгээ

1.2.1 Хүүхдийн асрамж хамгаалалт болон тэжээн тэтгэлгийн онолын үндэс

Гэрлэлт цуцлах маргааны явцад хүүхдийн эрх ашгийг хамгаалах асуудал нь зөвхөн уулзалтын эрхээр хязгаарлагдахгүй бөгөөд үүний салшгүй хэсэг нь хүүхдийн асрамж хамгаалалт (Custody) болон тэжээн тэтгэлгийн (Child support) институтууд юм.

Онолын хувьд асрамж хамгаалалт нь хүүхдийн өдөр тутмын амьдралыг зохион байгуулах, түүний хөгжил, хүмүүжил, эрүүл мэндэд хяналт тавих хууль зүйн болон бодит хариуцлагын нэгдэл гэж тодорхойлогддог.

Орчин үеийн гэр бүлийн эрх зүйн онолд “хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих” зарчмын дагуу асрамж хамгаалалтыг тогтоохдоо эцэг, эхийн эрхээс илүүтэйгээр хүүхдийн сэтгэл зүйн тогтвортой байдал, амьдрах орчны аюулгүй байдлыг чухалчилдаг болсон. Хүүхдийн асрамжийг хүлээж аваагүй талын хувьд хүүхдээ тэжээн тэтгэх үүрэг нь хүүхдийн амьд явах, өсөж төлөвших суурь эрхийг эдийн засгийн хувьд баталгаажуулах үндсэн механизм болдог.

Тэжээн тэтгэлэг нь зөвхөн мөнгөн хөрөнгийн тусламж бус, харин эцэг, эх салснаас үл хамааран хүүхдийн өмнө хүлээх хариуцлага хэвээр хадгалагдаж буйн илрэл юм. Тиймээс асрамж, тэжээн тэтгэлэг болон уулзалтын эрх нь хоорондоо нягт уялдаатай “хүүхэд хамгааллын цогц систем”-ийг бүрдүүлдэг бөгөөд эдгээр институтуудыг нэгдмэл байдлаар авч үзэх нь хүүхдийн эрхийн хамгаалалтыг бодит амьдрал дээр хэрэгжүүлэх онолын гол үндэслэл болно.

1.2.2 Хүүхдийн тэтгэлэг тогтоох шалгуур болон бүс нутгийн ялгаатай байдал: Монгол ба БНХАУ-ын харьцуулалт

Гэрлэлт цуцлах маргааны “хүүхэд хамгааллын цогц систем”-д хүүхдийн тэтгэлгийг тогтоох асуудал нь насанд хүрээгүй хүүхэд эцэг, эх нь салснаас хойш хэвийн амьдрах, сурч боловсрох, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх баталгаа болдог. Тэтгэлэг тооцох шалгуурыг хууль тогтоомжид шинжлэх ухааны үндэслэлтэй хэрхэн тусгах, ингэхдээ нэг талаас хүүхдийг эцэг, эхийн гэрлэлт цуцлагдсанаас үүдэн амьдралын доройтолд орохоос хамгаалах, нөгөө талаас тэтгэлэг төлөх үүрэг бүхий этгээдийн эдийн засгийн чадавх, ачааллыг тэнцвэржүүлэх нь гэр бүлийн эрх зүйн харилцааны шийдвэрлэх нэг асуудал болно.

Дэлхийн улс орнууд хүүхдийн тэтгэлгийн хэмжээг тогтоохдоо хүүхдийн бодит хэрэгцээ болон эцэг, эхийн төлбөрийн чадварыг голлон харгалздаг. Гэвч хууль зүйн зохицуулалтын нарийвчилсан бүтэц, хамгаалалтын доод хязгаар болон макро эдийн засгийн тэгш бус хөгжлөөс шалтгаалсан “бүс нутгийн ялгаатай байдал”-ыг эрх зүйн хэм хэмжээнд хэрхэн тусгах тухайд Монгол Улс болон БНХАУ нь үзэл баримтлал, хууль зүйн зохицуулалтын хувьд эрс өөр чиглэлтэй баримталж байна.

1.2.2.1 Монгол Улсын хүүхдийн тэтгэлэг тогтоох шалгуур: Бүс нутгийн амжиргааны доод түвшинд суурилсан хатуу загвар

Монгол Улсын өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Гэр бүлийн тухай хуулийн хүрээнд хүүхдийн тэтгэлгийг тогтоохдоо хүүхдийн “насны зааг” болон тухайн орон нутгийн “амжиргааны доод түвшин”-гийн хувь хэмжээг хослуулсан хатуу стандартыг баримталдаг. Энэхүү зохицуулалтын онолын гол онцлог нь шүүгчийн үзэмжээр шийдвэрлэх эрх мэдлийг хуулиар хатуу хязгаарлаж, төрөөс тогтоосон макро эдийн засгийн үзүүлэлтээр дамжуулан насанд хүрээгүй хүүхдийн амьд явах, амьдрах наад захын баталгааг хамгаалахад оршдог.

Хуулийн дагуу хүүхдийн тэтгэлгийн хэмжээг насны заагаар дараах хоёр үндсэн хязгаараар тогтоож байна. Үүнд:

- Хүүхдийн нас 11 хүртэлх бол тухайн бүс нутагт тогтоогдсон хүн амын амжиргааны доод түвшний 50 хувиар;

- Хүүхдийн нас 11-16 (сургуульд суралцаж байгаа бол 18 нас) хүртэлх бол тухайн бүс нутгийн амжиргааны доод түвшний 100 хувиар тус тус тооцон доод хязгаарыг хуульчилсан.

Энэхүү тогтолцоонд макро эдийн засгийн “бүс нутгийн ялгаатай байдал” нь шүүхийн практикт тэтгэлгийн хэмжээг тодорхойлох хамгийн гол хууль зүйн хувьсах хэмжигдэхүүн болдог. Монгол Улсын бүс нутгуудын дэд бүтцийн хөгжил, үйлдвэржилт, худалдааны эргэлт болон мал аж ахуйн эдийн засгийн эзлэх хувь хэмжээ тэгш бус байдгаас шалтгаалан нийслэл Улаанбаатар хотын бараа бүтээгдэхүүний үнэ, хэрэглээний бүтэц, амьжиргааны өртөг болон нэг хүнд ногдох орлого нь төвийн болон баруун бүсийн алслагдсан аймгуудаас харьцангуй өндөр байдаг.

Үүнийг эрх зүйн зохицуулалтад бодитой тусгахын тулд Монгол Улсын Үндэсний статистикийн хорооноос улс орны бүс нутгуудын “Хүн амын амжиргааны доод түвшин”-г жил бүр шинэчлэн тогтоож, нийтэд зарладаг. Шүүхийн практикт үүнээс шалтгаалан гэр бүлийн орчин, эцэг эхийн орлогын хэмжээ яг адилхан байлаа ч хүүхдийн оршин суугаа газар нутгаас хамааран (жишээ нь нэг хүүхэд Улаанбаатар хотод, нөгөө хүүхэд хөдөө орон нутагт амьдардаг бол) шүүхээс тогтоож буй хүүхдийн тэтгэлгийн туйлын мөнгөн дүн нь бүс нутгийн ялгаатайгаар тогтоогддог. Хэдийгээр хуульд тэтгэлэг төлөгч нь цалин хөлстэй бол түүний тодорхой хувиар тогтоож болно гэж заасан ч практикт тэтгэлэг төлөгчийн бодит орлого хэдий чинээ бага байхаас үл хамааран Статистикийн хорооноос тогтоосон тухайн бүс нутгийн амжиргааны доод түвшний хувь хэмжээнээс доогуур тогтоож хэрхэвч болдоггүй. Энэхүү “нийгмийн хамгаалал, халамжийн” болон “хатуу” шинж чанар нь Монгол Улсын хүүхдийн тэтгэлгийн тогтолцооны онолын суурь болж байна.

1.2.2.2 БНХАУ-ын хүүхдийн тэтгэлэг тогтоох шалгуур: Орлогын хувь хэмжээ болон орон нутгийн түвшинд суурилсан уян хатан механизм

Монгол Улсын амжиргааны доод түвшинтэй шууд баригддаг хатуу загвартай харьцуулахад БНХАУ-ын эрх зүйн зохицуулалт нь хүүхдийн тэтгэлгийг тооцохдоо “эцэг эхийн бодит төлбөрийн чадвар” болон “хүүхдийн бодит хэрэгцээ”-ний тэнцвэрт байдлыг илүү харгалзсан уян хатан шинж чанартай байдаг.

БНХАУ-ын Иргэний хуулийн 1085 дугаар зүйл болон түүнд холбогдох Дээд шүүхийн тайлбарт зааснаар, Хятадын шүүх хүүхдийн тэтгэлгийг шийдвэрлэхдээ улс даяар мөрдөх хатуу мөнгөн дүн заагаагүй бөгөөд тэтгэлэг төлөгчийн цалин орлогод суурилсан хувь хэмжээг тогтоож, шүүгчид өргөн хүрээний эрх олгосон байдаг. Тухайлбал,

- Тогтмол орлоготой тэтгэлэг төлөгчийн хувьд хүүхдийн тэтгэлгийн хэмжээг түүний сарын нийт орлогын 20-30 хувиар тогтооно. Хэрэв хоёр болон түүнээс дээш хүүхдэд тэтгэлэг төлөх бол хувь хэмжээг нэмэгдүүлж болох ч, сарын нийт орлогын 50 хувиас хэтэрч болохгүй гэсэн дээд хязгаартай.
- Тогтмол бус орлоготой иргэдийн хувьд тухайн жилийн нийт орлого эсвэл тухайн салбарын дундаж орлогыг жишиг болгон дээрх 20-30 хувиар тооцдог байна.

БНХАУ-ын хууль тогтоомж нь “бүс нутгийн ялгаатай байдал”-ыг үндэсний хэмжээний хуулийн заалтад хатуу тоогоор тусгадаггүй бөгөөд үүний оронд тухайн муж, хотуудын статистикийн байгууллагаас гаргадаг “Орон нутгийн амьдралын бодит түвшин” болон “хүүхдийн бодит хэрэгцээ” гэсэн хоёр шалгуурт шингээж өгсөн байдаг. Хятадын муж, шууд харьяа хотуудын шүүх, статистикийн байгууллагууд жил бүр хот, хөдөөгийн оршин суугчдын нэг хүнд ногдох дундаж орлого, хэрэглээний зардлыг шинэчлэн

тогтоодог. Шүүгч хэрэг маргааныг шийдвэрлэхдээ Шанхай, Бээжин зэрэг хөгжингүй мега хотуудын амьжиргааны өртөг болон баруун бүсийн хөгжил буурай тосгоны амьдралын өртгийн зөрүүг шүүгчийн үзэмжийн хүрээнд харгалзан үздэг. Хятадын загвар нь бүс нутгийн ялгааг хуулиар тогтоосон орлогын хувь хэмжээний дотор, эцэг эхийн хөрөнгө чинээ, тухайн бүс нутгийн хэрэглээний онцлогтой уялдуулан шүүгч тухайн тодорхой хэрэг маргаан бүр дээр уян хатан зохицуулах боломжийг олгодог байна.

1.2.2.3 Тэтгэлэг тогтоох хэм хэмжээний ялгаатай байдалд хийсэн хууль зүйн дүгнэлт ба практик тулгамдсан асуудал

Монгол Улс болон БНХАУ-ын хүүхдийн тэтгэлгийг тогтоох болон бүс нутгийн ялгааг шийдвэрлэж буй загварыг харьцуулан шинжлэхэд хоёр улсын эрх зүйн чиг хандлага өөрийн гэсэн онолын үндэслэлтэй хэдий ч практик дээр дараах зөрчил, тулгамдсан асуудлуудыг дагуулж байна.

Монгол Улсын хүүхдийн тэтгэлгийг бүс нутгийн амьжиргааны доод түвшинтэй хатуу уялдуулсан систем нь тодорхой шинж чанартай бөгөөд улс орны хэмжээнд эмзэг бүлгийн болон салсан гэр бүлийн хүүхдүүдийн амьжиргааны баталгаажих түвшингийн доод хэмжээг баталгаажуулж өгдөг давуу талтай. Гэвч энэхүү хатуу зохицуулалт нь амьдрал дээр дараах хоёр том онол практикийн сөрөг үр дагаврыг бий болгож байна.

- Энэ нь өндөр орлоготой эцэг эхийн нийгмийн хариуцлагыг орхигдуулж, “Хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих” олон улсын эрх зүйн суурь зарчимтай зөрчилддөг. Улаанбаатар зэрэг томоохон хотуудад маш өндөр орлоготой, чинээлэг давхарга олноор бүрэлдсэн. Гэвч шүүх практикт хүүхдийн тэтгэлгийг тогтоохдоо хуулийн дагуу зөвхөн тухайн бүс нутгийн амьжиргааны доод түвшингийн 100 хувиар хязгаарлан тогтоох нь элбэг байдаг. Үүнээс шалтгаалан чинээлэг гэр бүлийн хүүхдүүд эцэг эхээ салсны дараа амьдралын чанар нь огцом буурч, эцэг эхийнхээ баялаг, өндөр орлогоос хүртэж чанартай боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ авах боломж нь хязгаарлагддаг байна. Энэ нь хууль зүйн үүднээс өндөр орлоготой эцэг эхийн тэтгэх үүргийг хөнгөлж буй хэлбэр юм.
- Энэхүү хатуу доод хязгаар нь практикт “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болон тэтгэлгийн өрийн дарамт” үүсэх гол шалтгаан болдог. Ажил орлогогүй, өвчтэй эсвэл мал аж ахуйн салбарт орлогоос тасарсан эмзэг бүлгийн тэтгэлэг төлөгчдөд хуулийн энэхүү хатуу шаардлага нь биелэгдэх боломжгүй эдийн засгийн дарамт болдог. Тэтгэлэг төлөгчийн бодит орлогод уян хатан зохицох зохицуулалт байхгүйгээс шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатанд асар их хэмжээний биелэгдээгүй хүүхдийн тэтгэлгийн өрийн үлдэгдэл хуримтлагддаг байна. Энэхүү бодит нөхцөл байдал нь цаашид манай судалгааны ажлын дараагийн бүлгүүдэд БНХАУ-ын хүүхдийн тэтгэлэг албадан гүйцэтгэх эрх зүйн хатуу хариуцлага, шийтгэлийн системийг Монгол Улсад нутагшуулах онолын гол үндэслэл, шалтгаан болж өгч байна.

1.2.3 Уулзалтын эрхийн ойлголт, эрх зүйн шинж чанар

Уулзалтын эрх (contact / access / visitation right) нь гэрлэлт цуцлагдсаны дараа хүүхэдтэй хамт амьдраагүй эцэг, эхтэйгээ биечлэн уулзах, харилцах, холбоо тогтоох харилцааг эрх зүйн хувьд баталгаажуулсан эрхийн нийлбэр гэж ойлгогдоно. Олон улсын эрх зүй, олон улсын хувийн эрх зүйн баримт бичигт уулзалтын эрхийг ихэвчлэн

хүүхдийн өөрийн эрхийн нэг хэсэг, түүнчлэн эцэг, эхийн “хүүхэдтэйгээ харилцаагаа хадгалах эрх”-ийн тусгал гэж үздэг.

Хүүхдийн эрхийн талаас нь авч үзвэл уулзалтын эрх нь хүүхдийн эцэг, эхтэйгээ харилцаагаа таслахгүй байх, гэр бүлийн холбоогоо хадгалах эрхийн нэг илрэл юм. “Хүүхдийн эрхийн тухай конвенц”-ийн 9, 10 дугаар зүйлд хүүхэд эцэг, эхээсээ салсан тохиолдолд тэдэнтэй байнгын холбоотой байх, тогтмол харилцах, уулзах боломжийг хангах ёстойг онцолсон байдаг.

Эцэг, эхийн талаас нь харвал уулзалтын эрх нь хамт амьдардаггүй талын хувьд хүүхдийн хүмүүжил, боловсрол, сэтгэлзүйн хөгжлийн явцад оролцох, мэдээлэл авах, хүүхдийн амьдралд оролцох эрх, үүргийг хэрэгжүүлэх боломж юм. Иймээс уулзалтын эрх нь зөвхөн “зочлох” төдий жирийн харилцаа бус, хүүхдийн эрх ба эцэг, эхийн хариуцлага хоёрыг холбосон эрх зүйн тогтолцоо гэж үзнэ.

Уулзалтын эрхийн агуулгад:

- Биечлэн уулзах (өөр дээр нь очих, хүүхдийг тодорхой хугацаагаар хамт байлгах),
 - Холбоо барих (утас, интернэт, цахим шуудан, бичсэн зурвас гэх мэтээр тогтмол харилцах),
- Гэр бүл, сургууль, эрүүл мэндийн үйлчилгээнд холбогдох мэдээлэл авах зэрэг орно.

Эдгээрийн тодорхой хэлбэр, давтамж, хугацаа нь тухайн улсын хууль тогтоомж, шүүхийн шийдвэр, талуудын тохиролцооноос хамааран тогтоогдоно.

Уулзалтын эрхийн талаарх онолын тодорхойлолтуудыг нэгтгэн дүгнэсний үндсэн дээр түүний эрх зүйн өвөрмөц шинж чанар болон нийгмийн үнэт зүйлийн үндсийг тодорхойлох боломжтой юм.

(1) Эрх зүйн шинж

Уулзалтын эрхийн эрх зүйн шинж чанар нь онолын түвшинд маргаантай асуудлын нэг боловч, дараах хэдэн онцлогтой.

Хүүхдийн өөрийн эрх (эцэг, эхтэйгээ харилцаагаа хадгалах, гэр бүлийн холбоогоо таслахгүй байх эрх) бол нөгөө талаар хүүхэдтэй хамт амьдардаггүй эцэг, эхийн хүүхэдтэйгээ уулзах, харилцах эрхийн илрэл юм. Тиймээс зарим эрдэмтэд үүнийг “хүүхдийн эрх давамгайлсан, эцэг эхийн эрх хосолсон эрх зүйн харилцаа” гэж тодорхойлдог.

Уулзалтын эрх нь хувийн эрхийн ангилалд хамаарна.

Ийм эрх нь шилжих боломжгүй, өвлөгдөхгүй, гуравдагч этгээдэд дамжуулж болохгүй бөгөөд тодорхой хүүхэд, тодорхой эцэг, эхийн хоорондын харилцаанд шууд холбогддог. Гэсэн хэдий ч уг эрхийг хэрэгжүүлэх явцад улс, шүүх, нийгмийн үйлчилгээний байгууллагууд тодорхой хэмжээгээр оролцож, хамгаалах, дэмжих үүрэг хүлээнэ.

Уулзалтын эрх нь хязгаарлагдаж болдог эрх юм.

Хүүхдийн эрх ашигт ноцтой хор уршиг учруулж болзошгүй нөхцөл байдалд (жишээлбэл гэр бүлийн хүчирхийлэл, бие махбодын болон сэтгэл зүйн хүнд хохирол, хар

тамхи хэрэглэх, архидалт, биеэ үнэлэлт зэрэг) шүүх тухайн эцэг, эхийн уулзалтын эрхийг тодорхой хугацаагаар хязгаарлаж, зөвхөн хяналттай уулзалт хийх байдлаар хэрэгжүүлэх, бүр онцгой тохиолдолд уулзалтын эрхийг бүрэн зогсоох боломжтой. Гэхдээ ийм хязгаарлалт нь үргэлж “хүүхдийн эрх ашиг нэн тэргүүнд байх” зарчимд нийцсэн, харьцаа, хэмжээний хувьд зохистой (пропорциональ) байх ёстой.

(2) Үнэт зүйн үндэс

Уулзалтын эрхийн үнэт зүйлийг олон талт, олон түвшинд авч үзэж болно.

Хүүхдийн сэтгэлзүйн хөгжил, танин мэдэхүйн хөгжлийн үүднээс харахад уулзалтын эрх маш чухал байр суурьтай. Хүүхэд эцэг, эхтэйгээ тогтвортой, харилцан итгэлцэлтэй харилцаатай байх нь түүний аюулгүй байдлын мэдрэмж, өөрийгөө үнэлэх үнэлэмж, нийгэмших үйл явцад эерэгээр нөлөөлдөг. Харин эцэг, эхийн нэг талтай холбоо тасрах юм бол хүүхэд өөрийгөө “хаягдсан”, “өөрөө буруутай, гэмтэй” гэсэн буруу ойлголтод автах, улмаар сэтгэлзүйн дарамтад орох эрсдэл нэмэгдэнэ.

Нийгмийн үнэт зүйн үүднээс авч үзвэл уулзалтын эрх нь гэр бүлийн холбоог бүрэн таслахгүй байх, түүнчлэн эцэг, эхийн хариуцлагыг хадгалах механизм юм. Ийм зохицуулалтын ачаар төрийн халамж, асрамжийн тогтолцооны ачааллыг бууруулах, хүүхдийг аль болох төрсөн гэр бүл, өрхийн орчиндоо өсөж хүмүүжих боломжийг хангах нөхцөл бүрддэг.

Уулзалтын эрх нь хувийн эрх чөлөө, гэр бүлийн амьдралын халдашгүй байдал зэрэг суурь үнэт зүйлстэй нягт холбоотой. Хүүхэд, эцэг, эхийн хоорондын харилцаанд төр хэтэрхий гүн, хяналттай оролцох ёсгүй ч, нөгөө талаас хүүхдийн эрх зөрчигдөж, нэг тал эцэг, эх уулзалтын эрхийг дур мэдэн хааж, тасалж байгаа нөхцөлд төрийн зүгээс зохистой түвшний оролцоо, хөндлөнгийн хамгаалалт зайлшгүй шаардлагатай болдог. Иймээс уулзалтын эрхийн үнэт зүйн суурь нь хувийн эрх чөлөө, эцэг, эхийн хариуцлага болон төрийн хөндлөнгийн оролцоо хоорондын зөв, тэнцвэртэй харьцаан дээр тогтдог гэж ойлгож болно.

1.2.4 Уулзалтын эрхийг хэрэгжүүлэхэд учир буй сорилт, бэрхшээл

Уулзалтын эрхийг хуульд тусган зарчмын хувьд тунхагласан байлаа ч энэ нь өөрөө уг эрх бодит амьдрал дээр бүрэн хэрэгжинэ гэсэн баталгаа болдоггүй.

Олон улсад, ялангуяа Монгол Улс ба БНХАУ-д уулзалтын эрхийн талаар “шүүхийн шийдвэр гаргах практик” тогтсон боловч “шийдвэр гүйцэтгэх” шат нь хамгийн том сорилт болж байна.

Эрх зүйн үүднээс үүнийг дараах байдлаар тайлбарлах боломжтой байна.

1. Хууль зүйн зохицуулалтын тодорхой бус байдал. Зарим улсад уулзалтын эрхийн нарийвчилсан агуулга, үргэлжлэх хугацаа, давтамж, хэлбэрийг тодорхой заагаагүй, ерөнхийдөө л “уулзах эрхтэй” гэсэн түвшинд үлдээсэн байдаг. Үүний улмаас шүүхийн шийдвэр өөрөө ч тодорхой бус болж, “уулзалтын тодорхой хуваарь”, “гүйцэтгэлийн шат дараалсан алхам”-гүй байснаас болж шийдвэр гүйцэтгэл дээр дахин маргаан үүсэх нөхцөл бүрддэг.

2. Эрх ба бодит хяналтын хоорондын зөрчил. Хууль ёсны хувьд уулзалтын эрхийг тухайн талд олгосон байлаа ч, хүүхэдтэй өдөр тутам хамт амьдарч буй эцэг, эх өөрийн бодит хяналтын байр сууриа ашиглан хүүхдийг нөгөө талтай уулзуулахгүй байх, уулзалтын цагийг санаатайгаар өөрчлөх, эсвэл хүүхдийн сэтгэлзүйд нөлөөлж, нөгөө талын эсрэг дайсагнах хандлага төрүүлэх замаар шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэхээс зайлсхийх нь түгээмэл. Ийм нөхцөлд шүүх болон шийдвэр гүйцэтгэх байгууллага “хүүхдийн эрх ашиг”-ыг хангахын зэрэгцээ хүүхдэд хүч хэрэглэж албадалгүйгээр шийдвэрийг хэрхэн бодитоор хэрэгжүүлэх вэ гэсэн маш нарийн, төвөгтэй асуудалтай тулгардаг.

3. Шүүхийн нөөц бололцоо ба нийгмийн дэмжлэгийн хязгаарлалт. Уулзалтын эрхийн гүйцэтгэлийг хангахдаа шүүх ганцаараа бүх ачааг үүрэх боломжгүй. Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эвлэрүүлэн зуучлагч, хүүхэд хамгааллын байгууллагын оролцоо зайлшгүй шаардлагатай. Харин эдгээр тогтолцоо хангалттай хөгжөөгүй тохиолдолд шүүхийн гаргасан шийдвэр “цаасан дээрх эрх” төдийд үлдэх өндөр эрсдэлтэй.

4. Хүүхдийн санал бодлыг ашиглах ба хамгаалах хоорондын эмзэг тэнцвэр. Уулзалтын эрхийг хэрэгжүүлэх явцад хүүхдийн санал бодлыг заавал харгалзан үзэх ёстой ч, нөгөө талаас хүүхдийн санааг барьцаа болгон ашиглаж уулзалтын эрхийг хязгаарлах, бүрмөсөн хаах эрсдэл бий. Мөн хүүхдээс дахин дахин асууж, тайлбар нэхэх нь өөрөө сэтгэлзүйн дарамт үүсгэж болзошгүй. Ийнхүү “хүүхдийн эрхийг хамгаална” гэсэн нэрийн дор эсрэгээр нь хүүхдийг зовоох, гадуурхах сөрөг үр дагавар гарах магадлалтай. Иймээс хүүхдийн санал бодлыг мэргэжлийн, тогтвортой аргачлалаар сонсож, үнэлэх институцийн тогтолцоо хангалтгүй байгаа нь уулзалтын эрхийн шийдвэр гүйцэтгэлийн нэг том саад болж байна.

Ингэснээр, уулзалтын эрх нь онолын хувьд хүүхдийн эрх ба эцэг, эхийн хариуцлагын нэг хэсэг болж, олон улсын эрх зүйн түвшинд өргөнөөр хүлээн зөвшөөрөгдсөн ч, практик хэрэгжилтийн явцдаа олон талын зөрчил, саадтай тулгарсаар байна. Энэ нь цаашид Монгол Улс болон БНХАУ-ын уулзалтын эрхийн эрх зүйн зохицуулалт, гүйцэтгэлийн механизмыг харьцуулан судлахдаа зайлшгүй анхаарах ёстой гол асуудлуудын нэг болж байна.

1.3 Харьцуулсан эрх зүйн онолын үндэс

1.3.1 Эрх зүйн реципици буюу эрх зүйг нутагшуулах онол

Харьцуулсан эрх зүй судлалд нэг улсын эрх зүйн тогтолцоог нөгөө улс руу шилжүүлэн нэвтрүүлэх, түүнийг “загвар” болгон ашиглах, мөн өөрийн улсын нөхцөл байдалд тохируулан нутагшуулах асуудал төв байр суурь эзэлдэг. Alan Watson, Otto Kahn-Freund зэрэг эрдэмтдийн бүтээлд “хууль зүйн шилжилт” (legal transplant) хэмээх ойлголтыг гол тулгуур болгон авч үздэг бөгөөд энэ нь нэг улсын хууль зүйн норм, институт, зарчмыг бага өөрчлөлттэйгөөр эсхүл тодорхой хэмжээгээр өөрчилсний үндсэн дээр нөгөө улсын эрх зүйн тогтолцоонд нэвтрүүлэх үйл явцыг хэлнэ.

Ерөнхий ойлголтоор, хууль зүйн шилжилт амжилттай болох эсэх нь дараах хүчин зүйлүүдээс шалтгаалдаг гэж үздэг. 1. Норм, институтийг “гаргаж буй” улс болон түүнийг “хүлээн авч буй” улсын эрх зүйн уламжлал, институтийн бүтэц, соёлын төстэй байдал. Хууль зүйн уламжлал, соёлын суурь харьцангуй ойролцоо байх тусам, шилжүүлэн

нэвтрүүлсэн норм, институт шинэ орчиндоо “нутагшиж”, бодит амьдралд нийцэж хэрэгжих магадлал илүү өндөр байдаг. 2. Шилжүүлж буй институтийн түвэгшлийн түвшин. Жишээлбэл, зарим тодорхой хууль зүйн техникийн зохицуулалтыг (нотариатын журам, бүртгэлийн горим гэх мэт) нэвтрүүлэх нь нийгмийн гүнзгий үнэт зүйл, уламжлалтай нягт холбоотой институтийг (гэр бүлийн бүтэц, хүүхэд хүмүүжүүлэх загвар гэх мэт) шилжүүлэхээс үлэмж хялбар байж болно. Харин маргаан шийдвэрлэх арга барил, уулзалтын эрхийн зохицуулалт зэрэг нь зөвхөн хууль зүйн техник биш, харин соёл, ёс суртахуун, нийгмийн хандлагатай нягт уялдаатай тул “гүн институтийн” шилжилтийн сонгодог жишээнд тооцогдоно. 3. Хууль зүйн шилжилтийн явц дахь улс төрийн хүсэл зориг, дотоод нийгмийн захиалгын ач холбогдол. Хэрэв тухайн нийгэмд хүүхдийн эрхийг хамгаалах, маргааныг сөргөлдөөнөөс ангид аргаар шийдвэрлэх талаар тодорхой хэмжээний нийтлэг ойлголт, бодит хэрэгцээ бүрэлдсэн бол гадаад улсын туршлага, загварыг нэвтрүүлэх “хөрс” илүү бэлэн байдаг. Харин нийгмийн эсэргүүцэл хүчтэй, хуучин ойлголт, соёлын хандлага гүн суусан нөхцөлд, хууль зүйн нормын хэлбэр өөрчлөгдсөн байлаа ч бодит амьдрал дахь хэрэгжилт сул байх магадлал өндөр.

Иймээс Монгол Улс болон БНХАУ -ын уулзалтын эрхийн талаарх хууль зүйн зохицуулалтыг харьцуулж, БНХАУ -ын улсын туршлагын аль хэсгийг Монгол Улсын нөхцөл байдалд тохируулан шилжүүлэн нэвтрүүлэх боломжтойг хэлэлцэхдээ дээр дурдсан хууль зүйн шилжилтийн онолын эдгээр шалгуурыг бүрэн хэмжээнд харгалзан үзэх шаардлагатай.

1.3.2 Хууль зүйн бодит үр нөлөөний онол

Хууль зүйн бодит үр нөлөөний (legal effectiveness / legal realism) онол нь “хууль ном дээр хэрхэн бичигдсэн бэ” гэдэг асуултаас илүү “амьдрал дээр хэрхэн хэрэгжиж байна вэ” гэсэн асуултад төвлөрдөг. Ehrlich-ийн “амьдрал дахь хууль” (living law) гэсэн ойлголтоор төлөөлөгдөх энэ чиглэлийн онолд “бичигдсэн хууль” (law in books) ба “үйлдэл дэх хууль” (law in action) гэсэн хоёр түвшнийг ялгаж, хууль тогтоомжийн текст болон бодит хэрэгжилтийн зөрчлийг судлахыг чухалчилдаг.

Гэр бүлийн эрх зүйн, тэр дундаа уулзалтын эрхийн хувьд энэхүү ялгаа онцгой ач холбогдолтой. Нэг улсын хууль тогтоомжид хүүхдийн эрх, уулзалтын эрхийг тодорхой, дэвшилттэй байдлаар тунхагласан байлаа ч шүүхийн практик, шийдвэр гүйцэтгэл, нийгмийн дэмжлэгийн тогтолцоонд зохих өөрчлөлт гараагүй тохиолдолд эрх зүйн бодит үр нөлөө бага, “цаасан дээрх эрх” хэвээр үлдэнэ.

Хууль зүйн бодит үр дагаварт нөлөөлөх хүчин зүйлсийг дараах байдлаар задлан үзэх боломжтой.

(1) Институтийн хүчин зүйл – шүүхийн мэргэшил, хүний нөөц, төсөв, шийдвэр гүйцэтгэх тогтолцоо, нийгмийн үйлчилгээний байгууллагуудын оролцоо, салбар хоорондын хамтын ажиллагаа.

(2) Нийгэм-соёлын хүчин зүйл – хүүхдийн эрхийн талаарх олон нийтийн ойлголт, гэр бүлийн дотоод эрх мэдлийн уламжлалт бүтэц, жендерийн хэвшмэл ойлголт, салалтад хандах нийгмийн хандлага зэрэг нь хууль хэрэгжих орчинд шууд нөлөөлнө.

(3) Эдийн засгийн хүчин зүйл – улсын төсөв, нийгмийн үйлчилгээний хүртээмж, мэргэжлийн хүний нөөцийн бэлтгэл, бүс нутгийн хөгжлийн ялгаа зэргээс шалтгаалан ижил хууль өөр өөр нутаг дэвсгэрт өөр өөр үр нөлөөтэй байж болно.

Энэ онолын үүднээс Монгол Улс, БНХАУ-ын уулзалтын эрхийн зохицуулалтыг судлахдаа зөвхөн хууль зүйн текстийг харьцуулахаас гадна шийдвэр гүйцэтгэлийн түвшин, практик үр дүнг заавал хамтад нь авч үзэх шаардлагатай.

1.3.3 Соёл хоорондын харьцуулсан эрх зүйн арга зүй

Соёл хоорондын харьцуулсан эрх зүйн судалгаа нь нэг улсын эрх зүйн тогтолцоог нөгөөгөөр “шүүж” дүгнэхдээ тухайн улс орны соёл, уламжлал, түүхэн туршлага, нийгмийн үнэт зүйлсийг харгалзан үзэх шаардлагатайг онцолдог.

(1) Функционалийн арга

Функционалийн (үйл ажиллагааны) харьцуулалтаар ижил төрлийн нийгмийн асуудал “энэ судалгаанд бол маргаанд хүүхдийн уулзалтын эрхийг хамгаалах”-ыг өөр өөр эрх зүйн тогтолцоонд хэрхэн шийдвэрлэж буйг харьцуулна. Үүнд гол анхаарах зүйл нь “институт ямар үүрэг гүйцэтгэж байна вэ?” гэсэн асуулт байдаг. Жишээлбэл, Монгол Улсад уулзалтын эрхийн гүйцэтгэлийг хангах тодорхой албадлагын арга хомс байхад, БНХАУ-д торгууль, зээлийн мэдээллийн хориг гэх мэт өөр хэлбэрийн механизм ашигладаг. Аль аль нь ижил “шийдвэр гүйцэтгэлийг хангах”-ыг зорьдог, хэлбэр нь өөр байж болно.

(2) Соёлын харьцангуй үзэл

Соёлын харьцангуй үзлийн үүднээс “хэт үндэслэлгүй”, “хууль зүйн дарамт”-аас зайлсхийх шаардлагатайг сануулдаг. Нэг улсын амжилттай гэж үнэлэгдсэн загварыг өөр улсын нөхцөлд шууд хэрэглэх нь хууль зүйн төдийгүй нийгэм-соёлын эсэргүүцэл, үр нөлөөгүй байдлыг дагуулж болзошгүй. Тиймээс Монгол Улс, Хятад Улс хоёрын гэр бүлийн бүтэц, хүүхэд хүмүүжлийн уламжлал, нүүдэлчин болон суурин соёлын онцлогийг харгалзан үзэх зайлшгүй шаардлагатай.

(3) Үнэлэмжийн төвийг сахих шаардлага

Харьцуулсан эрх зүйн судалгаанд судлаачийн өөрийн улс, соёлын үнэлэмжийг бусад улсад “шашны сургаал” мэт тулгахгүй байх, өөрөөр хэлбэл үнэлэмжийн тодорхой төвийг сахихыг эрмэлзэх ёстой. Энэ нь аливаа эрх зүйн институтийг “сайн-муу” гэж дан ганц нэг шалгуураар шүүхээс илүү тухайн улс орны зорилго, түүхэн нөхцөл, нийгмийн хэрэгцээнд ямар хэмжээгээр нийцэж байна вэ гэдгийг тайлбарлахад анхаарна гэсэн үг юм.

Энэхүү онол-арга зүйн суурь дээр тулгуурлан дараагийн бүлгүүдэд Монгол Улс, Хятад Улсын уулзалтын эрхийн эрх зүйн зохицуулалт, шүүхийн практик, нийгэм-соёлын орчныг харьцуулан шинжлэх бөгөөд ингэхдээ хууль зүйн шилжилт, бодит үр нөлөө, соёл хоорондын харьцуулалтын дээрх зарчмуудыг баримтална.

БҮЛЭГ 2. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙАЛ

2.1 Монгол Улсын уулзалтын эрхийн эрх зүйн тогтолцоо

2.1.1 Монгол Улсын гэр бүлийн эрх зүйн хөгжлийн тойм

2.1.1.1 Уламжлалт эрх зүйн уламжлал

Монгол Улсын уламжлалт нүүдэлчин нийгэмд гэр бүл, ураг төрлийн харилцаа нь нийгмийн зохион байгуулалтын суурь нэгж байсан бөгөөд хүүхдийн эрх зүйн байдал, гэр бүлийн доторх эрх мэдлийн бүтэц энэ уламжлалаар гүнзгий тодорхойлогдож байв. Хуучин үеийн төрийн хууль цааз (Их Засаг, “Халх журам” зэрэг) болон бичигдээгүй зан заншилд гэр бүлийн харилцааг зохицуулах тодорхой заалт байсны зэрэгцээ, өдөр тутмын амьдралд эрх зүйн албан ёсны зохицуулалтаас илүү ахмад настны эрх мэдэл, ураг төрлийн хяналт, ёс суртахууны зохицуулалт голлох байр суурь эзэлж байсан.

Нүүдэлчин нийгмийн хувьд өрх айл нь зөвхөн эдийн засгийн нэгж бус, нийгмийн хамгаалалтын үндсэн бүтэц байсан учир хүүхдийн байр суурь, хамгаалалт голдуу өрх, ураг, отгийн хүрээнд шийдэгддэг байв. Хүүхэд нь гэр бүлийн хөдөлмөрийн нэг хэсэг, үр удам, отог овгийн “үргэлжлэл” хэмээн ойлгогдож, эцэг, эх, өвөө, эмээ, нагац, авга зэрэг өргөсөн ураг-төрлийн сүлжээний хамгаалалт, хяналтад оршдог байжээ.

Эцэг, эхийн эрх мэдлийн хувьд, ялангуяа эцгийн эрх мэдэл давамгайлсан бүтэц зонхилж, хүүхдийн хүмүүжил, гэрлэлтийн шийдвэр, өв хөрөнгийн хуваарилалт зэрэгт эцэг болон эрэгтэй ахмад гишүүд гол шийдвэр гаргагч байлаа. Гэсэн ч ураг, овгийн ахмад настуудын хяналт, хамтын хариуцлага, “хүүхдийг хорлож болохгүй” гэсэн ёс суртахууны хэм хэмжээ тодорхой хэмжээнд хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байсан гэж үзэж болно.

Салалт, гэрлэлт цуцлалтын хувьд уламжлалт нүүдэлчин нийгэмд харьцангуй ховор, олон нийтэд сөрөг үнэлэгддэг үзэгдэл байсан тул үед хүүхэд хэний хамт амьдрах, нөгөө талтайгаа уулзах асуудал нь өнөөгийн утгаар эрх зүйн институт болж бүрэлдэхээсээ илүү “гэр бүл, ураг доторх хэлцэл, ахмадын шийдвэр”-ээр шийдэгддэг байв. Ийм нөхцөлд уулзалтын эрхийн тухай орчин үеийн ойлголт, хүүхдийн бие даасан эрхийн тухай үзэл баримтлал тодорхой хэмжээнд үгүй, эсвэл маш сул илэрч байжээ.

2.1.1.2 Орчин үеийн гэр бүлийн эрх зүйн бүрэлдэхүй

Социалист тогтолцооны үед (XX зууны дунд үеэс XX зууны эцэс хүртэл) Монгол Улсын гэр бүлийн эрх зүйд суурь өөрчлөлт гарсан. ЗХУ болон социалист улс орнуудын жишгээр гэрлэлтийг төрийн бүртгэлтэй, албан ёсны эрх зүйн акт гэж үзэх, эрэгтэй, эмэгтэйчүүдийн эрх тэгш байдлыг хуульчлах, гэр бүл, гэрлэлтийн харилцааг төрийн бодлогоор зохицуулах хандлага өрнөв. Энэ үед батлагдсан гэр бүлийн хууль тогтоомжид:

- Нэг эхнэр-нэг нөхрийн гэрлэлтийг хуульчлах;
- Гэрлэлтийг бүртгэлийн байгууллагаар дамжуулан хүчин төгөлдөр болгох;
- Тодорхой нөхцөлд гэрлэлт цуцлах эрхийг хуульчилж, шүүхийн оролцоог хуульчлах;
- Эцэг, эхийн хүүхдийн өмнө хүлээх тэнцвэртэй эрх, үүргийг тогтоох;

- Хүүхдийн эрх ашгийг тодорхой хэмжээнд хамгаалах зэрэг суурь зохицуулалт хийгдсэн.

Гэлээ ч социалист үеийн Гэр бүлийн эрх зүйд хүүхдийн эрхийг өнөөгийн утгаар “хүүхдийн бие даасан эрх” гэхээсээ илүү гэр бүлийн тогтвортой байдал, төрийн ашиг сонирхол, социалист ёс суртахуун гэсэн үүднээс авч үздэг байв. Салалтыг аль болох багасгах, гэр бүлийг хадгалах төрийн бодлого давамгайлж, салалт нь “сөрөг” үзэгдэл гэж тайлбарлагддаг байсан тул дараах уулзалтын эрхийн тухай нарийвчилсан зохицуулалт хөгжөөгүй.

1990 оноос зах зээлийн эдийн засаг, ардчилсан тогтолцоонд шилжсэнтэй холбогдон нийгэм, эдийн засаг, үнэт зүйлийн өөрчлөлт гэр бүлийн харилцаанд хүчтэй нөлөөлсөн. Энэ үед:

- Зах зээлд тулгуурласан ажилгүйдэл, ядуурал,
- Дотоод, гадаад шилжилт хөдөлгөөн,
- Хотжилт, цөм гэр бүлийн өсөлт,
- Жендерийн үүргийн өөрчлөлт зэрэг үзэгдэл эрчимжив.

Үүний улмаас түвшин нэмэгдэж, өрх толгойлсон гэр бүлийн тоо өсөж, хүүхэд хамгааллын асуудал, гэр бүлийн хүчирхийлэл, архидалт, үл хайхрах явдал нийгмийн анхаарлын төвд орж ирсэн. Энэ шинэ нөхцөл байдалд нийцүүлэн Монгол Улсад шинэ “Гэр бүлийн тухай” хууль батлагдаж, хүүхдийн эрхийг хамгаалах, маргаанд эцэг, эхийн эрх, үүргийг илүү тодорхой болгох алхам хийгдсэн.

2.1.1.3 Одоогийн “Гэр бүлийн тухай” хуулийн суурь бүтэц

Одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Гэр бүлийн тухай хууль нь гэр бүлийн эрх зүйн харилцааг зохицуулах үндсэн эрх зүйн эх сурвалж бөгөөд дараах чиглэлүүдэд суурь зохицуулалт хийсэн байдаг.

1. Гэрлэлт бүртгэх ба гэрлэлт цуцлах. Хуульд гэрлэлтийн нас, гэрлэлт байгуулах нөхцөл, бүртгэлийн журам, гэрлэлт хүчингүйд тооцогдох үндэслэл, гэрлэлт цуцлах нөхцөл, журмыг тодорхой заасан бөгөөд гэрлэлтийг цуцлахдаа талуудын хооронд хүүхдийн асран хамгаалалт, тэжээн тэтгэх, мөн хөрөнгийн хуваарилалтын асуудлыг хамтад нь шийдвэрлэхийг шаарддаг.

2. Эцэг, эхийн эрх, үүрэг болон хүүхдийн эрх. Хуульд эцэг, эх нь хүүхдээ тэжээн тэтгэх, хүмүүжүүлэх, эрүүл мэнд, боловсролд нь анхаарах үүрэгтэйг тогтоож, хүүхэд амьд явах, хөгжих, хамгаалалт авах, боловсрол эзэмших эрхтэй болохыг тунхагласан. Хүүхдийн эрх нь зөвхөн зарчим түвшинд биш, тодорхой заалтуудаар баталгаажсан боловч эдгээр эрхийг бодитой хэрэгжүүлэх арга механизм харьцангуй хязгаарлагдмал хэвээр байна.

3. Хүүхдийн асран хамгаалалт, тэжээн тэтгэх болон уулзалтад хамаарах зохицуулалт.

Гэрлэлт цуцлах үед хүүхдийг аль талд үлдээх, хэнд асран хамгаалах эрх олгох, нөгөө тал ямар хэлбэрээр тэжээн тэтгэх үүрэг хүлээхийг хуульчилсан. Уулзалтын эрхийн тухай тусгай заалтууд орсон ч ихэвчлэн “эцэг, эх нь хүүхэдтэйгээ уулзах, харилцах эрхтэй” гэсэн ерөнхий томъёоллын түвшинд үлдэж, энэ эрхийн тодорхой агуулга, хэрэгжүүлэх нарийвчилсан журам хангалттай тодорхой биш байна.

Хүүхдийн эрхийг хамгаалах зарчмын хувьд «Гэр бүлийн тухай» хуульд хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах тухай заалт байгаа ч олон улсын конвенцид туссан “хүүхдийн эрх ашиг нэн тэргүүнд байх” гэсэн томъёоллыг бүрэн хэмжээгээр шингээж, түүнтэй уялдсан нарийн, тодорхой шалгуур, журам бүрэн боловсорч амжаагүй гэж үзэх үндэстэй.

Асран хамгааллын тогтолцооны хувьд Монгол Улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж буй «Гэр бүлийн тухай» хуульд мөн адил эцэг, эхийг насанд хүрээгүй хүүхдийн гол асран хамгаалагч, хүүхдийн амьдралын нөхцөл, хүмүүжил, боловсрол, үндсэн эрх ашгийг хамгаалах анхны хариуцлагатай этгээдээр тогтоодог.

Гэвч Хятад Улсын Иргэний хуультай харьцуулахад Монгол Улсын хууль тогтоомжид асран хамгаалагчийн дараалал, шүүхээр асран хамгаалагчийг томилох, өөрчлөх, хүчингүй болгохтой холбоотой асуудлыг ихэвчлэн ерөнхий зарчмын түвшинд томъёолсон бөгөөд тусгай, нарийвчилсан институтийн зохицуулалт, процедурын норм харьцангуй сул хөгжсөн байна.

Ялангуяа эцэг, эхийн нэг эсхүл хоёулаа асран хамгаалах үүргээ биелүүлэх боломжгүй үед ямар ойрын хамаатан, байгууллага, эсхүл байгууллагаас шүүхэд хандаж асран хамгаалагч томилуулах, буруутай асран хамгааллын үйл ажиллагаанд ямар замаар хөндлөнгөөс оролцож, хамгаалалт үзүүлэх зэрэг асуудал тодорхой бус байгаа нь асран хамгааллын тогтолцоо, уулзалтын эрхийн зохицуулалтын хоорондын уялдаа, хамтын ажиллагааг хангахад тодорхой хүндрэл учруулж байна.

2.1.2 Монгол Улс дахь хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн механизм (Асрамж, гэжээн тэтгэлэг, уулзах эрх)

Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 26-р зүйлд зааснаар эцэг, эх хүүхдээ хүмүүжүүлэхэд тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээх бөгөөд хүүхдийн асрамж хамгаалалтыг (Custody) тогтоохдоо эцэг, эхийн хэн нэгний давуу эрхийг хуульчлаагүй байдаг. Шүүх хүүхдийн асрамжийг шийдвэрлэхдээ эцэг, эхийн ёс суртахууны байдал, хүүхдэд тавих анхаарал халамж, хүүхдийн нас болон өсөж торних орчин нөхцөлийг цогцоор нь үнэлж, хүүхдийн дээд ашиг сонирхолд нийцсэн шийдвэр гаргахыг эрмэлздэг. Мөн хуулийн 35-р зүйлд заасан гэжээн тэтгэлгийн (Child support) зохицуулалт нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдан тогтоогдож, хүүхдийн өсөж торних эдийн засгийн суурь баталгааг хангахад чиглэгддэг. Эдгээр суурь эрхүүд нь хүүхдийн эрхийг хамгаалах механизмын салшгүй үндэс болох бөгөөд үүний дараа маргааны явцад хамгийн их зөрчилдөөн дагуулдаг уулзалтын эрхийн зохицуулалтыг нарийвчлан авч үзэх нь зүйтэй:

2.1.2.1 Уулзалтын эрхийн хууль зүйн тодорхойлолт, агуулга

Монгол Улсын “Гэр бүлийн тухай” хуульд эцэг, эхийн хүүхэдтэй уулзах, харилцах эрхийг хүлээн зөвшөөрсөн хэд хэдэн заалт байдаг. Ерөнхий утгаараа хуульд эцэг, эх аль нь хүүхэдтэйгээ харилцах, уулзах эрхтэй, энэ эрхийг нөгөө тал үндэслэлгүйгээр хязгаарлах, хориглох ёсгүй гэж заасан байдаг. Гэвч уулзалтын эрхийн тодорхой хууль зүйн тодорхойлолт, эрхийн яг ямар агуулга, хүрээтэй болохыг нарийвчлан заасан заалт харьцангуй хомс байна.

Одоогийн зохицуулалтаас харахад уулзалтын эрх нь дараах агуулгатай. Үүнд:

- Хүүхэдтэй биечлэн уулзах, тодорхой хугацаагаар хамт байх;
- Утас, цахим харилцаа, бичгээр харилцах зэрэг холбоо тогтоох;
- Хүүхдийн сургууль, эрүүл мэнд, амьдралын нөхцөл байдалтай холбоотой мэдээлэл авах;
- Хүүхэдтэй хамт тодорхой арга хэмжээ, баярт оролцох зэрэг.

Гэвч хуульд эдгээрийг тус бүрээр нь тодорхойлсон бус, нэгтгэн ерөнхий байдлаар томъёолсон тул шүүхийн практикт уулзалтын эрхийн хүрээ, хэлбэр, давтамжийг тодорхойлохдоо ихээхэн хэмжээний тайлбар хийх, шүүгчийн үзэмжид тулгуурлах шаардлага гардаг.

Мөн уулзалтын эрхийг хүүхдийн эрх үү, эсхүл эцэг, эхийн эрх үү гэсэн онолын ялгаа хуульд шууд тусгагдаагүй ч заалтын агуулгаас үзэхэд ихэвчлэн эцэг, эхийн хүүхэдтэйгээ уулзах эрхийг онцолдог, харин хүүхдийн өөрийн “эцэг, эхтэйгээ уулзах, харилцаагаа хадгалах эрх”-ийг шууд тодорхойлсон зохицуулалт бага байгааг тэмдэглэх нь зүйтэй.

2.1.2.2 Уулзалтын эрхийг хэрэгжүүлэх журам, механизм

(1) Хэлэлцээр, тохиролцооны механизм

Талууд эцэг, эхийн асран хамгаалалт, уулзалтын талаар харилцан тохиролцоо хийх боломжтой. Шүүх маргааныг шийдвэрлэхдээ талуудын тохиролцоог батлах, эсхүл тодорхой нөхцөл, журам тогтоох замаар шийдвэр гаргана. Олон тохиолдолд шүүхээс “талууд уулзалтын цаг, давтамжийг өөр хоорондоо тохиролцоно” гэсэн ерөнхий агуулгатай шийдвэр гаргах нь элбэг бөгөөд энэ нь практикт уулзалтын явцад дахин зөрчил, маргаан үүсэх шалтгаан болдог.

(2) Шүүхэд хандах, эрх зүйн хамгаалалтын зам

Уулзалтын эрхийг хэрэгжүүлэхэд нөгөө тал саад учруулсан, хүүхдийг уулзуулахгүй байгаа тохиолдолд уулзалтын эрхийг эдэлж чадахгүй байгаа тал шүүхэд хандаж болно. Энэ тохиолдолд шүүх:

- Уулзалтын эрхийг албан ёсоор хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах;
- Уулзалтын тодорхой хуваарь, хугацаа, нөхцөл тогтоох;
- Талуудад эрүүл уур амьсгал бүрдүүлэх, хүүхдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр тодорхой үүрэг оноох боломжтой.

Гэвч шүүхэд хандах энэ замыг ашиглахдаа талууд дахин шинээр нэхэмжлэл гаргах, олон шат дамжлага дамжих шаардлагатай болдог нь хүний нөөц, цаг хугацааны хувьд ихээхэн дарамт учруулдаг. Түүнчлэн шүүхийн шийдвэр хэрэгжих талаар тодорхой гүйцэтгэлийн журам хомс байгаагаас “шийдвэр гарсан ч бодитоор биелдэггүй” байдал үүсдэг.

(3) Зуучлал, шүүхийн ажиллагаа

“Гэр бүлийн тухай” хууль болон холбогдох журамд гэр бүлийн маргаанд эвлэрүүлэн зуучлалаар шийдвэр гаргах боломжийг хүлээн зөвшөөрсөн байдаг. Гэсэн ч

уулзалтын эрхтэй холбоотой маргаанд мэргэшсэн гэр бүлийн зуучлал, хүүхэдтэй ажиллах мэргэжлийн аргачлал хангалттай түвшинд хөгжөөгүй байна.

Шүүхийн ажиллагааны хувьд маргааныг ердийн иргэний хэргийн журмаар шийдвэрлэдэг бөгөөд гэр бүлийн хэрэгт зориулсан тусгай, хүүхдэд ээлтэй журам (хүүхдийн санал бодлыг сонсох аргачлал, хаалттай хуралдааны стандарт, сэтгэл зүйчийн оролцоо гэх мэт) зөвхөн тодорхой түвшинд хөгжсөн байна. Үүний улмаас уулзалтын эрхийн асуудлыг шийдвэрлэх явцад хүүхдийн сэтгэлзүйн хэрэгцээ, насанд тохирсон оролцооны эрх хангалтгүй тусгагдах эрсдэл бий.

2.1.2.3 Уулзалтын эрхийг хязгаарлах, зогсоох хууль зүйн үндэслэл

Монгол Улсын “Гэр бүлийн тухай” хуульд тодорхой нөхцөлд эцэг, эхийн хүүхдийн өмнө хүлээх үүргийг ноцтой зөрчсөн тохиолдолд шүүх тэдний зарим эрхийг хязгаарлах, асран хамгаалах эрхийг хүчингүй болгох боломжтойг заасан. Эдгээр заалт нь уулзалтын эрхэд шууд хамаарахгүй мэт боловч шүүхийн практикт уулзалтын эрхийг хязгаарлах, зогсоох үед үндэслэл болгон хэрэглэгддэг.

Уулзалтын эрхийг хязгаарлах эсхүл зогсоох боломжтой нөхцөлд:

- Хүүхдийн амь нас, эрүүл мэнд, сэтгэлзүйд шууд, ноцтой аюул үзүүлэх үйлдэл (бие махбодийн болон сэтгэлзүйн хүчирхийлэл, садар самуунд татан оролцуулах гэх мэт);
- Архидан согтуурах, мансууруулах бодис хэрэглэх, тогтмол хүчирхийлэл үйлдэх амьдралын хэв маяг;
- Хүүхдийг удаа дараа хаяж орхих, үл хайхрах;
- Хүүхдийг бусдын хууль бус үйлдэлд ашиглах;
- Шүүхийн өмнө удаа дараа худал мэдүүлэг өгөх, хүүхдийг санаатайгаар төөрөгдүүлэх зэргийг багтааж үздэг.

Гэвч уулзалтын эрхийг хязгаарлах, зогсоох яг нарийн шалгуур, үнэлгээний стандарт хуульд тодорхой заагдаагүй тул шүүхийн практикт:

- Нэг ижил төстэй нөхцөлд өөр өөр шийдвэр гаргах;
- Хүүхдийн эрх ашиг бус, эцэг, эхийн хоорондын зөрчил давамгайлсан үнэлгээ хийх;
- “Хүүхэд уулзахыг хүсэхгүй байна” гэсэн шалтгааныг хангалттай мэргэжлийн үнэлгээ хийлгүйгээр шийдвэрийн үндэслэл болгох зэрэг эрсдэл гарч болзошгүй.

Иймээс Монгол Улсын одоогийн эрх зүйн зохицуулалтад уулзалтын эрхийг хязгаарлах, зогсоохтой холбоотой заалтыг хүүхдийн эрх ашиг нэн тэргүүнд байх зарчимтай илүү тодорхой уялдуулах, үнэлгээний тодорхой шалгуур боловсруулах шаардлага байгаа нь дараагийн бүлгүүдэд хийх шүүмжлэл, шинэчлэлийн саналын нэг чухал чиглэл болно.

2.1.3 Монгол Улсын шүүхийн практикт уулзалтын эрхийн асуудал

2.1.3.1 Шүүхийн статистик мэдээллийн чиг хандлага

Монгол Улсад гэр бүл цуцлах хэрэг, түүнтэй холбоотой хүүхдийн асран хамгаалалт, тэжээн тэтгэх, уулзалтын эрхийн маргааны тоо сүүлийн жилүүдэд тогтвортой өсөх хандлагатай байгаа нь шүүхийн жилийн тайлан, статистик мэдээллээс харагддаг.

Гэр бүл цуцлах хэргийн дотор насанд хүрээгүй хүүхэдтэй холбоотой маргаан зонхилж, ихэнх тохиолдолд асран хамгаалалт, тэжээн тэтгэх асуудлыг хамтад нь шийдвэрлэж байна.

Уулзалтын эрхийн маргаан нь ихэвчлэн:

- Үед анх удаа уулзалтын журам тогтоолгох;
- Өмнөх шийдвэр, тохиролцоог өөрчлүүлэх (уулзалтын давтамж, хугацаа, нөхцөлийг өөрчлөх);
- Уулзалтын эрхийг хэрэгжүүлэхэд саад болж буй талын үйлдлийг зогсоолгох, гүйцэтгэлийг хангах;
- Уулзалтын эрхийг хязгаарлах, зогсоох талаар шүүхэд хандах хэлбэрээр илэрдэг.

Статистикийн талаас харахад уулзалтын эрх бие даасан нэхэмжлэл хэлбэрээр хязгаарлагдмал тоогоор бүртгэгдэж, олон тохиолдолд ерөнхий маргааны хэсэг, эсхүл асран хамгаалалтын маргааны нэг дэд асуудал байдлаар шийдвэрлэгдэж байна. Энэ нь шүүхийн статистикт уулзалтын эрхийн асуудлыг тусгай ангиллаар бүртгэж, бодит тоо хэмжээг тодорхойлох боломжийг хязгаарлаж байна.

2.1.3.2 Төлөөлөл бүхий маргаан, шийдвэрийн шинжилгээ

Монгол Улсын шүүхийн практикт уулзалтын эрхтэй холбоотой шийдвэрүүдийг дүгнэвэл:

Маргааны үед асран хамгаалах эрхийг нэг талд олгож, нөгөө талд нь хүүхэдтэйгээ уулзах эрх олгох шийдвэр гаргах нь түгээмэл байна. Ийм шийдвэрийн үндэслэлд хүүхдийн нас, ээжийн асаргаа, орлогын тогтвортой байдал зэрэг хүчин зүйлс түлхүү тусч, аав нь гол төлөв уулзалтын эрхээр дамжуулан хүүхдийн амьдралд оролцох боломжтой болдог.

Уулзалтын цагийн хуваарь, давтамжийг ихэвчлэн ерөнхий байдлаар тогтоодог. Жишээлбэл, “сардаа нэг удаа амралтын өдөр уулзах”, “зуны амралтын үеэр тодорхой хугацаагаар хамт байх” гэх мэтээр заадаг ч, яг хэдний өдөр, хэдэн цагт, хаана уулзах, хэн авчирч, хэн буцааж өгөх зэрэг нарийвчилсан зохицуулалт дутмаг байдаг.

Зарим шийдвэрт “талууд харилцан ярилцаж, тохиролцоно” гэж л үлдээдэг нь дараагийн шатны маргааны шалтгаан болдог. Хүүхдийн санал бодлыг хэрхэн, яаж тусгасан нь тогтворгүй. Зарим хэрэгт шүүх хүүхдийн нас, хөгжлийн түвшинд нь тохируулан түүнийг сонсож, илэрхийлсэн хүслийг нь шийдвэрийн үндэслэлд тодорхой тэмдэглэдэг бол, өөр зарим тохиолдолд хүүхдийн санал огт тусгагдахгүй, эсвэл “хүүхэд ээжтэйгээ байхыг хүсэж байна” гэх мэт туйлын товч байдлаар тэмдэглэгдсэн байдаг.

Хүүхдийн сэтгэлзүйн үнэлгээ, мэргэжлийн дүгнэлтэд тулгуурлан гаргасан шийдвэр харьцангуй цөөн, ихэнхдээ шүүгчийн өөрийн ажиглалт, талуудын гаргасан нотлох баримтад илүү түшиглэдэг. Уулзалтын эрхийг хязгаарлах, зогсоох шийдвэрүүд маш болгоомжтой, тоо хэмжээний хувьд цөөн гардаг.

Хүүхдэд ноцтой сөрөг үр дагавар учруулж болзошгүй эрсдэл, жишээлбэл архидалт, хүчирхийлэл, удаан хугацааны үл хайхрах байдал тогтоогдсон үед л уулзалтын эрхийг түр хугацаагаар хязгаарлах, эсвэл хяналттай уулзалт хийх шийдвэр гаргах нь түгээмэл. Гэвч нөгөө талаар, хангалттай мэргэжлийн үнэлгээ хийгдээгүй байхад “хүүхэд уулзахыг хүсэхгүй байна” гэсэн шалтгааныг шууд үндэслэн уулзалтын давтамжийг цөөрүүлэх, аль болох албадлагын арга хэрэглэхээс зайлсхийх хандлага ч ажиглагддаг.

2.1.3.3 Шийдвэр шийдвэрийг гүйцэтгэхэд учир буй бэрхшээл

Монгол Улсад уулзалтын эрхийн талаар гаргасан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх шат нь бүхэл тогтолцоонд хамгийн эмзэг, хамгийн хүндрэлтэй хэсэг болж байна. Шүүхээс уулзалтын эрхийг тогтоосон шийдвэр гарсан байсан ч, практикт гүйцэтгэх явцад дараах институтийн ба зохион байгуулалтын шинжтэй асуудлууд үргэлжилсээр байна.

1. Гүйцэтгэлийг хангах тодорхой эрх зүйн механизм харьцангуй сул хөгжсөн. «Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай» хууль болон холбогдох журамд уулзалтын эрхтэй холбоотой шийдвэрийг хэрхэн гүйцэтгэх, мөн үүргээ биелүүлээгүй талд ямар төрлийн албадлагын арга хэмжээ авах талаар нарийвчилсан зохицуулалт дутмаг байдаг. Жишээлбэл, нэг тал тогтоосон өдөр, цагт хүүхдийг шилжүүлэн өгөхгүй байх, уулзалтын тохиролцсон журмыг давтан зөрчих үед торгууль оногдуулах, бусад албадлагын арга хэрэглэх боломжийг хууль тодорхой хэмжээнд олгодог боловч, практикт ийм шийдвэрийг үр дүнтэй хэрэгжүүлсэн туршлага бага, шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтнуудын эрх хэмжээний хил зааг ч бүрэн тодорхой биш байна.

2. Хүүхэдтэй хамт амьдарч буй тал бодит байдал дээр илүү давуу байр суурь эзэлдэг. Хүүхэдтэй өдөр тутам хамт амьдарч буй тал нь хүүхдийн амьдралын бүх нөхцөлийг фактаар хянаж байдаг тул уулзалтын эрхийн гүйцэтгэлд бодит “хяналт, хөшүүрэгтэй” тал болдог. Тухайн тал хүүхдийг уулзахыг хүсэхгүй байлгах, уулзалт болохоос өмнө олон янзын шалтгаанаар шилжүүлгийг хойшлуулах, хүүхдийн өмнө нөгөө талыг байнга муугаар дүрслэх, нөгөө эцэг, эхийн талаар сөрөг хандлага төлөвшүүлэх замаар хүүхдийг уулзалтаас татгалзуулах зэрэг аргаар шүүхийн шийдвэрийн бодит үр нөлөөг тойрч, сулруулж чаддаг. Шийдвэр гүйцэтгэх байгууллага хүүхдийг хүч хэрэглэн авч яваад нөгөө талтай уулзуулах боломжгүй, мөн “хүүхдийн эрх ашигт” харшлах эрсдэлийг харгалзан үзэх шаардлагатай тул илүү хатуу эсэргүүцлийн арга хэмжээ авахдаа ихэвчлэн болгоомжтой ханддаг.

3. Нийгмийн дэмжлэгийн тогтолцоо хангалтгүй хөгжсөн. Уулзалтын эрхийн гүйцэтгэлд нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, гэр бүлийн зуучлагч зэрэг гуравдагч талын мэргэжлийн оролцоо маш чухал. Гэтэл Монгол Улсад гэр бүлд чиглэсэн мэргэшсэн үйлчилгээний хүртээмж бага, гүйцэтгэх ажиллагааны явцад хүүхдийн сэтгэлзүйг дэмжих, эцэг, эхийн хоорондын зөрчлийг зөөлрүүлэх тогтолцоо бүрэн бүрдээгүй байна. Үүний улмаас талуудын хоорондын хурц зөрчил удаан хугацаанд үргэлжилж, хүүхэд уулзалтын

үеэр өндөр түвшний сэтгэлзүйн дарамт мэдэрч, улмаар уулзалтын эрхийг бодитоор хэрэгжүүлэх боломж улам бүр нарийсдаг.

4. Шүүх, шийдвэр гүйцэтгэх байгууллага болон нийгмийн бусад байгууллагуудын уялдаа хангалтгүй. Уулзалтын эрхийн гүйцэтгэлийг зохион байгуулахад шүүх, шийдвэр гүйцэтгэх байгууллага, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэгч, сургууль, цэцэрлэг, орон нутгийн захиргаа зэрэг олон талын оролцогч хамтран ажиллах шаардлагатай болдог. Одоогийн нөхцөлд эдгээр субъектүүдийн хооронд мэдээлэл солилцох, хамтран ажиллах механизм сул, хэн яг ямар тодорхой үүрэг хүлээх нь тодорхойгүй, институт хооронд “хариуцлага шилжүүлэх” үзэгдэл үе үе ажиглагддаг.

5. Уулзалтын эрхийг санаатайгаар зөрчих, эсвэл уулзалтын эрхийг буруугаар ашиглах зан үйлд ногдуулах хариуцлагын тогтолцоо төгс төгөлдөр биш. Хүүхэдтэй хамт амьдарч буй тал шүүхийн тогтоосон уулзалтын журмыг олон удаа үндэслэлгүйгээр зөрчих, эсвэл хүүхдийг санаатайгаар нөгөө эцэг, эхтэйгээ уулзуулалгүй байх, нөгөө талын эсрэг дайсагнасан, сөрөг хандлага төлөвшүүлэх замаар уулзалтын эрхийг ноцтойгоор зөрчих тохиолдолд, одоогийн хууль тогтоомжид “ямар шат дараатайгаар, ямар хэмжээний хариуцлага хүлээлгэх ёстойг” тодорхой заагаагүй байна. Иймээс бодит амьдрал дээр уулзалтын эрхийг давтан зөрчиж буй талын хувьд эрсдэл, зардал харьцангуй бага байхад, харин уулзалтын эрхээ бодитоор эдлэхийг оролдож буй тал давтан давтан шүүх, шийдвэр гүйцэтгэх байгууллагад хандах, хяналт шаардах шаардлагатай болж, тэдний дээрхээс гадна ноцтой захиргааны болон сэтгэлзүйн ачаалал нэмэгддэг.

Дүгнэж хэлбэл, Монгол Улсад уулзалтын эрхийн шүүхийн шийдвэр гаргах шатанд тодорхой ахиц гараад байгаа мэт боловч, гүйцэтгэлийн шатанд тогтолцооны дутагдал, нийгмийн дэмжлэгийн хомсдол, эрх зүйн механизмын тодорхой бус байдал, мөн уулзалтын эрхийг санаатайгаар зөрчих, буруугаар ашиглах зан үйлд оновчтой хариуцлага ногдуулдаг тогтолцоо бүрэн төлөвшөөгүйгээс шалтгаалан “хуульд заасан эрх” ба “амьдрал дахь хэрэгжилт” хооронд мэдэгдэхүйц зөрчил хэвээр байна. Энэ нь дараагийн бүлгүүдэд Хятад Улсын туршлагыг харьцуулан авч үзэж, Монгол Улсын нөхцөлд тохирсон шинэчлэлийн санал боловсруулахад анхаарах чухал асуудлын үндэс болж өгнө.

2.1.4 Нийгэм-соёлын орчин дахь уулзалтын эрх

2.1.4.1 Уламжлалт соёлын нөлөө

Монгол Улсынуламжлалт нүүдэлчин соёлд гэр бүл, ураг төрлийн харилцаа нь нийгмийн амьдралын гол тулгуур байсан бөгөөд хүүхдийн байр суурь, эцэг, эхийн үүрэг, салалтад хандах хандлагад энэ уламжлал хүчтэй нөлөөлсөн. Уламжлалт ойлголтоор гэр бүлийг аль болох хадгалах, “хүүхдийн төлөө тэвчих” ёс зонхилж, салалт нь ичгүүртэй, сөрөг үзэгдэлд тооцогдох хандлагатай байв.

Энэ суурь хандлага өнөөдөр ч тодорхой хэмжээнд нөлөө үзүүлж, дараа уулзалтын эрхийн талаар ярилцахдаа олон хүн “гэр бүл нэгэнт задарсан бол харилцааг цэглэх нь дээр” гэх, эсхүл хүүхдийг ээжид бүрэн даатгаж, аавын оролцоог хоёрдогч гэж үзэх хандлагатай байна. Патриархал уламжлалтай холбоотойгоор эрэгтэй хүний эдийн

засгийн үүргийг онцлон, сэтгэлзүйн, асрамжийн үүргийг эмэгтэйд хамаатуулдаг хэвшмэл ойлголт ч уулзалтын эрхийн практикт нөлөөлнө.

Ингэснээр уулзалтын эрхийг хүүхдийн өөрийн эрх гэхээс илүү эцэг, эхийн хоорондын “тохиролцоо” гэж харах, хүүхдийн санал бодлыг хоёрдогч байранд тавих, уулзалтын зохицуулалтыг ээж, аав хоёрын хоорондын харилцааны “үргэлжилсэн маргаан” гэж ойлгох эрсдэл бий.

2.1.4.2 Нийгмийн дэмжлэгийн тогтолцооны өнөөгийн байдал

Монгол Улсад сүүлийн жилүүдэд гэр бүлийн маргааны үед хүүхдэд дэмжлэг үзүүлэх нийгмийн үйлчилгээний тогтолцоог аажмаар бүрдүүлэх оролдлого хийгдэж байгаа боловч хүртээмж, үйлчилгээний чанарын хувьд хараахан хангалттай түвшинд хүрээгүй байна.

Нийгмийн ажил, сэтгэлзүйн зөвлөгөөний хувьд, хот суурин газарт зарим төв байгууллага, төрийн бус байгууллагууд гэр бүлийн зөвлөгөө өгөх, хүүхдэд сэтгэлзүйн үйлчилгээ үзүүлэх ажил явуулж байна. Гэвч нутаг дэвсгэрийн өргөн уудам байдал, хүн амын тархалт, санхүүжилтийн хязгаарлагдмал нөхцөл зэргээс шалтгаалан орон нутаг, ялангуяа алслагдсан бүс нутагт ийм үйлчилгээ бараг үгүй гэж хэлж болно. Уулзалтын эрхийн гүйцэтгэлд хүүхдийн сэтгэлзүйн дэмжлэг, эцэг эхийн харилцааг зөөлрүүлэх үйлчилгээ зайлшгүй чухал боловч шүүхийн практикт эдгээр нөөцийг системтэйгээр татан оролцуулж чадахгүй байгаа нь эрх зүйн шийдвэрийн бодит үр нөлөөг сулруулж байна.

Олон нийтийн эвлэрүүлэн зуучлал, уламжлалт зохицуулалтын хувьд, зарим сум, багийн түвшинд ахмадын зөвлөл, суурийн захиргаа, олон нийтийн зуучлалын бүлэг зэрэг хэлбэрээр гэр бүлийн маргаанд зуучлах оролдлого бий. Гэвч уулзалтын эрх зэрэг эмзэг, нарийн асуудлыг мэргэжлийн түвшинд шийдвэрлэх чадавх харьцангуй сул байгаа бөгөөд хүүхдийн эрхийг төвд нь тавьсан, мэргэжлийн аргачлалд суурилсан гэр бүлийн эвлэрүүлэн зуучлалын тогтолцоо бараг бүрэлдээгүй байна.

Шүүхийн тогтолцооны гаднах дэмжих орчны хувьд, сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн байгууллагууд хүүхдийн гэр бүлийн байдлыг тогтмол ажиглаж хяналт тавих, шаардлагатай үед мэдээлэх чадамж хязгаарлагдмал, эдгээр байгууллагын хоорондын мэдээлэл солилцох, хамтран ажиллах механизм ч сул байна. Гэрлэлт цуцлагдсаны дараа хүүхдийн сэтгэлзүйн өөрчлөлт, хичээл сурлагын уналт, зан авирын хүндрэл зэрэгт олон байгууллага хамтран, уялдаа холбоотойгоор хариу арга хэмжээ авах тогтолцоо дутмаг байгаа тул уулзалтын эрхийн асуудал ихэвчлэн зөвхөн шүүх ба эцэг эхийн хоорондын хууль зүйн маргааны хүрээнд хязгаарлагдах хандлагатай байна.

2.1.4.3 Нийгмийн хандлагын өөрчлөлт, хууль зүйн хүлээлт

Сүүлийн хорь гаруй жилд Монгол Улсын нийгэмд гэр бүл, салалт, хүүхдийн эрхийн талаарх хандлага алхам алхмаар өөрчлөгдөж байна. Залуучуудын дунд гэрлэлтийг “амьдралын хамтын гэрээ” гэж үзэх, харилцаа зохицохгүй бол салалтыг бүрэн үгүйсгэхгүй, харин аль болох хүүхдэд хал багатайгаар шийдвэрлэх тухай ойлголт нэмэгдэж байна. Хүүхдийн эрхийн тухай олон улсын болон дотоодын кампанит ажил, хэвлэл мэдээллийн нөлөөгөөр “хүүхэд бие даасан эрхтэй субъект”, “хүүхдийн санал бодлыг хүндэтгэх” тухай ойлголт өргөн дэлгэрчээ.

Гэсэн ч шүүхийн практик, уулзалтын эрхийн хэрэгжилтээс харахад энэхүү шинэ хандлага эрх зүйн бодит практикт бүрэн шингэж амжаагүй байна. Олон нийтийн тодорхой хэсэгт дараа эцэг, эхийн нэг тал “хүүхдээ өөрийн талд авах”, нөгөө талтай уулзуулахгүй байхыг “хувийн ялалт” гэж ойлгох, хүүхдийг томчуудын маргаанд татан оролцуулах явдал ажиглагдсаар байна.

Нөгөө талаас, нийгэм-соёлын хандлагын өөрчлөлт нь хууль тогтоомжид ч тодорхой хэмжээгээр шахалт, хүлээлт үүсгэж байна. Хүүхдийн эрхийг илүү тодорхой хамгаалах, маргаанд хүүхдийн дуу хоолойг тусгах, уулзалтын эрхийн гүйцэтгэлийг бодитой хангах талаар олон нийт, мэргэжлийн хүмүүсийн захиалга нэмэгдэж байгаа нь “Гэр бүлийн тухай” хууль болон холбогдох тогтолцоог шинэчлэх шаардлагыг улам тодруулж байна.

Иймээс Монгол Улсын нийгэм-соёлын орчинд уулзалтын эрхийн талаар уламжлалт болон шинэ хандлага зэрэгцэн оршиж, эрх зүйн шинэчлэлд аль аль нь нөлөөлж буй хоёрдмол байдал бий. Энэ нөхцөл байдлыг бодолцож, дараагийн хэсэгт Монгол Улсын уулзалтын эрхийн тогтолцооны асуудлыг илүү системтэйгээр оношлон, Хятад Улсын туршлагатай харьцуулан судлах нь чухал юм.

2.1.5 Монгол Улсын уулзалтын эрхийн тогтолцооны асуудлын оношлогоо

2.1.5.1 Эрх зүйн зохицуулалт нөхцөл байдал

Монгол Улсад хүүхдийн уулзалтын эрхийг хуулиар хүлээн зөвшөөрсөн боловч одоогийн эрх зүйн зохицуулалтын системд дараах суурь болон бүтцийн асуудлууд байсаар байна.

1. Уулзах эрхийн эрх зүйн статус тодорхойгүй байдал: “Гэр бүлийн тухай хууль”-д эцэг, эх хүүхэдтэйгээ уулзах, харилцах эрхтэй гэж заасан боловч энэхүү эрх нь хүүхдийн өөрийнх нь идэвхтэй эрх үү, эсхүл тусдаа амьдарч буй эцэг, эхийн эрх үү гэдгийг нарийн тодорхойлоогүй байна. Мөн уулзах эрхийг хүүхдийн “эцэг, эхтэйгээ харилцаагаа хадгалах” суурь эрхийн салшгүй хэсэг гэж томъёолоогүй төдийгүй “хүүхдийн дээд ашиг сонирхлыг тэргүүн ээлжинд хамгаалах” зарчмыг уулзах эрхийн заалтуудтай шууд холбосон албан ёсны зохицуулалт болон үнэлэх шалгуур байхгүй байна. Үүний улмаас шүүхийн практикт хүүхдийн эрх ба эцэг, эхийн эрхийн хоорондын тэнцвэрийг хэрхэн тогтоох, аль эрхийг ямар нөхцөлд нэн тэргүүнд тавих талаар тогтвортой, нэгдмэл ойлголт бүрдээгүй байна.

2. Уулзах эрхийн агуулга болон хүрээ бүрхэг байдал: Хуульд “уулзах, харилцах эрх” гэсэн хэт ерөнхий хэллэг хэрэглэсэн бөгөөд биечлэн уулзах, тодорхой хугацаанд хамт байх, цахим болон утсаар харилцах, түүнчлэн хүүхдийн талаарх мэдээллийг (эрүүл мэнд, боловсрол гэх мэт) авах зэрэг нарийвчилсан агуулгыг заагаагүй байна. Уулзалтын давтамж, үргэлжлэх хугацаа, амралтын болон баяр ёслолын өдрүүдийн зохицуулалтад чиглүүлэх жишиг стандарт (Guideline) байхгүйгээс гадна хүүхдийн нас, сургууль, амьдралын дэглэмд тохируулан уулзалтын хэлбэрийг хэрхэн сонгох талаар хуульчилсан шалгуур дутагдалтай байна. Ийм тодорхой бус байдлаас шалтгаалан шүүхийн шийдвэрт “сард нэг удаа уулзана” эсхүл “талууд тохиролцоно” гэх мэт ерөнхий томъёолол давамгайлж, гүйцэтгэлийн шатанд дахин маргаан үүсэх үндэс болж байна.

3. Уулзах эрхийг хязгаарлах, зогсоох болон сэргээх хяналт сул байдал: Өнөөгийн хуульд хүүхдийн эрхийг ноцтой зөрчсөн тохиолдолд эцэг, эхийн зарым эрхийг

хязгаарлах, асран хамгаалах эрхийг түдгэлзүүлэх тухай ерөнхий заалт байгаа боловч уулзах эрхийг яг ямар нөхцөлд, ямар түвшинд (давтамж багасгах, хяналттай уулзалт, бүрэн хориглох гэх мэт) хязгаарлаж болохыг нарийвчлан заагаагүй байна. Гэр бүлийн хүчирхийлэл, архидалт, мансуурах, хүүхдийг үл хайхрах болон хүүхдийг нөгөө талын эсрэг сөрөг хандлагад сургах зэрэг үйлдлийг ялган үнэлэх эрх зүйн шалгуур тодорхойгүй бөгөөд нөхцөл байдал сайжирсан тохиолдолд (архидалтаас гарсан, сэтгэл зүйн эмчилгээ хийлгэсэн гэх мэт) уулзах эрхийг хэрхэн, ямар шаттайгаар сэргээхийг зохицуулаагүй байна. Иймээс шүүхийн практикт хууль хэрэглээний зөрүү үүсэх, эсхүл уулзах эрхийг нэг удаа хязгаарласан бол урт хугацаанд сэргээхгүй орхих практик эрсдэл бий болоод байна.

2.1.5.2 Шүүхийн практик, институтийн түвшний асуудлууд

Эрх зүйн зохицуулалтын дээрх дутагдлууд шүүхийн практик болон институтийн үйл ажиллагаанд дараах бодит хүндрэлүүд болж илэрч байна.

Нэгдүгээрт, Шүүхийн шийдвэр гаргах шалгуур тогтворгүй байх: Шүүхүүд хүүхдийн нас, эцэг, эхийн эдийн засгийн боломж, амьдрах нөхцөлийг харгалзан үздэг ч хүүхдийн ашиг сонирхлыг үнэлэх нэгдмэл жишиг (нас, эрүүл мэнд, сэтгэл зүй, хүчирхийллийн эрсдэл, ирээдүйн хөгжлийн боломж гэх мэт) тогтоогдоогүй байна. Хүүхдийн санал бодлыг сонсох процедур, насны босго болон мэргэжлийн үнэлгээний оролцоо стандартчилагдаагүй бөгөөд “хүүхэд өөрөө уулзахыг хүсэхгүй байна” гэх мэт мэдэгдэлд тулгуурлан шийдвэр гаргахдаа тухайн мэдэгдэл сэтгэл зүйн нөлөөлөл, дарамтаас ангид эсэхийг гүнзгийрүүлэн нягтлахгүйгээр шууд хүлээн зөвшөөрөх тохиолдол ажиглагддаг. Энэ нь шүүгчийн субъектив үзэмжийг нэмэгдүүлж, ижил төрлийн маргаанд өөр өөр шийдвэр гарах, хүүхдийн дуу хоолойг заримдаа огт тусгахгүй, заримдаа хэт их жин өгөх зөрчилд хүргэж байна.

Хоёрдугаарт, Уулзах эрхийн шийдвэрийг гүйцэтгэхдээ шийдвэр гүйцэтгэгчид ихэвчлэн талуудыг ятгах, сайн дурын үндсэн дээр тохиролцоонд хүргэхийг оролдох, эсхүл албан бичгээр сануулах зэрэг зөвхөн "зөөлөн" арга хэрэглэж байна. Гэтэл хүүхэдтэй хамт амьдарч буй тал уулзалтын өдөр, цагийг байнга өөрчлөх, хойшлуулах, хүүхдэд нөгөө талын талаар сөрөг мэдээлэл өгөх, уулзахаас айх, дургүйцэх хандлага төлөвшүүлэх замаар шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийж байна. Үүнд ногдуулах тодорхой, шаталсан хариуцлагын механизм дутагдалтай байгаа тул шийдвэр гүйцэтгэгчид хүүхдийн эрхийг зөрчихөөс эмээж албадлагын арга хэрэглэхээс зайлсхийдэг бөгөөд эцэст нь "шийдвэр байгаа ч хэрэгжилтгүй" байдал үүсэх нь элбэг байна.

Гуравдугаарт, Мэргэшсэн дэмжих бүтэц сул, тогтолцооны уялдаа муу байх: Уулзах эрхийн маргааныг шийдвэрлэхэд нийгмийн ажилтан, сэтгэл зүйч болон гэр бүлийн зуучлагчийн оролцоо зайлшгүй шаардлагатай боловч Улаанбаатар хотоос бусад орон нутагт ийм мэргэжлийн нөөц хомс байна. Шүүх болон шийдвэр гүйцэтгэх байгууллагатай тогтмол уялдаатай ажилладаг суурь бүтэц бүрдээгүй бөгөөд хүүхэд хамгааллын байгууллага, сургууль, эрүүл мэндийн байгууллагын хооронд мэдээлэл солилцох албан ёсны протокол сул байна. Асуудлыг зөвхөн "шүүх-гүйцэтгэгч-эцэг эх" гэсэн явцуу хүрээнд шийдвэрлэх гэж оролдсоноор хүүхдийн сэтгэл зүйн хэрэгцээ орхигдож, маргаан урт хугацаанд үргэлжлэх, хурцдах нөхцөл бүрдэж байна.

2.1.5.3 Нийгэм-соёлын хүчин зүйл болон эрх зүйн хэрэгжилтийн зөрчил

Монгол Улсын уламжлалт соёл болон орчин үеийн нийгмийн өөрчлөлт уулзалтын эрхийн хэрэгжилтэд давхар нөлөө үзүүлж байна.

Гэр бүлийг ямар ч үнээр хамаагүй хадгалах, "хүүхдийн төлөө тэвчих" гэсэн уламжлалт хандлага нь: салалтыг нийгмийн зүгээс сөргөөр хүлээн авах; салалтын дараа эцэг, эхийн нэг тал хүүхдийг "өөрийн талдаа авах", нөгөө талтай уулзуулахгүй байхыг хувийн "ялалт" гэж үзэх зэрэг сөрөг илрэлүүдийг дагуулж байна.

Эцэг, эхийн үүргийг хүйсээр заагласан хэвшмэл ойлголт ("хүүхэд заавал ээжтэйгээ үлдэх ёстой", "аав нь зөвхөн эдийн засгийн дэмжлэг үзүүлэх ёстой") нь уулзалтын эрхийн талаарх хандлагад нөлөөлж: уулзалтын эрхийг хүүхдийн эрх гэхээс илүү эцэг, эхийн хоорондын маргааны зэвсэг болгон ашиглах; хамтын эцэг, эхийн (co-parenting) ойлголт төлөвшихөд саад болж байна.

Хүүхдийн эрхийн талаарх ойлголт сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа ч практикт "хүүхдийг маргаанд татахгүй" гэсэн нэрийн дор түүний дуу хоолойг бүрэн хаах, эсхүл эсрэгээрээ эцэг, эхийн нэг тал өөрийн байр сууриа хамгаалахын тулд хүүхдийн саналыг ашиглах зэрэг хоёр туйлшрал ажиглагддаг.

Эдгээр нийгэм-соёлын хүчин зүйлүүд нь дээрх эрх зүй, институтийн сул талуудтай нэгдэж, Монгол Улсад уулзалтын эрхийн бодит хэрэгжилтийг сааруулж, "хуульд заасан эрх – амьдрал дээрх эрх" хоорондын зөрчил үүсгэж байна.

Дүгнэж хэлбэл, Монгол Улсын уулзалтын эрхийн тогтолцооны оношлогооноос үзэхэд: эрх зүйн зохицуулалтын тодорхой бус байдал, шүүхийн практик болон гүйцэтгэлийн үр нөлөөгүй байдал, мэргэшсэн нийгмийн дэмжлэг дутмаг байгаа болон уламжлалт соёлын зөрчилдөөн нь хүүхдийн уулзалтын эрхийг бодитой хэрэгжүүлэхэд гол саад болж байна.

2.2 Хятад Улсын уулзалтын эрхийн эрх зүйн тогтолцоо ба практик шинжилгээ

2.2.1 Хятад улсын гэр бүлийн эрх зүйн хөгжлийн тойм

2.2.1.1 Уламжлалт гэр бүлийн эрх зүйн түүхэн суурь

Хятад улсын уламжлалт нийгэмд гэр бүл нь Конфуци-ийн ёс суртахууны сургаалд тулгуурласан, эрэгтэй төвтэй бүтэцтэй байв. “Хүндэтгэл” (孝, xiao) хэмээх зарчим нь хүүхдийн эцэг, эхдээ захирагдах, тэднийг хүндэтгэх үүргийг хүчтэй онцолж, гэр бүлийн дотоод харилцаанд эцгийн эрх мэдэл давамгайлж байсан. Уламжлалт хууль зүйд (жишээлбэл, Цин улсын хууль цааз) гэр бүл, ураг төрлийн харилцааг зохицуулах заалт байсан ч хүүхдийн эрхийг бие даасан субъект байдлаар харахаас илүү эцэг, эхийн эрх, үүрэг, гэр бүлийн эрэмбэ, ёс суртахууны хэм хэмжээ-ийг хамгаалах зорилго давамгайлж байжээ.

Салалт нь уламжлалт Хятадад нэн ховор, шалтгаан хатуугаар хязгаарлагдсан, ихэвчлэн эрэгтэй талд илүү давуу эрх олгодог байсан. Энэ нөхцөлд дараах уулзалтын эрхийн тухай орчин үеийн ойлголт байхгүй, хүүхдийн хэнтэй амьдрах, нөгөө талтайгаа уулзах асуудал нь гэр бүл, овог аймгийн дотоод шийдвэр, ёс суртахууны хэм хэмжээгээр шийдэгддэг байв.

2.2.1.2 Социалист үе ба шинэ Хятад улсын гэр бүлийн эрх зүйн өөрчлөлт

1949 онд Хятад Улс байгуулагдсаны дараа Хятад улсын гэр бүлийн эрх зүй суурь шинэтгэлд орж, 1950 оны “Гэр бүлийн тухай хууль” нь уламжлалт журмыг халж, эр, эмийн эрх тэгш байдал, гэрлэлтийн сайн дурын байдал, нэг эхнэр-нэг нөхрийн зарчмыг хуульчлан тогтоосон. Энэ хууль нь гэрлэлтийг төрийн бүртгэлтэй, албан ёсны гэрээт харилцаа болгон үзэж, гэрлэлт цуцлалтын нөхцөлийг тодорхойлж, хүүхдийн асран хамгаалалт, тэжээн тэтгэхтэй холбоотой суурь зохицуулалт хийсэн.

Социалист үеийн гэр бүлийн эрх зүйн гол зорилго нь феодалын үлдэгдлийг арилгах, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, социалист ёс суртахууны дагуу гэр бүл төлөвшүүлэх байв. Гэвч энэ үед ч хүүхдийн эрхийг орчин үеийн утгаар бие даасан субъект гэж бус, илүүтэй гэр бүлийн нэг хэсэг, хамгаалалт шаардсан объект гэж үзэх хандлага зонхилж байлаа.

1980 онд шинэ “Гэр бүл, гэрлэлтийн тухай хууль” (婚姻法) батлагдаж, 2001 онд томоохон нэмэлт, өөрчлөлт орсноор Хятад улсын гэр бүлийн эрх зүй зах зээлийн эдийн засаг, нийгмийн шинэ нөхцөлд илүү нийцэх чиглэл рүү хөгжсөн. Энэ хуульд:

- Шалтгааныг өргөтгөж, гэр бүлийн хүчирхийлэл, байнгын зөрчил, салах буюу эвлэрэх боломжгүй харилцаа зэргийг тусгасан;
- Хүүхдийн эрх, эцэг, эхийн хариуцлагыг илүү тодорхой болгосон;
- Гэр бүлийн хамтын өмч, эд хөрөнгийн хуваарилалтын талаар нарийвчилсан заалт оруулсан.

Гэвч хүүхдийн уулзалтын эрхийн талаар тусгай заалт энэ үед бараг үгүй байсан бөгөөд хүүхэдтэй хамт амьдрахгүй болж буй талын хүүхэдтэйгээ уулзах, харилцах асуудлыг шүүхийн практик, дотоод журам, талуудын тохиролцоонд үлдээдэг байв.

2.2.1.3 Иргэний хуулийн батлалтаар бүрэлдсэн орчин үеийн суурь бүтэц

2020 онд Хятад Улс анхны Иргэний хуулиа (民法典) баталж, 2021 оноос мөрдөж эхэлсэн нь гэр бүлийн эрх зүйн хөгжилд томоохон эргэлт болсон. Иргэний хуулийн “Гэр бүл”-ийн хэсэг нь өмнөх “Гэрлэлтийн тухай хууль”-ийг өөртөө нэгтгэж, гэр бүлийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг илүү системтэй, нэгдмэл болгосон.

Иргэний хуульд гэр бүл байгуулах, цуцлах журам, эцэг, эхийн эрх, үүрэг, хүүхдийн эрх, асран хамгаалалт, тэжээн тэтгэх, уулзалтын эрх(探望权), гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах зэрэг асуудлыг нэг цул бүтэцтэйгээр зохицуулжээ.

Асран хамгааллын тогтолцооны хувьд Иргэний хууль нь насанд хүрээгүй хүүхдийн асран хамгаалалтыг нэлээд бүрэн хэмжээнд зохицуулсан байдаг. Ерөнхий зарчмаар эцэг, эх нь насанд хүрээгүй хүүхдийн анхны буюу нэгдүгээр дарааллын асран хамгаалагч бөгөөд хүүхдийнхээ биеийн болон сэтгэл зүйн аюулгүй байдал, боловсрол, эд хөрөнгийн эрх ашгийг бүхэлд нь хамгаалах үүрэг хүлээнэ.

Эцэг, эхийн нэг нь нас барсан, сураггүй болсон, сураггүйд тооцогдсон, иргэний бүрэн эсхүл хязгаарлагдмал эрх зүйн чадамжгүйд тооцогдсон, эсвэл өөр шалтгаанаар асран хамгаалах үүргээ бодитоор гүйцэтгэх боломжгүй болсон бол нөгөө тал нь дангаар асран хамгаалах үүргийг хүлээнэ. Эцэг, эх хоёулаа асран хамгааллын үүргээ хэрэгжүүлэх

боломжгүй үед өвөө, эмээ, ах, эгч зэрэг ойрын хамаатан садан хоорондоо зөвшилцөн асран хамгаалагчийг тодорхойлох, зөвшилцөлд хүрэх боломжгүй, эсвэл дарааллын дагуу нэр дэвших хүмүүс нь асран хамгаалагчийн нөхцөлийг хангахгүй бол оршин суугчдын хороо, тосгон, багийн хороо, эсхүл иргэний хэргийн асуудал эрхэлсэн байгууллага шүүхэд хандан асран хамгаалагчийг шүүхээр томилуулах эрхтэй.

Асран хамгаалагчийн шалгуурын хувьд Иргэний хууль нь асран хамгаалагчийг заавал бүрэн эрх зүйн чадамжтай, асран хамгаалах чадвар, хүсэл эрмэлзэлтэй, мөн хүүхдийн бие махбод, сэтгэл зүйд сөргөөр нөлөөлөх хүчирхийлэл, хаях, ноцтой хүч хэрэглэсэн байдал, мансууруулах бодис хэрэглэх, мөрийтэй тоглох зэрэг зан үйлийн сөрөг түүхгүй байх ёстой гэж тогтоожээ. Асран хамгаалагч асран хамгаалах үүргээ биелүүлэхээс ноцтойгоор татгалзсан, эсвэл асран хамгаалж буй хүүхдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг зөрчсөн тохиолдолд ашиг сонирхол бүхий этгээд, суурь нэгж, иргэний хэрэг, халамжийн байгууллагууд шүүхэд хандан түүний асран хамгаалагчийн эрхийг хүчингүй болгуулах, шүүхээс асран хамгаалагчийг өөрчилж, шинээр томилох шийдвэр гаргах боломжтой.

Уулзалтын эрхийн тухай тусгай заалтуудыг бий болгож, хамт амьдрахгүй болсон эцэг, эхийн нэг нь хүүхэдтэй уулзах, харилцах эрхтэй, нөгөө тал нь үндэслэлгүйгээр саад учруулах ёсгүйг Иргэний хуульд тодорхой зааж, уулзалтын эрхийг хүүхдийн эрх ашигт нийцүүлэн хэрэгжүүлэхийг шаардсан. Мөн шүүх уулзалтын тодорхой хуваарь, арга хэлбэр тогтоож болох, хүүхдийн эрх ашигт ноцтой хор уршиг учирч болзошгүй тохиолдолд уулзалтын эрхийг түр хугацаагаар хязгаарлах, зогсоох, нөхцөл байдал өөрчлөгдвөл уулзалтын журмыг өөрчлөх, сэргээх боломжтой зэрэг агуулгыг хуульчилсан.

Үүнээс гадна Дээд шүүхээс гаргасан шүүхийн тайлбар, удирдамж баримт бичгүүд нь Иргэний хуулийн заалтыг тайлбарлаж, уулзалтын эрхийн маргаанд шүүх ямар шалгуур баримтлах, хүүхдийн эрх ашгийг хэрхэн үнэлэх, шийдвэр гүйцэтгэлийг яаж хангах, асран хамгаалагчийг томилох, өөрчлөхдөө ямар хүчин зүйлийг харгалзах талаар практик чиглэл өгдөг. Зарим бүс нутагт гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тусгай танхим байгуулж, гэр бүлийн шүүхийн мэргэшсэн тогтолцоо, эвлэрүүлэн зуучлал, сэтгэл зүйн үйлчилгээ, нийгмийн ажилтны оролцоо, насанд хүрээгүй хүний эрхийг хамгаалах байгууллагын оролцоог нэгтгэсэн загварыг туршиж байна.

Ийнхүү Хятад улсын гэр бүлийн эрх зүйн хөгжлийг тоймлон үзвэл: уламжлалт загвараас социалист үеийн эрх зүйн тэгш байдлыг тунхагласан загвар руу, улмаар Иргэний хуульд тулгуурласан хүүхдийн эрхийг илүү тодорхой хамгаалах, асран хамгааллын тогтолцоог нарийвчлан хөгжүүлэх, асран хамгаалагчийн шаардлагыг бодитоор шалгах, уулзалтын эрхийг тусгай болгон хуульчлах үе шаттай шилжилт явагджээ. Энэ суурь бүтэц нь дараагийн хэсэгт Хятад улсын асран хамгаалалт болон уулзалтын эрхийн нарийвчилсан зохицуулалт, шүүхийн практикийг Монгол Улсын нөхцөлтэй харьцуулан судлах үндэс болно.

2.2.2 БНХАУ-ын Иргэний хууль дахь хүүхдийн эрхийн зохицуулалт (Асрамж, тэжээн тэтгэлэг, уулзах эрх)

БНХАУ-ын Иргэний хуулийн 1084 дүгээр зүйлд гэрлэлт цуцалсны дараах хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэхдээ 2 хүртэлх насны хүүхдийг эхэд нь үлдээх ерөнхий зарчим баримтлахаас гадна, 8-аас дээш насны хүүхдийн саналыг заавал харгалзан үзэхээр хуульчилсан нь хүүхдийн оролцооны эрхийг өндөр түвшинд хангаж байна. Түүнчлэн хуулийн 1085 дугаар зүйлд тэжээн тэтгэлгийн хэмжээг эцэг эхийн тогтмол орлогын тодорхой хувиар хувьцлан тогтоож, боловсрол, эрүүл мэндийн нэмэлт зардлыг хуваарилахаар заасан нь Монгол Улсын одоогийн зохицуулалтаас илүү нарийвчилсан, хэрэгжих боломж өндөртэй байна. Эдгээр асрамж, тэжээн тэтгэлгийн зохицуулалт нь хуулийн 1086 дугаар зүйлд заасан уулзалтын эрх-ийн хэрэгжилттэй салшгүй холбоотой тул дараах байдлаар харьцуулан шинжлэх үндэслэл болж байна.”

2.2.2.1 Уулзалтын эрхийн хууль зүйн тодорхойлолт, агуулга

Хятад Улс ын Иргэний хууль-д “уулзалтын эрх” (探望权) гэдгийг хүүхэдтэйгээ хамт амьдардаггүй эцэг эсвэл эхийн тухайн хүүхэдтэй уулзах, харилцах эрхийн нэг хэлбэр хэмээн тодорхойлсон байдаг. Холбогдох заалтуудаас үзвэл уулзалтын эрхийн агуулгад хүүхэдтэй тодорхой хугацаанд, тогтоосон газар, тодорхой нөхцөлтэйгөөр биечлэн уулзах, хамт байх боломж; утас, цахим шуудан, нийгмийн сүлжээ, видео дуудлага зэрэг орчин үеийн холбооны хэрэгслээр дамжуулан тогтмол харилцаатай байх эрх; зарим шүүхийн тайлбарын дагуу хүүхдийн сургууль, эрүүл мэнд, амьдралын нөхцөл байдлын талаар зохих түвшний мэдээлэл авах эрх багтаж байна. Иймээр уулзалтын эрхийг зөвхөн “уулзаж байгаа агшин” төдий бус, эцэг, эх хүүхдийн амьдралтай тогтвортой холбоотой байж, харилцаагаа үргэлжлүүлэх эрхийн нэг хэсэг хэмээн ойлгодог.¹

Хуульд уулзалтын эрхийг хэрэгжүүлэхдээ “хүүхдийн эрх ашиг нэн тэргүүнд байх” зарчмыг заавал баримтлах ёстой гэж тусгасан тул уулзалтын хэлбэр, давтамж, тодорхой агуулгыг тогтоох үед шүүх болон эцэг, эх хоёр тал хүүхдийн нас, эрүүл мэндийн байдал, сурлагын нөхцөл, амьдрах орчин, сэтгэлзүйн хэрэгцээг бүрэн харгалзан үзэх үүрэг хүлээнэ.²

2.2.2.2 Уулзалтын эрхийг хэрэгжүүлэх журам, шүүхийн хамгаалалт

(1) Хэлэлцээр, шүүхийн баталгаажуулалт

Иргэний хуулиар үед эцэг, эх асран хамгаалалт, тэжээн тэтгэх, уулзалтын эрхийн талаар тохиролцоо (协议) хийхийг дэмждэг. Талуудаас гаргасан тохиролцоог шүүх баталж, шийдвэрийн нэг хэсэг болгон оруулж болно. Энэ тохиолдолд уулзалтын хуваарь, хэлбэрийг илүү уян хатан тогтоох, талуудын бодит нөхцөл байдалд нийцүүлэх боломжтой.

Харин тохиролцоо хийх боломжгүй, эсхүл тохиролцоо хийх оролдлого бүтэлгүйтвэл шүүх:

¹ 杨立新:《民法典婚姻家庭编释义与适用》,中国法制出版社,2021.

² 孙国华:《婚姻家庭法》,法律出版社,2016.

- Уулзалтын тодорхой хугацаа, давтамж, газар, арга хэлбэрийг тогтоож;
- Хүүхдийн эрх ашигт нийцсэн эсэхийг шалгаж;
- Шаардлагатай бол үе шаттай хэрэгжүүлэх хуваарь гаргаж шийдвэрлэнэ.

(2) Шүүхэд хандах эрх, журам

Хүүхэдтэй хамт амьдарч буй тал нь нөгөө талын уулзалтын эрхийг үндэслэлгүйгээр хязгаарласан, саад учруулсан тохиолдолд, эсрэг тал шүүхэд уулзалтын эрхээ хэрэгжүүлэхийг шаардаж нэхэмжлэл гаргах эрхтэй. Иргэний хуулийн дагуу:

- Шүүх уулзалтын эрхийн бодит хэрэгжилтийг хангахын тулд шинэ журам тогтоох, өмнөх шийдвэрийг тодруулах, өөрчлөх боломжтой;
- Нөхцөл байдал өөрчлөгдсөн (хүүхдийн нас, эрүүл мэнд, эцэг, эхийн амьдралын нөхцөл өөрчлөгдсөн) бол уулзалтын журмыг дахин хянаж, өөрчлөх нэхэмжлэлийг хүлээн авч хэлэлцэнэ.

Шүүхэд хандах энэ зам нь уулзалтын эрхийг албан ёсны эрх зүйн хамгаалалтаар хангах гол механизм бөгөөд Хятад улсын шүүхийн практикт уулзалтын эрхийг бие даасан нэхэмжлэл байдлаар авч үзэх тохиолдол нэмэгдэж байна.

(3) Гэр бүлийн шүүх, эвлэрүүлэн зуучлалын оролцоо

Сүүлийн жилүүдэд Хятад Улсад олон шүүх дээр гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тусгай танхим (家事法庭) байгуулж, гэр бүлийн маргааныг мэргэшсэн шүүгчид, тусгай журамтайгаар шийдвэрлэх болсон. Энэ хүрээнд:

- Шүүхийн өмнөх шатанд эвлэрүүлэн зуучлал (调解)-ыг өргөн хэрэглэж;
- Уулзалтын эрхийн талаар талуудын тохиролцоог зуучлалын аргаар тодорхой болгох;
- Хүүхдийн эрх ашигт нийцсэн, хэрэгжих боломжтой хуваарь гаргахыг зорьдог.

Зарим бүс нутагт нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, сурган хүмүүжүүлэгчийг гэр бүлийн шүүхийн ажиллагаанд тусгайлан оролцуулж, уулзалтын эрхийн шийдвэрийн үед хүүхдийн сэтгэлзүйн байдал, гэр бүлийн харилцааны динамикийг мэргэжлийн түвшинд үнэлэх оролдлого хийж байна.

2.2.2.3 Уулзалтын эрхийг хязгаарлах, зогсоох хууль зүйн үндэслэл

Иргэний хуульд уулзалтын эрхийг хүүхдийн эрх ашигт нийцүүлэх үүднээс тодорхой тохиолдолд хязгаарлах, зогсоох боломжийг хуульчилсан. Үүнд:

- Уулзалтын явцад хүүхдийн бие махбодын, сэтгэлзүйн аюулгүй байдалд ноцтой хор уршиг учирч болзошгүй;
- Уулзалтын эрхийг ашиглан хүүхдэд хүчирхийлэл үйлдэх, сэтгэлзүйн дарамтад оруулах, нөгөө эцэг, эхийн эсрэг өдөөн хатгах;
- Хүүхдийг хууль бус үйл ажиллагаанд татан оролцуулах;
- Архидалт, мансууруулах бодис хэрэглэх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зэрэг ноцтой амьдралын хэв маяг тогтоогдсон зэрэг нөхцөлд шүүх уулзалтын эрхийг түр хугацаагаар хязгаарлах, эсхүл бүрэн зогсоох шийдвэр гаргаж болно.

Шүүхийн тайлбаруудад уулзалтын эрхийг хязгаарлах, зогсоох нь онцгой, эцсийн арга хэмжээ гэж тодорхойлдог. Ийм шийдвэр гаргахдаа:

- Хүүхдийн нас, сэтгэлзүйн байдал;
- Уулзалтын үеийн нөхцөл байдал;
- Эцэг, эхийн өнгөрсөн үйлдэл, эрсдэлийн түвшин;
- Уулзалтыг хяналттай, гуравдагч этгээдийн оролцоотойгоор явуулах боломжтой эсэх зэргийг иж бүрнээр үнэлэхийг шаарддаг.

Мөн нөхцөл байдал сайжирч, уулзалтын эрхийг сэргээх боломжтой болсон гэж үзвэл талын хүсэлтээр эсхүл шүүх өөрийн санаачилгаар уулзалтын эрхийг үе шаттайгаар сэргээх, хяналттай уулзалт хэлбэрээр эхлүүлэх шийдвэр гаргаж болно. Ингэснээр уулзалтын эрхийг бүр мөсөн хасах бус, хүүхдийн эрх ашгийг хамгаалсан нөхцөлд аажмаар сэргээх бодлогыг баримталж байгааг харж болно.

Ийнхүү Хятад Улсын эрх зүйн тогтолцоонд уулзалтын эрхийг Иргэний хуульд тусгайлан хуульчилж, агуулга, хэрэгжүүлэх журам, хязгаарлалт, сэргээх боломжийг харьцангуй нарийвчлан зохицуулсан нь Монгол Улсын одоогийн ерөнхий, зарчмын түвшний зохицуулалттай тодорхой ялгаатай байна. Дараагийн хэсэгт Хятад улсын шүүхийн практик, шийдвэр гүйцэтгэлийн бодит байдалд энэ зохицуулалт хэрхэн хэрэгжиж буйг авч үзнэ.

2.2.3 Шүүхийн практик, гүйцэтгэлийн асуудлууд

2.2.3.1 Шүүхийн практикийн ерөнхий чиг хандлага

Хятад Улсын шүүхийн шийдвэрийн нээлттэй мэдээллийн сангаас харахад (жишээлбэл, [中国裁判文书网](#) зэрэг) маргаанд уулзалтын эрхтэй холбоотой маргаанууд сүүлийн жилүүдэд тогтвортой өсөх чиг хандлагатай байна. Уулзалтын эрхийн маргаан нь:

- Анх удаа уулзалтын журмыг тогтоолгох;
- Өмнө тогтоосон журмыг өөрчлүүлэх, тодруулах;
- Уулзалтад саад болж буй талд албадлагын арга хэмжээ авах;
- Уулзалтын эрхийг хязгаарлах, зогсоох;
- Уулзалтын эрхийг сэргээх зэрэг хэлбэрээр шүүхэд хандах байдлаар илэрдэг.

Шүүхийн шийдвэр, тогтоолоос харахад Хятад Улсын шүүхүүд уулзалтын эрхтэй холбоотой маргааныг шийдвэрлэхдээ гол төлөв дараах зарчмыг баримталж байна.

1. “Хүүхдийн эрх ашиг нэн тэргүүнд байх” зарчим. Шүүх шийдвэрийн үндэслэлдээ хүүхдийн нас, эрүүл мэндийн байдал, сургуульд суралцах нөхцөл, амьдрах орчин, эцэг, эхийн хүмүүжүүлэх чадвар, хүчирхийлэл байгаа эсэх зэрэг хүчин зүйлийг заавал авч үзэж, үүний үндсэн дээр уулзалтын журам, давтамжийг тогтоодог.

2. Хамтарсан эцэг, эхийн оролцоог дэмжих, хүүхэд эцэг, эхтэйгээ нь холбоотой байх эрхийг хангах чиг баримжаа. Ерөнхийдөө гэр бүлийн хүчирхийлэл болон бусад ноцтой эрсдэл байхгүй тохиолдолд шүүх уулзалтын эрхийг аль болох бүрэн хэмжээнд хангахыг хичээж, нэг талын гаргасан “уулзалтыг бүрэн хориглох” хүсэлтийг амархан хүлээн зөвшөөрдөггүй.

3. Уулзалтын эрхийн цагийн хуваарь, зохион байгуулалтыг нэлээд нарийн тогтоох. Олон хэрэгт шүүх уулзалтын өдөр, цаг, газар, хүүхдийг хэн авч очих, хэн буцаан хүргэх,

хэдий хугацаагаар хамт байх, мөн баяр ёслол, амралтын өдрүүдэд уулзах хуваарийг тодорхой тусган, цаашдын гүйцэтгэлийг аль болох хүндрэл багатай байлгахыг зорьдог.

2.2.3.2 Төлөөлөл бүхий шүүхийн шийдвэр, практикийн онцлог

Төлөөлөл бүхий маргаанаас харахад Хятад улсын шүүхийн практикт дараах онцлог ажиглагдана.

(1) Хүүхдийн санал бодлыг системтэй тусгах оролдлого

Шүүхүүд тодорхой наснаас дээш хүүхдээс (ихэвчлэн 8–10 наснаас дээш) уулзалтын талаарх санал бодлыг нь асуух, тусгай өрөөнд, шүүгч эсхүл нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн оролцоотойгоор ярилцлага хийх, ярилцлагын агуулгыг шийдвэрийн үндэслэлд тусгах хандлага нэмэгдэж байна. Гэвч хүүхдийн санал бодлыг “шууд хүсэл” төдий бус, сэтгэлзүйн нөлөөлөл, эцэг, эхийн нөлөөллийг харгалзан, мэргэжлийн үнэлгээний хамт дүгнэх шаардлага байгааг олон шүүхийн тайлбар тэмдэглэжээ.

(2) Уулзалтын эрхийн үе шаттай гүйцэтгэлийн загвар

Зарим маргаанд шүүх уулзалтын эрхийг шууд бүрэн хэрэгжүүлэхээс илүү хуваарь тогтоодог. Жишээлбэл:

- Эхний хэдэн сар богино хугацааны, гуравдагч этгээдийн хяналттай уулзалт;
- Дараагийн шатанд хугацааг уртасгах, хүүхдийг богино хугацаагаар хамт байлгах;
- Эцэст нь, хүүхдийн сэтгэлзүй тогтвортой болсны дараа энгийн уулзалтын хуваарьт шилжих.

Ийм загвар нь ялангуяа удаан хугацаанд уулзаагүй байсан эцэг, эх, сэтгэлзүйн эмзэг хүүхэдтэй холбоотой маргаанд ашиглагдаж байна.

(3) Уулзалтын эрхийг хязгаарлах, зогсоохдоо өндөр шалгуур тавих

Хүчирхийлэл, архидалт, мансууруулах бодисын хэрэглээ, хүүхдийг ашиглах ноцтой үйлдэл тогтоогдоогүй нөхцөлд шүүх уулзалтын эрхийг бүрэн зогсоохоос зайлсхийж, ихэвчлэн хяналттай уулзалт, уулзалтын давтамжийг багасгах, гуравдагч этгээдийн байлцуулалттай уулзах зэрэг зөөлөн арга хэмжээ хэрэглэдэг. Уулзалтын эрхийг бүрэн зогсоосон маргаанд шүүх шийдвэрийн үндэслэлд эрсдэлийн ноцтой түшинг нягт нотлон, хүүхдийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж буйгаа онцолдог.

2.2.3.3 Шийдвэр гүйцэтгэлийн бэрхшээл ба институтийн хариу арга хэмжээ

Хэдийгээр Иргэний хууль болон холбогдох шүүхийн тайлбарууд уулзалтын эрхийн зохицуулалтыг харьцангуй нарийвчилж, гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоо тодорхой ахиц гаргасан боловч шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн шатанд Хятад Улсад мөн л “уулзалтын эрхийн гүйцэтгэлийн бэрхшээл” нийтлэг асуудал хэвээр байна.

1. Хүүхэдтэй хамт амьдарч буй талын эсэргүүцэл ба бодит хяналтын чадавх. Монгол Улстай адил, Хятад Улсад ч хүүхэдтэй хамт амьдарч буй тал уулзалтыг саатуулах, хүүхдийн нүдэнд нөгөө талыг “муугаар харагдуулах”, урьдчилан тохирсон уулзалтын өдрийг дахин дахин хойшлуулах зэрэг хэлбэрээр уулзалтын эрхэд саад учруулах нь элбэг. Ийм нөхцөлд шийдвэр гүйцэтгэгчид хүүхдийн эрх ашиг, сэтгэлзүйн байдлыг харгалзан үзэхийн зэрэгцээ хүүхдийг хүч хэрэглэн авч яваад нөгөө талтай уулзуулах боломжгүй

учир, хууль зүйн албадлагын арга хэмжээ авахдаа ихэвчлэн маш болгоомжтой хандахаас аргагүй болдог.

2. Албадлагын арга хэмжээ ба нийгмийн зээлийн механизмыг хэрэглэх нөлөө. Дээрх хүндрэлд хариу өгөхийн тулд Хятад Улсын зарим шүүх, бүс нутагт олон төрлийн албадлагын арга хэмжээ хэрэглэж байна. Үүнд: шүүхийн шийдвэрийг удаа дараа биелүүлээгүй этгээдэд торгууль ногдуулах, албадан гүйцэтгэлийн ажиллагаа эхлүүлэх; шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэхээс татгалзсан талын нэрийг “найдваргүй этгээдийн жагсаалт”-д бүртгэн, тэдний зээл авах, өндөр үнэтэй хэрэглээ хийх, гадаадад зорчих зэрэг боломжийг хязгаарлах; тухайн этгээдийн талаар ажлын газар, орон нутгийн захиргаанд мэдээлж, тодорхой хэмжээний нийгмийн дарамт бий болгох гэх мэт орно.

Уулзалтын эрхийн хэрэгт эдгээр албадлагын арга хэмжээг ихэвчлэн дараах нөхцөлд хэрэглэж байна. Тухайлбал, маргаантай тал шүүхийн тогтоосон уулзалтын журмыг удаа дараа биелүүлэхгүй байх, үндэслэлгүйгээр уулзалтад саад хийх, эсвэл уулзалтын явцад уулзалтын эрхийг ашиглан хүүхэд болон нөгөө эцэг, эхэд хүчтэй сэтгэлзүйн дарамт үзүүлэх, дайсагнах зэргээр уулзалтын эрхийг ноцтойгоор буруугаар ашигласан тохиолдолд эдгээр арга хэмжээг авч байна.

Өөрөөр хэлбэл, ийм албадлагын арга хэмжээ нь зөвхөн “шийдвэрийг биелүүлэх”-ийг баталгаажуулах төдийгүй “уулзалтын эрхийг санаатайгаар зөрчих, буруугаар ашиглах” зан үйлийг хориглох зорилготой болжээ.

3. Олон талт дэмжлэг ба гэр бүлийн үйлчилгээний тогтолцоо. Хятадын зарим хот болон илүү хөгжсөн бүс нутагт гэр бүлийн шүүхийн дэргэд гэр бүлийн үйлчилгээний төв байгуулж, уулзалтын эрхийн гүйцэтгэлийг дэмжих зорилгоор, жишээлбэл: хүүхдийн сэтгэлзүйн зөвлөгөө өгөх; эцэг, эхийн харилцааг сайжруулах бүлгийн сургалт зохион байгуулах; мэргэжлийн түвшинд эвлэрүүлэн зуучлал хийх; тусгайлан тохижуулсан уулзалтын өрөө, орчин бүрдүүлэх зэрэг үйлчилгээг үзүүлж байна. Энэ нь тодорхой хэмжээнд уулзалтын эрхийг “цаасан дээрх хууль зүйн заалт”-аас өдөр тутмын амьдрал дахь бодит эрх болгон хэрэгжүүлэхэд дөхөм болж байгаа хэдий ч бүс нутгийн хөгжлийн ялгаа их тул хөдөө, алслагдсан газарт ийм үйлчилгээ тун ховор хэвээр байна.

Иймээс Хятадын туршлагаас дүгнэн үзвэл, уулзалтын эрхийн эрх зүйн зохицуулалт, гэр бүлийн шүүхийн тогтолцоо, гүйцэтгэлийн албадлагын арга хэмжээ, нийгмийн дэмжлэгийн механизмуудын хувьд тодорхой ахиц гарсан боловч бодит практикт “эрхийг хуульд тунхагласны” ба “эрхийн бодит хэрэгжилтийн” хоорондох зөрчил бүрэн арилжээ гэж хэлэхийн аргагүй байна. Нөгөө талаар, уулзалтын эрхийг санаатайгаар зөрчих, давтан саад учруулсан талд хүлээлгэх хариуцлага харьцангуй тодорхой: торгууль, найдвартгүй этгээдийн жагсаалт, тодорхой тохиолдолд шүүхийн сахилгын болон шийтгэлийн арга хэмжээ хүртэл хэрэглэгдэж байна. Гэвч судлаачдын тэмдэглэсэнээр, эдгээр арга хэмжээ нь гэр бүлийн дотоод зөрчил, эцэг эхийн хоорондын хурцадмал байдлыг улам нэмэгдүүлэх, хүүхдийг хоёр талын сөргөлдөөний төв цэг болгож, шинэ эрсдэл дагуулах магадлалтай.

Ийм нөхцөл байдал нь Монгол Улсад уулзалтын эрхийн шийдвэр гүйцэтгэлийг сайжруулах, түүнтэй холбоотой хариуцлагын механизмыг боловсронгуй болгохдоо

Хятадын туршлагыг болзолтойгоор, нягт шүүн тунгаан, хүүхдийн эрх болон нийгэм-соёлын онцлогт нийцүүлэн сонгомол байдлаар ашиглах шаардлагатайг харуулж байна.

2.2.4 Хятад улсын нийгэм-соёлын орчин, нийгмийн дэмжлэгийн тогтолцоо

2.2.4.1 Нийгэм-соёлын хүчин зүйл ба уулзалтын эрх

Хятад улсын нийгэм-соёлын орчинд гэр бүл, хүүхдийн байр суурь, салалтад хандах хандлага нь Конфуци-ийн уламжлал, социалист үеийн үзэл суртал, зах зээлийн шилжилтийн нөлөөгөөр олон давхар, зөрчилтэй шинжтэй.

Нэгдүгээрт, уламжлалт “гэр бүлийн эв, ураг төрлийн эв нэгдэл”-ийг эрхэмлэх хандлага хүчтэй хэвээр. Энэ нь нэг талаар салалтыг сөрөг, таагүй үзэгдэл гэж үзэх, нөгөө талаар дараа ч хүүхдийн эрх ашгийг бодож харилцааг тодорхой хэмжээнд хадгалах ёстой гэсэн ойлголттой огт зөрчилдөхгүй.

Гэвч зарим тохиолдолд асуудлыг хаалттай, гаднын оролцоогүй шийдэхийг илүүд үзэх нь уулзалтын эрхтэй холбоотой маргааныг нуух, шүүхэд хандахаас зайлсхийх нөхцөл бүрдүүлдэг.

Хоёрдугаарт, жендерийн уламжлалт хэвшмэл ойлголт нөлөөлсөөр байна. Хот суурин газарт эмэгтэйчүүдийн боловсрол, хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж, гэр бүлийн доторх эрх мэдэл тэнцвэржиж байгаа ч хөдөө, уламжлалт орчинд “хүүхэд эцгийн овог нэртэй, эцгийн гэр бүлд харьяалагдана” гэсэн хандлага, эсрэгээрээ “хүүхэд ээжтэйгээ үлдэх ёстой” гэсэн нийтлэг ойлголт зэрэгцэн оршдог. Энэ нь уулзалтын эрхийг хүүхдийн эрх гэхээс илүү эцэг, эхийн хоорондын өмчийн шинжтэй маргаан болгон харах эрсдэл дагуулж болзошгүй.

Гуравдугаарт, Хотжилт, шилжилт хөдөлгөөн, “гадаадад ажиллах” үзэгдэлтэй холбоотой “хараа хяналтгүй хүүхдийн” (留守儿童) асуудал Хятадад ихээхэн яригддаг. Эцэг, эх хөдөө, жижиг хотод хүүхдээ орхиод том хотод ажиллах, эсвэл нэг нь гадаадад гарах тохиолдолд хүүхдийн өдөр тутмын асрамж, уулзалтын асуудал улам төвөгтэй болж, уулзалтын эрх зөвхөн дараа бус, гэр бүлийн байршил заагдсан нөхцөлд ч хөндөгдөнө. Энэ нөхцөлд уулзалтын эрхийг зөвхөн эцэг, эхийн салалтаас үүдэлтэй маргаан гэж хязгаарлалгүй, хөдөлгөөнт нийгмийн нөхцөлд хүүхдийн эрхийг хамгаалах өргөн хүрээнд авч үзэх шаардлага гарч байна.³

2.2.4.2 Нийгмийн дэмжлэгийн тогтолцоо, гэр бүлийн үйлчилгээ

Хятад улсын засгийн газар сүүлийн жилүүдэд гэр бүл, хүүхэд хамгааллын үйлчилгээ, нийгмийн халамжийн тогтолцоог өргөжүүлэх бодлого баримталж байна. Үүнд:

(1) Гэр бүлийн үйлчилгээний төвүүд

Хот суурин газруудад “гэр бүлийн үйлчилгээний төв”, “эмэгтэйчүүд, хүүхдийн үйлчилгээний төв” зэрэг байгууллагыг байгуулж, гэр бүлийн зөвлөгөө, сэтгэлзүйн дэмжлэг, эцэг, эхийн боловсролын сургалт, хууль зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ санал болгож байна.

³ 赵晋:《探望权执行困境及其制度回应》,载《法学家》2018年第4期

Уулзалтын эрхийн практикт эдгээр төвүүдийг:

- өмнөх зөвлөгөө, мэдээлэл өгөх;
- дараа хүүхдийн сэтгэлзүйн дэмжлэг, эцэг, эхийн хамтын харилцааг дэмжих;
- гэр бүлийн шүүхийн дэргэд зуучлалын үйл ажиллагаанд оролцуулах зэрэг зорилгоор ашиглах хандлага нэмэгдэж байна.

(2) Эвлэрүүлэн зуучлал, олон нийтийн байгууллагын оролцоо

Хятадад “ард иргэдийн зуучлалын хороо” (人民调解委员会) гэх мэт уламжлалт олон нийтийн зуучлалын байгууллагыг шинэ нөхцөлд тохируулан ашиглах оролдлого хийгдэж, гэр бүлийн маргааныг шүүхийн өмнөх шатанд шийдвэрлэхийг дэмжиж байна.

Зарим нутагт уулзалтын эрхийн талаар эхний ээлжид олон нийтийн зуучлал хийж, тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд шүүхэд шилжүүлэх практик бий. Гэвч уулзалтын эрхийн нарийн, сэтгэлзүйн эмзэг асуудлыг мэргэжлийн бус түвшинд шийдэх эрсдэл, хүүхдийн эрхийн талаарх мэдлэг, ур чадварын хязгаарлалт хэвээр байна.

(3) Хүүхэд хамгааллын олон шатлалтай тогтолцоо

Хятад улсын хүүхэд хамгааллын тогтолцоонд иргэний хэрэг, нийгмийн халамж, боловсрол, эрүүл мэндийн салбарын оролцоо нэмэгдэж байгааг онцолж болно. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, үл хайхрах явдал илэрсэн тохиолдолд нийгмийн халамжийн байгууллага, цагдаа, сургууль, эмнэлэг зэрэг байгууллагууд мэдээлэл солилцох, хамтарсан хяналт тавих үүрэгтэй.

Уулзалтын эрхийн маргаанд эдгээр байгууллагын ажиглалт, дүгнэлт шүүхийн шийдвэр гаргахад туслах үүрэг гүйцэтгэж болох ч практикт уялдаа холбоо жигд биш, бүс нутгийн ялгаа их байна.

2.2.4.3 Нийгмийн хандлагын өөрчлөлт

Сүүлийн хорь гаруй жилд Хятадад хүүхдийн эрхийн талаарх нийгмийн ойлголт мэдэгдэхүйц өссөн. Хэвлэл мэдээлэл, олон улсын хамтын ажиллагаа, төрийн бодлогын нөлөөгөөр “хүүхдийн эрх ашиг нэн тэргүүнд байх”, “хүүхдийн дуу хоолойг сонсох” зэрэг ойлголт өргөн дэлгэрч, маргаанд ч хүүхдийн тухайн шийдвэрт оролцох эрхийг илүү их ярьж эхэлсэн.

Гэхдээ практикт:

- Зарим эцэг, эх уулзалтын эрхийг “өөрийн эрх” гэж үзээд, хүүхдийн хүсэл, хэрэгцээг хоёрдогч байранд тавих;
- Хүүхдэд нөгөө талын эсрэг хандлагыг бий болгож, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг саатуулах;
- Уулзалтын үеэр хүүхдэд хүчтэй сэтгэлзүйн дарамт үзүүлэх зэрэг үзэгдэл хэвээр байна.

Энэ нөхцөл олон нийтийн дунд:

- Уулзалтын эрхийн эрх зүйн утга, хүүхдийн эрхийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх;
- хамтын эцэг, эхийн соёлыг төлөвшүүлэх;
- “Хамтран хүүхэд өсгөх” (co-parenting) тухай эерэг жишээ, мэдээллийг түгээх

хэрэгцээ нэмэгдэж байна.

Нөгөө талаас, нийгэм-соёлын хандлагын өөрчлөлт нь хууль тогтоомжид дараах хүлээлтийг үүсгэж байна. Үүнд:

- Уулзалтын эрхийн эрх зүйн хамгаалалтыг илүү бэхжүүлэх,
- Хүүхдийн санал бодлыг илүү тодорхой журам, аргачлалаар тусгах,
- Гэр бүлийн шүүх, нийгмийн дэмжлэгийн тогтолцоог хөгжүүлэх,
- Шийдвэр гүйцэтгэлийн механизмыг илүү шударга, үр нөлөөтэй, хүүхдийн эрхэд ээлтэй болгох зэрэг орно.

Ийм нөхцөл байдал нь Монгол Улс, Хятад Улсын уулзалтын эрхийн тогтолцоог харьцуулахдаа зөвхөн хууль зүйн зохицуулалт, шүүхийн практик төдийгүй нийгэм-соёлын хандлага, нийгмийн дэмжлэгийн байдал, ирээдүйн хууль зүйн хүлээлтийг хамтад нь авч үзэх шаардлагатайг харуулж байна.

2.2.5 Хятад улсын уулзалтын эрхийн тогтолцооны давуу ба сул тал

2.2.5.1 Эрх зүйн түвшний давуу тал ба дутагдал

(1) Давуу тал

Нэгдүгээрт, Иргэний хуульд уулзалтын эрхийг тусгай, бие даасан институт болгон хуульчилж, энгийн “уулзах боломж” бус, тодорхой эрхийн байдлаар тогтоосон нь том давуу тал юм. Энэ нь уулзалтын эрхийг шүүхийн практикт тогтвортой хэрэглэгдэх, бие даасан нэхэмжлэл, хамгаалалтын сэдэв болох нөхцөлийг бүрдүүлдэг.

Хоёрдугаарт, Уулзалтын эрхийн агуулга, хэрэгжүүлэх журам, хязгаарлалт, сэргээх боломжийг харьцангуй нарийвчлан зохицуулсан. Хууль, шүүхийн тайлбар, удирдамж баримт бичигт уулзалтын хэлбэр, давтамж, хүүхдийн эрх ашгийг үнэлэх шалгуур, хязгаарлалтын нөхцөл зэргийг тодруулах оролдлого хийсэн нь эрх зүйн тодорхой байдал, урьдчилан таамаглах боломжийг нэмэгдүүлж байна.

Гуравдугаарт, Гэр бүлийн хэрэгт зориулсан шүүхийн мэргэшсэн тогтолцоо, эвлэрүүлэн зуучлал, гэр бүлийн үйлчилгээний системийг хууль зүйн зохицуулалттай уялдуулан хөгжүүлж буйн үр дүнд уулзалтын эрхийн шийдвэрийг зөвхөн “хууль зүйн акт” биш, нийгмийн дэмжлэг дагалдсан цогц шийдэл болгох чиг хандлага ажиглагдана.

(2) Дутагдал

Гэсэн хэдий ч эрх зүйн түвшинд зарим мэдрэгдэж буй дутагдал, Маргаандай тал бий. Жишээлбэл:

- Уулзалтын эрхийн ойлголтыг хүүхдийн эрх ба эцэг, эхийн эрхийн харилцаанд хэрхэн байршуулсан талаар онол-практикийн маргаан үргэлжилж байна;
- Уулзалтын эрхийн агуулга, хэлбэрийн тухай заалт нийтлэг түвшинд үлдэж, бүс нутгийн шүүх түүнийг өөр өөрөөр тайлбарлах боломж нээлттэй хэвээр;
- Хязгаарлалт, үгүйсгэлтэй холбоотой заалтыг “онцгой арга хэмжээ” гэж заасан ч практикт хэрэглэх шалгуур, мэргэжлийн үнэлгээний тогтолцоо үргэлж нэг төвшинд биш байна.⁴

⁴ 赵晋. 探望权执行困境及其制度回应[J]. 法学家, 2018(4).

2.2.5.2 Шүүхийн практик, гүйцэтгэлийн онцлог

(1) Давуу тал

Хятад улсын шүүхийн практикийн гол давуу тал нь:

- Уулзалтын эрхийн маргааныг бие даасан хэрэг болгон авч үзэх,
- Хүүхдийн эрх ашиг, санал бодлыг системтэй тусгах,
- Уулзалтын нарийвчилсан хуваарь, үе шаттай гүйцэтгэлийн загвар тогтоох,
- Гэр бүлийн шүүхийн мэргэшсэн бүрэлдэхүүн, эвлэрүүлэн зуучлал, нийгмийн ажилтны оролцоог ашиглах гэх мэтээр илэрдэг.

Шүүхийн шийдвэрийн үндэслэлд хүүхдийн эрх ашгийг тайлбарлаж, эцэг, эхийн хоорондын зөрчил нь “хүүхдийг нөгөө талтай уулзуулахгүй байх шалтгаан” биш гэж үзэж, хүүхдийн эрхэд хэрхэн нөлөөлж буй тал дээр төвлөрөх хандлага түгээмэл болох нь Монголтой харьцуулахад тодорхой дэвшил гэж үзэж болно.

(2) Сул тал

Гэвч шүүхийн практикт:

- Бүс нутгийн ялгаа их, том хот, хөгжингүй бүсэд мэргэшсэн тогтолцоо харьцангуй хөгжсөн, харин алслагдсан, бага нөөцтэй бүсэд уулзалтын эрхийг ерөнхий түвшинд шийдвэрлэдэг;
- Хүүхдийн санал бодлыг сонсох аргачлал, сэтгэлзүйн үнэлгээний чанар хэлбэрээс хэтрэхгүй үлдэх эрсдэл;
- Шүүгчийн ачаалал, гэр бүлийн хэрэгт зарцуулах цаг хугацааны хязгаарлалт зэргээс шалтгаалан маргаан бүрийг гүнзгий судлах боломж хязгаарлагддаг.
- Шийдвэр гүйцэтгэлийн хувьд:
- Уулзалтын эрхийг албадан биелүүлэхэд хүч хэрэглэлгүйгээр, хүүхдийн эрхийг зөрчихгүйгээр хэрэгжүүлэх арга олоход хүндрэлтэй;
- “Найдваргүй этгээдийн жагсаалт”, торгууль зэрэг албадлагын арга хэмжээ нь заримдаа эцэг, эхийн харилцааг улам хурцатгах, хүүхдэд сөргөөр тусах магадлалтай;
- нийгмийн дэмжлэг, сэтгэлзүйн үйлчилгээ хангалтгүй үед эрх зүйн албадлага ганцаараа хангалттай үр нөлөө үзүүлэхгүй байх тохиолдол элбэг.

2.2.5.3 Нийгмийн дэмжлэг, тогтолцооны давуу тал ба хязгаарлалт

(1) Давуу тал

Хятад улсын уулзалтын эрхийн тогтолцооны давуу талын нэг нь гэр бүлийн үйлчилгээ, нийгмийн дэмжлэгийг хууль зүйн тогтолцоотой уялдуулж хөгжүүлэх оролдлого юм. Гэр бүлийн үйлчилгээний төв, эмэгтэйчүүд, хүүхдийн байгууллагууд, нийгмийн ажилтны оролцоо, сэтгэлзүйн зөвлөгөө, сургалт, эвлэрүүлэн зуучлалыг шүүхийн ажиллагаатай холбон ашиглах нь уулзалтын эрхийн шийдвэрийг амьдралд хэрэгжүүлэхэд тодорхой дэмжлэг болж байна.

(2) Хязгаарлалт

Гэсэн ч эдгээр үйлчилгээний хүртээмж, чанар, мэргэшил бүс нутгаар ихээхэн ялгаатай, суурин бус, хөдөө орон нутагт хүүхэд, гэр бүлд чиглэсэн мэргэжлийн

үйлчилгээ хомс, олон нийтийн уламжлалт хандлага, нууцлаг байдал, “гадуур ярихгүй” гэсэн соёл уулзалтын эрхийн асуудлыг мэргэжлийн байгууллагад ил болгоход саад болдог.

Иймээс Хятад улсын уулзалтын эрхийн тогтолцоо нь эрх зүйн түвшинд тодорхой ахицтай, нийгмийн дэмжлэгийн системийг байгуулах оролдлого гаргаж буй ч бодит практикт эрх зүйн нарийвчилсан зохицуулалт, шүүхийн мэргэшсэн практик, нийгмийн дэмжлэгийн жигд хөгжил хоорондын зөрчил хэвээр байна.

Энэ бүлэгт хийсэн шинжилгээ нь Монгол Улсын уулзалтын эрхийн тогтолцоотой харьцуулахад Хятад улсын туршлагаас сургамж авах боломжтой үндэслэлүүд (эрх зүйн тодорхой байдал, гэр бүлийн шүүхийн тогтолцоо, олон талт дэмжлэг) болон болгоомжтой хандах шаардлагатай талуудыг (албадлагын арга хэмжээний нөлөө, бүс нутгийн тэгш бус байдал) ялган харах онол-практикийн суурь болно.

Үүн дээр үндэслэн дараагийн бүлэгт Монгол Улс ба Хятад Улсын уулзалтын эрхийн тогтолцооны харьцуулсан шинжилгээг хийж, нутагшуулах боломж, хязгаар, шинэчлэлийн чиглэлийг тодорхойлох юм.⁵

⁵ 陈苇. 以儿童最佳利益原则审视探望权制度[J]. 法律科学, 2019(2): 85-99.

БҮЛЭГ 3. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

3.1 Судалгааны дизайн

3.1.1 Судалгааны арга зүй

Энэхүү магистрын судалгааны ажил нь эрх зүйн шинжтэй, харьцуулсан судалгааны төрөлд хамаарах тул дараах үндсэн аргуудыг хослуулан ашиглав.

(1) Нормын шинжилгээний арга

Судалгааны гол хэсэг нь Монгол Улс болон Хятад Улсын гэр бүлийн эрх зүйн тогтолцоог харьцуулан шинжлэхэд чиглэж байгаа тул “Гэр бүлийн тухай” хууль, Иргэний хууль, хүүхдийн эрхийн хамгааллын холбогдох хууль тогтоомж, шүүхийн тайлбар, дэд журам, бодлогын баримт бичгүүдэд нормын шинжилгээ хийв. Нормын шинжилгээний аргаар уулзалтын эрхийн ойлголт, агуулга, хэрэгжүүлэх журам, хязгаарлалт, шийдвэр гүйцэтгэлийн зохицуулалтыг задлан шинжилж, хоёр улсын хууль тогтоомжийн ижил болон ялгаатай талыг илрүүлэв.

(2) Харьцуулсан эрх зүйн арга

Судалгааны үндсэн онцлог нь Монгол Улс ба Хятад Улсын эрх зүйн тогтолцоог харьцуулж буйд оршино. Иймээс харьцуулсан эрх зүйн функционалийн аргыг ашиглан ижил төрлийн нийгмийн асуудал (маргаанд хүүхдийн уулзалтын эрхийг хамгаалах)-ыг хоёр өөр эрх зүйн тогтолцоонд хэрхэн шийдвэрлэж буйг харьцуулсан. Энэ хүрээнд: (1) Хууль зүйн эх сурвалжийн бүтэц, эрх зүйн зарчим, үндсэн ойлголтуудыг; (2) Тодорхой зохицуулалт (уулзалтын эрхийн агуулга, журам, хязгаарлалт, гүйцэтгэл); (3) шүүхийн практик, нийгмийн дэмжлэгийн тогтолцоог үе шаттайгаар харьцуулан судалсан.

(3) Маргаанд суурилсан эмпирик шинжилгээ

Уулзалтын эрхийн “эрх зүйн текст” болон “амьдрал дахь хэрэгжилтийн” хоорондын зөрчлийг тодруулах зорилгоор тодорхой төлөөлөл бүхий шүүхийн шийдвэр, маргаануудыг сонгон эмпирик шинжилгээ хийв. Монгол Улсын шүүхийн шийдвэрийн нээлттэй мэдээллийн сан, Хятад улсын шүүхийн шийдвэрийн мэдээллийн санд нийтлэг, төлөөлөх шинжтэй гэж үзсэн маргаан, уулзалтын эрхтэй холбоотой маргааныг сонгон авч, шүүхийн үндэслэл, “хүүхдийн эрх ашиг нэн тэргүүнд байх” зарчмыг хэрхэн тайлбарласан байдал, уулзалтын эрхийн гүйцэтгэлийн талаар гаргасан шийдвэрийг тохиолдолд суурилан задлан судалсан.

(4) Баримт бичгийн шинжилгээний арга

Олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагын тайлан, судалгааны баримт бичиг, статистик мэдээлэл, бодлогын баримт бичгийг ашиглан түвшин, гэр бүлийн бүтцийн өөрчлөлт, хүүхдийн эрхийн хамгаалалтын бодит байдал, уулзалтын эрхийн гүйцэтгэлтэй холбоотой тоон, чанарын мэдээллийг цуглуулж, харьцуулсан шинжилгээнд ашиглав.

Мөн Монгол Улс ба Хятад Улсад, гадаадын эрдэм шинжилгээний өгүүлэл, ном, судалгааны тайланг системтэйгээр шүүн сонгож, судалгааны онолын ба эмпирик үндсийг бүрдүүлэв.

Эдгээр аргыг хослуулан ашигласнаар зөвхөн хууль зүйн заалтыг формал түвшинд задлан шинжлээд зогсохгүй, тухайн зохицуулалтын бодит хэрэгжилт, нийгмийн нөлөө, практикт үүсэж буй зөрчил, бэрхшээлийг илүү цогцоор нь авч үзэх боломж бүрдэв.

3.1.2 Судалгааны алхам

Судалгааны ажлыг дараах үндсэн үе шат, алхмаар зохион байгуулсан болно.

Нэгдүгээрт, онолын ба баримт бичгийн суурь судалгаа. Энэ шатанд хүүхдийн эрхийн онол, “хүүхдийн эрх ашиг нэн тэргүүнд байх” зарчим, уулзалтын эрхийн эрх зүйн шинж, хууль зүйн шилжилт, нутагшуулалтын онолтой холбоотой гадаад, дотоод судалгаануудыг өргөн хүрээнд шүүн сонгож, судалгааны онолын хүрээ, ойлголтын суурийг тогтоов. Мөн Монгол Улс, Хятад Улсын гэр бүлийн эрх зүйн холбогдох хууль тогтоомж, шүүхийн тайлбар, бодлогын баримт бичгийг цуглуулж, системчилсэн.

Хоёрдугаарт, эрх зүйн эх сурвалжийн нормын шинжилгээ. Монгол Улсын “Гэр бүлийн тухай” хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Хятад Улсын Иргэний хууль, шүүхийн тайлбар, гэр бүлийн хэрэгт хамаарах журам зэрэг эрх зүйн эх сурвалжийг зүйл заалт бүрээр нь ялган ангилж, маргаанд хүүхдийн асран хамгаалалт, уулзалтын эрхийн тухай зохицуулалтыг тодорхойлж, агуулгын шинжилгээ хийв. Энэ үе шатанд хоёр улсын хууль тогтоомжийн ижил төстэй ба ялгаатай тал, эрх зүйн ойлголтын зөрүүг тэмдэглэж авсан.

Гуравдугаарт, Шүүхийн практик, маргааны шинжилгээ. Монгол Улс, Хятад Улсын шүүхийн шийдвэрийн мэдээллийн сангаас маргаан дахь уулзалтын эрхтэй холбоотой тодорхой тооны (тоо хэмжээг судалгааны дараагийн бүлэгт тодорхой дурдана) шийдвэрийг сонгон авч, шийдвэр гаргах үндэслэл, хүүхдийн эрхийг хэрхэн тайлбарласан байдал, уулзалтын эрхийн гүйцэтгэлийн талаар авсан арга хэмжээг маргааны түвшинд задлан судалсан.

Энэ шатанд маргаануудыг төрөлжүүлж (жишээлбэл, эцэг, эхийн зөрчил өндөртэй маргаан, хүүхдийн эсэргүүцэлтэй маргаан, алслагдсан бүс нутгийн маргаан гэх мэт) харьцуулалт хийх боломжийг бүрдүүлсэн.

Дөрөвдүгээрт, харьцуулсан шинжилгээ, нэгтгэн дүгнэх шат. Монгол Улс, Хятад Улсын эрх зүйн зохицуулалт, шүүхийн практик, нийгэм-соёлын нөхцөлийг харьцуулсан шинжилгээг хийхдээ функционалийн арга баримталж, ижил асуудлыг шийдвэрлэхдээ ямар өөр эрх зүйн шийдэл, институтийн зохион байгуулалт ашиглаж буйг харьцуулсан. Үүний үндсэн дээр нийтлэг сорилт, ялгаатай онцлог, харилцан суралцах боломжийг тодорхойлж, Монгол Улс ба Хятад Улсад тохирох эрх зүйн шинэчлэлийн чиглэлийг нэгтгэн дүгнэсэн.

Тавдугаарт, Бодлогын болон эрх зүйн санал боловсруулах шат. Харьцуулсан шинжилгээний дүнд тулгуурлан Монгол Улсын нөхцөлд хэрэгжих боломжтой, эрсдэл, хязгаарлалыг харгалзсан хууль зүйн болон институтийн санал, зөвлөмжийг боловсруулсан. Энэ шатанд хууль зүйн шилжилт, нутагшуулалтын онолын зарчмыг баримталж, Хятад улсын туршлагын аль хэсгийг шууд нэвтрүүлэх боломжтой, аль хэсгийг нутагшуулах шаардлагатайг ялган үзсэн.

Ийнхүү судалгааны арга зүй, техник чиглэлийг системтэйгээр төлөвлөсөн нь судалгааны зорилго, асуулттай уялдсан, дэс дараатай, нотолгоонд суурилсан дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлсэн юм.

3.1.3 Судалгааны харьцуулалтын үзүүлэлт ба хэмжигдэхүүн

Кейс судалгаа болон харьцуулсан шинжилгээний үр дүнг илүү нарийвчилсан, системтэй хэлбэрээр харуулахын тулд энэхүү судалгааны ажилд дараах 5 үндсэн үзүүлэлт болон хэмжигдэхүүнүүдийг шалгуур болгон ашиглав. Үүнд:

1. Эрх зүйн зохицуулалтын түвшинд

- **Хууль зүйн статус:** Хүүхэдтэй уулзах эрхийн хууль зүйн тодорхойлолт, мөн чанар болон эрх зүйн бие даасан статус;
- **Эрхийн агуулга, хэлбэр:** Уулзалтын бодит хэлбэрүүд (биечлэн уулзах, зайнаас харилцах), давтамж, үргэлжлэх хугацаа болон баяр ёслол, амралтын өдрүүдийн тусгайлсан зохицуулалт;
- **Процедурын зохицуулалт:** Уулзах эрхийг хязгаарлах, түр зогсоох болон эргэж сэргээх үндэслэл, хэрэгжүүлэх нарийвчилсан журам.

2. Шүүхийн практик болон шийдвэр гаргах стандарт

- **Суурь зарчмын хэрэгжилт:** “Хүүхдийн дээд ашиг сонирхлыг тэргүүн ээлжинд хамгаалах” зарчмыг шүүхээс тайлбарлаж буй байдал болон шүүхийн шийдвэрийн үндэслэлд тусгагдсан хэлбэр;
- **Мэргэжлийн үнэлгээ:** Шүүхийн шатанд хүүхдийн санал бодлыг сонсох, үнэлэх журам, түүнчлэн сэтгэл зүйн болон нийгмийн нөхцөл байдлын мэргэжлийн үнэлгээг ашиглаж буй практик;
- **Шийдвэрийн нарийвчлал:** Шүүхийн шийдвэрээр тогтоож буй уулзалтын хуваарь болон зохион байгуулалтын нарийвчлалын түвшин (ерөнхий эсхүл тодорхой байгаа эсэх).

3. Шийдвэр гүйцэтгэлийн механизм

- **Албадлагын арга хэрэгсэл:** Уулзах эрхийн тухай шүүхийн шийдвэрийг бодитоор гүйцэтгэхэд ашиглаж буй эрх зүйн арга хэрэгслүүд (зөвлөмж, эвлэрүүлэн зуучлал, торгууль, захиргааны албадлага г.м);
- **Хариуцлагын тогтолцоо:** Шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзсан, эсхүл удаа дараа саад учруулсан тохиолдолд хэрэглэх шаталсан хариуцлагын механизмын бодит байдал;
- **Хүүхэд хамгааллын журам:** Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хүүхдийн эрх, аюулгүй байдал болон сэтгэл зүйг хамгаалах тусгай журам, хамгаалалтын арга хэмжээний хэрэгжилт.

4. Нийгмийн дэмжлэг болон байгууллагуудын оролцоо

- **Мэргэжилтнүүдийн оролцоо:** Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, гэр бүлийн зуучлагч болон хүүхэд хамгааллын байгууллагуудын харилцан уялдаа, тэдгээрийн эрх хэмжээ, үүрэг хариуцлагын хуваарилалт;

- **Дэд бүтцийн хүртээмж:** Гэр бүл, хүүхдэд зөвлөгөө өгөх үйлчилгээний төвүүд, шүүхийн дэргэдэх төрөлжсөн нэгжүүд зэрэг дэмжлэг үзүүлэх байгууллагуудын хөгжлийн түвшин ба хүртээмж;
- **Салбар хоорондын хамтын ажиллагаа:** Сургууль, эмнэлэг, орон нутгийн хамгааллын баг болон шүүх, шийдвэр гүйцэтгэх байгууллага хоорондын албан ёсны хамтын ажиллагааны түвшин.

5. Нийгэм-соёлын орчин болон хандлага

- **Нийгмийн ойлголт:** Гэр бүл, гэрлэлт цуцлалт болон хүүхдийн бие даасан эрхийн талаарх нийгмийн нийтлэг хандлага, хэвшмэл үзэл;
- **Хамтын эцэг эхийн соёл:** Салалтын дараа эцэг эх хамтран хүүхдээ хүмүүжүүлэх (co-parenting) соёлын төлөвшлийн түвшин;
- **Уулзах эрхийн мөн чанар:** Уулзах эрхийг хүүхдийн өөрийнх нь салшгүй эрх гэж үзэж байна уу, эсхүл эцэг эх хоорондын “өс хонзонгийн зэвсэг” болгон ашиглаж байна уу гэдэг хандлагын ялгаа.

Эдгээр таван үндсэн үзүүлэлт болон хэмжигдэхүүнүүдийг ашигласнаар энэхүү судалгааны ажил нь Монгол Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хүүхэдтэй уулзах эрхийн тогтолцоог зөвхөн хуулийн бичвэр төдийгүй, шүүхийн практик, шийдвэр гүйцэтгэл, институцийн дэмжлэг болон нийгэм-соёлын орчинд тулгуурласан цогц түвшинд гүнзгийрүүлэн харьцуулах боломжийг олгосон юм. Энэ нь судалгааны кейсүүдийг оношлох, харьцуулалтын үр дүнг илүү тодорхой, чанарын үзүүлэлтээр нотлоход чухал үүрэг гүйцэтгэсэн болно.

3.2 Мэдээлэл, өгөгдөл цуглуулах үйл явц

Энэхүү судалгааны ажлын практик үндэслэл, онолын дүгнэлтийг бодитой болгох үүднээс мэдээлэл, өгөгдлийг чанарын (qualitative) болон тоон (quantitative) судалгааны аргуудыг хослуулан, дараах хоёр үндсэн чиглэлээр системтэйгээр цуглуулсан болно. Эрх зүйн харьцуулсан судалгаанд зөвхөн хуулийн заалтыг харахаас гадна, шүүхийн практикт тухайн хууль хэрхэн хэрэгжиж буйг тоон үзүүлэлтээр харуулах нь чухал ач холбогдолтой юм.

3.2.1 Шүүхийн шийдвэрийн түүвэр судалгаа

Хоёр улсын гэрлэлт цуцлах маргаан дахь хүүхдийн асрамж, тэжээн тэтгэлэг болон уулзалтын эрхийн хэрэгжилтийг харьцуулах зорилгоор 2021-2025 онуудын хооронд шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн иргэний хэргийн шийдвэрүүдээс түүвэрлэлт (sampling) хийж, өгөгдлийн бааз үүсгэв.

- Монгол Улсын өгөгдөл: Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн нэгдсэн сан (shuukh.mn)-аас "Гэрлэлт цуцлах", "Хүүхдийн асрамж тогтоох", "Уулзалтын журам тогтоох" гэсэн түлхүүр үгсээр хайлт хийж, Нийслэлийн анхан шатны шүүхүүдээр шийдвэрлэгдсэн нийт 120 шүүхийн шийдвэрийг санамсаргүй түүвэрлэлтийн (random sampling) аргаар сонгон авч, контент анализ (content analysis) хийсэн.
- БНХАУ-ын өгөгдөл: БНХАУ-ын Ардын шүүхийн шийдвэрийн цахим сан (中国裁判文书网)-аас Хятад улсын Иргэний хуулийн 1084, 1085, 1086

дугаар зүйлд холбогдох, Өвөр Монголын Өөрөө Засах Орон болон Бээжин, Шанхай зэрэг хотуудын анхан шатны шүүхийн нийт 150 шүүхийн шийдвэрийг түүвэрлэн авч, мэдээллийн санд нэгтгэв.

3.2.2 Цуглуулсан тоон өгөгдлийн анхны бүтэц

Судалгааны явцад цуглуулсан шүүхийн кэйсүүдийг дараах үндсэн үзүүлэлтээр ангилж, статистик өгөгдлийн суурийг бэлдсэн. Шүүхийн шийдвэрүүдэд хийсэн урьдчилсан дүн шинжилгээгээр дараах тоон үзүүлэлтүүд (судалгааны эмпирик өгөгдөл) гарсан болно.

Хүснэгт 1 Түүвэрлэн авсан шүүхийн шийдвэрүүдийн ерөнхий бүтэц (Монгол ба Хятад Улс)

Судлагдсан үзүүлэлтүүд (Шүүхийн шийдвэрийн агуулга)	Монгол Улс (n=120)	БНХАУ (n=150)
Хүүхдийн асрамжийг эхэд нь үлдээсэн кэйсийн хувь	84.1% (101 кэйс)	78.6% (118 кэйс)
Хүүхдийн асрамжийг эцэгт нь үлдээсэн кэйсийн хувь	12.5% (15 кэйс)	16.0% (24 кэйс)
Хамтарсан асрамж (Joint custody) тогтоосон кэйс	3.4% (4 кэйс)	5.4% (8 кэйс)
Уулзалтын эрх /журам/-ийг нарийвчлан тогтоосон хувь	22.5% (27 кэйс)	68.7% (103 кэйс)
Уулзалтын эрхийг зөвхөн "тохиролцохоор" үлдээсэн хувь	77.5% (93 кэйс)	31.3% (47 кэйс)

(Тайлбар: Дээрх өгөгдөл нь хоёр улсын шүүхийн практикт хүүхдийн уулзалтын эрхийг шийдвэрлэж буй хэлбэрийн тод илрэл бөгөөд Монгол Улсад уулзалтын журмыг нарийвчлан хуульчлах шаардлагатайг харуулж буй анхдагч тоон нотолгоо юм).

3.2.3 Чанарын судалгааны мэдээлэл цуглуулах үйл явц

Тоон өгөгдлийг баяжуулах, хууль хэрэгжилтийн шатан дахь бодит бэрхшээлийг гүнзгийрүүлэн судлах зорилгоор хагас бүтэцчилсэн ярилцлагын (semi-structured interview) аргыг ашигласан. Судалгааны хүрээнд гэр бүлийн эрх зүйн чиглэлээр мэргэшсэн дараах шинжээч, мэргэжилтнүүдээс мэдээлэл цуглуулсан:

- Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 3 шүүгч,
- Гэр бүлийн маргаанаар мэргэшсэн 4 өмгөөлөгч,
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2 хуулийн зөвлөх болон сэтгэл зүйч.

Шинжээчдээс авсан ярилцлагын асуултууд нь "Шүүх уулзалтын эрхийг тогтоохдоо хүүхдийн нас, сэтгэл зүйг хэрхэн харгалздаг вэ?", "Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн шатанд уулзуулахгүй байх эсэргүүцлийг хэрхэн шийдвэрлэж байна вэ?" гэсэн агуулгад тулгуурласан бөгөөд эдгээр чанарын мэдээллийг IV бүлгийн практик зөвлөмжийн суурь болгон ашигласан болно.

3.3 Судалгааны хувьсагчийн тайлбар (Explanation of Variables and Indicators)

Гэрлэлт цуцлах маргаан дахь хүүхдийн эрх, тэр дундаа уулзалтын эрхийн хэрэгжилтэд нөлөөлж буй хүчин зүйлсийг шинжлэх ухааны үндэслэлтэй, дедуктив аргаар тодорхойлохын тулд судалгааны үндсэн хувьсагчдыг (variables) дараах байдлаар ангилан, тэдгээрийн хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг (operational indicators)

тодорхойлов. Гэр бүлийн эрх зүйн харилцаа нь зөвхөн хууль тогтоомжоос гадна хувь хүний зан үйл, нийгмийн хандлагаас хамаардаг тул хувьсагчдыг чанарын болон тоон үзүүлэлтээр хослуулан хэмжсэн болно.

3.3.1 Үл хамаарах хувьсагчид (Independent Variables)

Үл хамаарах хувьсагч гэдэг нь хүүхдийн эрхийн хамгаалалтын түвшин болон шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн үр дүнд шууд нөлөөлж буй үндсэн шалтгаан, нөхцөлүүд юм. Үүнд дараах гурван хувьсагчийг авч үзэв:

1. Хууль эрх зүйн зохицуулалтын нарийвчлал (X_1):

- Тодорхойлолт: Үүнд Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль болон БНХАУ-ын Иргэний хуульд уулзалтын эрх, асрамж, тэжээн тэтгэлгийг хэр зэрэг нарийвчлан заасан байдал орно.
- Хэмжих үзүүлэлт: Шүүхийн шийдвэрт уулзах цаг, давтамж, хэлбэрийг хуулийн заалтад тулгуурлан нарийвчлан зааж өгсөн эсэх (БНХАУ-ын Иргэний хуулийн 1084-1086 дугаар зүйлийн хэрэглээний түвшин).

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албадлага ба дэмжлэгийн механизм (X_2)

- Тодорхойлолт: Шүүхийн шийдвэр гарсаны дараа хамт амьдардаггүй эцэг, эхийг хүүхэдтэй нь уулзуулах үйл явцад хяналт тавьж буй эрх зүйн механизмын хүчин чадал.
- Хэмжих үзүүлэлт: Уулзуулах үүргээ биелүүлээгүй талд хүлээлгэх хуулийн хариуцлагын хэлбэрүүд (торгууль, сануулга, асрамжийн эрхийг шилжүүлэх үндэслэл) болон гэр бүлийн сэтгэл зүйчийг татан оролцуулж буй байдал.

3. Нийгэм-соёлын болон уламжлалт гэр бүлийн үнэт зүйл (X_3):

- Тодорхойлолт: Хоёр улсын иргэдийн дунд гэрлэлт цуцлалтын дараах эцэг, эхийн үүрэг хариуцлагын талаарх үзэл бодол, хандлага.
- Хэмжих үзүүлэлт: Салсан эцэг, эхчүүд уулзалтын эрхийг "хүүхдийн суурь эрх" гэж үзэж байна уу, эсвэл "эсрэг талынхаа давуу эрх" гэж туйлширч байна уу гэдгийг тодорхойлох чанарын индикаторууд.

3.3.2 Хамаарах хувьсагчид (Dependent Variables)

Хамаарах хувьсагч нь дээрх хүчин зүйлсийн (X_1 , X_2 , X_3) нөлөөгөөр өөрчлөгдөж буй судалгааны эцсийн үр дүн, үр нөлөөний үзүүлэлт юм.

1. Хүүхдийн дээд ашиг сонирхлын хангагдах түвшин (Y_1):

- *Тодорхойлолт:* Гэрлэлт цуцалсан ч хүүхэд эцэг, эхийн хайр халамжаас гадуур үлдэхгүй байх, сэтгэл зүйн дарамтгүй орчинд өсөх боломж.
- *Хэмжих үзүүлэлт:* Шүүхийн практикт хүүхдийн саналыг сонсож буй байдал (Жишээ нь: БНХАУ-д 8-аас дээш насны хүүхдийн саналыг харгалздаг хуулийн шалгуур), хүүхэд эцэг, эхийн хэн нэгнээс бүрмөсөн тусгаарлагдаж буй кэйсийн хувь хэмжээ.

2. Уулзалтын эрхийн бодит хэрэгжилт ба маргааны давтамж (Y_2):

- *Тодорхойлолт:* Шүүхээс тогтоосон уулзалтын журам амьдрал дээр хэр зэрэг тогтвортой хэрэгжиж байгаа эсэх.
- *Хэмжих үзүүлэлт:* Гэрлэлт цуцалсны дараа уулзалтын асуудлаас болж шүүх болон шийдвэр гүйцэтгэх байгууллагад дахин гомдол гаргаж буй хэргийн тоо, хувь хэмжээ.

Хүснэгт 2 Судалгааны хувьсагчдын матриц болон хэмжих индикаторуудын хураангуй

Хувьсагчийн төрөл	Хувьсагчийн нэршил	Хэмжих арга зүй / Шалгуур үзүүлэлт	Өгөгдлийн хэлбэр
Үл хамаарах (X ₁)	Эрх зүйн зохицуулалтын нарийвчлал	Хуулийн заалтын тодорхой байдал, шүүхийн шийдвэрт хуваарь заасан хувь	Чанарын болон тоон өгөгдөл
Үл хамаарах (X ₂)	Шийдвэр гүйцэтгэлийн албадлага	Хуулийн санкцийн хэлбэрүүд, хөндлөнгийн байгууллагын оролцоо	Чанарын өгөгдөл
Үл хамаарах (X ₃)	Нийгэм-соёлын нөхцөл	Эцэг, эхийн хариуцлагын талаарх хандлага, уламжлалт үнэт зүйл	Чанарын өгөгдөл
Хамаарах (Y ₁)	Хүүхдийн дээд ашиг сонирхол	Хүүхдийн насны зааг, оролцооны эрх хангагдсан байдал	Тоон болон чанарын өгөгдөл
Хамаарах (Y ₂)	Уулзалтын эрхийн бодит хэрэгжилт	Дахин үүссэн маргааны тоо, шүүхийн шийдвэр биелэлтийн хувь	Статистик тоон өгөгдөл

Эдгээр хувьсагчдын харилцан хамаарлыг нарийвчлан тодорхойлсноор Монгол Улсын гэр бүлийн эрх зүйн практикт тулгарч буй суурь гажиг хаанаа байгааг олж тогтоох, улмаар БНХАУ-ын институтийн туршлагыг ямар хөрсөн дээр нутагшуулах вэ гэдгийг тодорхойлох боломж бүрдэж байгаа юм.

3.4 Өгөгдөл боловсруулах ба шинжилгээний арга зүй

Энэхүү судалгааны ажлын хүрээнд цуглуулсан тоон болон чанарын мэдээлэл, шүүхийн кэйсүүд болон хоёр улсын хууль тогтоомжийн эх сурвалжийг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулж, дүгнэлт гаргахын тулд дараах дөрвөн үндсэн аналитик аргыг системтэйгээр ашигласан болно. Мэдээллийг боловсруулах үйл явц нь судалгааны объектив (бодит) байдлыг хангахад чиглэгдсэн.

3.4.1 Статистикийн дүрслэл болон харьцуулсан анализын арга

Шүүхийн шийдвэрийн нэгдсэн сангуудаас түүвэрлэн авсан Монгол Улсын 120 кэйс, БНХАУ-ын 150 кэйсийн тоон өгөгдлийг боловсруулахдаа Microsoft Excel болон SPSS програмыг ашиглан статистик дүрслэлийн (descriptive statistics) шинжилгээг хийсэн.

- **Процесс:** Шүүхийн шийдвэр бүрийг "Хүүхдийн нас", "Асрамж тогтоосон тал", "Тэжээн тэтгэлгийн хэмжээ", "Уулзалтын журмыг нарийвчлан заасан эсэх" гэсэн кодоор ангилж, өгөгдлийн бааз үүсгэсэн.

- **Шинжилгээ:** Хоёр улсын шүүхийн практикт уулзалтын эрхийг шийдвэрлэж буй хувь хэмжээг харьцуулан, Монгол Улсын практикт үүсээд буй эрх зүйн зохицуулалтын хоосон орон зайг (gap анализ) тоон үзүүлэлтээр нотолсон.

3.4.2 Эрх зүйн баримт бичгийн агуулгын шинжилгээ

Чанарын өгөгдөл болох Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль, БНХАУ-ын Иргэний хуулийн холбогдох заалтууд болон олон улсын конвенцуудын агуулгад системчилсэн шинжилгээ хийсэн.

- **Процесс:** БНХАУ-ын Иргэний хуулийн 1084, 1085, 1086 дугаар зүйлийн үзэл баримтлал, тэдгээрийн хэрэгжих механизмыг Монгол Улсын хуулийн заалтуудтай тус бүрчлэн тулгаж, логик харьцуулалт хийв.
- **Шинжилгээ:** Хятадын институтийн туршлага дахь "хүүхдийн насны заагт тулгуурлан асрамж тогтоох" болон "орлогын хувь хэмжээгээр тэжээн тэтгэлэг тодорхойлох" нарийвчилсан заалтууд нь хүүхдийн уулзалтын эрхийг хамгаалахад ямар суурь нөхцөл болж өгдөгийг онолын түвшинд илрүүлсэн.

3.4.3 Шүүхийн практикийн кэйс-лоо анализ

Зөвхөн хуулийн заалтыг судлаад зогсохгүй, амьдрал дээр хууль хэрхэн тайлбарлагдан хэрэглэгдэж байгааг судлахын тулд шүүхийн шийдвэрүүдэд чанарын гүнзгийрүүлсэн шинжилгээ (deep case analysis) хийсэн.

- **Процесс:** Түүвэрлэн авсан кэйсүүдээс хамгийн их зөрчил дагуулсан, өөрөөр хэлбэл "Шүүхийн шийдвэр гарсан ч хамт амьдардаг эцэг/эх нь хүүхдийг уулзуулахгүй байгаа" кэйсүүдийг тусгаарлан авч үзсэн.
- **Шинжилгээ:** Шүүгч нар ийм төрлийн маргааныг шийдвэрлэхдээ хүүхдийн сэтгэл зүйн тогтвортой байдал, дээд ашиг сонирхлыг ямар шалгуураар үнэлж байгаад чанарын дүгнэлт өгсөн.

3.4.4 Шинжээчдийн ярилцлагын логик нэгтгэл

Практик үйл ажиллагаа эрхэлж буй шүүгч, өмгөөлөгч, хүүхдийн эрхийн байгууллагын мэргэжилтнүүдээс цуглуулсан хагас бүтэцчилсэн ярилцлагын тэмдэглэлийг логик нэгтгэлийн (thematic analysis) аргаар боловсруулсан.

- **Процесс:** Ярилцлагын явцад илэрсэн гол санаануудыг "Хуулийн дутагдалтай тал", "Шийдвэр гүйцэтгэлийн гажиг", "Нийгмийн сэтгэл зүйн нөлөө" гэсэн үндсэн сэдвүүдэд (themes) хуваан ангилсан.
- **Шинжилгээ:** Олон улсын туршлага болон БНХАУ-ын эрх зүйн бүтцийг Монгол Улсын нийгэм-соёлын онцлогт нийцүүлэн хэрхэн нутагшуулах, гүйцэтгэлийн шатанд албадлага болон дэмжлэгийг хослуулсан шинэ механизмыг ямар бүтцээр нэвтрүүлэх вэ гэдгийг тодорхойлоход эдгээр чанарын дүгнэлтийг ашигласан болно.

БҮЛЭГ 4. ЭМПИРИК СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ БА ҮР ДҮН

4.1 Гэрлэлт цуцлах маргаан дахь хүүхдийн уулзалтын эрхийн хэрэгжилтийн харьцуулсан анализ

Судалгааны ажлын гуравдугаар бүлэгт тодорхойлсон арга зүйн дизайн болон үл хамаарах хувьсагч, шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд Монгол Улсын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 120 шийдвэр, БНХАУ-ын Ардын шүүхийн 150 шийдвэрт хийсэн контент анализын үндсэн үр дүнг энэхүү бүлэгт хэлэлцүүлнэ. Судалгаагаар үл хамаарах хувьсагч болох "Хууль эрх зүйн зохицуулалтын нарийвчлал" (X_1) нь хамаарах хувьсагч болох "Уулзалтын эрхийн бодит хэрэгжилт" (Y_2) болон "Хүүхдийн дээд ашиг сонирхлын хангагдах түвшин" (Y_1)-д шууд бөгөөд хүчтэй нөлөө үзүүлж буй нь эмпирик (тоон болон чанарын) өгөгдлөөр тогтоогдсон болно.

Түүвэрлэн авсан шүүхийн шийдвэрүүдэд хийсэн статистик дүн шинжилгээгээр, Монгол Улсын шүүхийн практикт гэрлэлт цуцалсан кэйсүүдийн 77.5%-д нь (93 кэйс) уулзалтын журмыг "эцэг эх цаашид харилцан тохиролцох"-ор ерөнхий орхисон байдаг бол, БНХАУ-ын шүүхийн шийдвэрүүдийн 68.7%-д нь (103 кэйс) уулзах цаг хугацаа, давтамж, хэлбэрийг маш нарийвчлан тогтоосон бүтэц ажиглагдаж байна. Энэхүү тоон үзүүлэлтийн зөрүү болон түүний цаана урсан гарч буй хууль зүйн үр дагавар, институтийн зохицуулалтын ялгаатай байдлыг дараах дэд хэсгүүдээр нарийвчлан шинжлэв.

4.1.1 Хууль эрх зүйн зохицуулалтын нарийвчлал (X_1)-ийн харьцуулсан үнэлгээ

Хоёр улсын гэрлэлт цуцлах маргаан дахь хүүхдийн уулзалтын эрхийн хэрэгжилтийг харьцуулан шинжлэхэд үл хамаарах хувьсагч болох "Хууль эрх зүйн зохицуулалтын нарийвчлал" (X_1) нь шүүхийн шийдвэр амьдрал дээр бодитой биелэх эсэхийг тодорхойлогч хамгийн гол хүчин зүйл болох нь судалгааны үр дүнгээр харагдлаа.

Хуулийн заалт хэр зэрэг нарийвчилсан, тодорхой байна, тэр хэмжээгээр салсан эцэг, эхийн дунд үүсэх дараагийн зөрчил буурч, хамаарах хувьсагч болох хүүхдийн дээд ашиг сонирхол хамгаалагддаг (Y_1). Энэхүү үзүүлэлтийн хүрээнд Монгол Улсын ерөнхий бөгөөд тунхаглалын шинжтэй хууль эрх зүйн орчин, БНХАУ-ын Иргэний хуулийн нарийвчилсан институтийн зохицуулалтыг тэдгээрийн шүүхийн практик, олон улсын конвенцийн хэрэгжилттэй уялдуулан дараах дэд хэсгүүдээр тус бүрчлэн харьцуулж, үндсэн үр дүнг тодорхойлов.

4.1.1.1 Монгол Улсын хууль тогтоомжийн ерөнхий шинж ба практик дахь хоосон орон зай

Үл хамаарах хувьсагч болох "Хууль эрх зүйн зохицуулалтын нарийвчлал" (X_1)-ийн хүрээнд Монгол Улсын гэр бүлийн эрх зүйн орчинд хийсэн судалгааны үр дүнд Монгол улсын хууль тогтоомж нь хүүхдийн уулзалтын эрхийг зохицуулах тал дээр хэт ерөнхий, тунхаглалын шинжтэй бөгөөд практикт томоохон хоосон орон зай (gap) үүсгэсэн байгаа нь тогтоогдлоо.

Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн нэгдсэн сан (shuukh.mn)-аас түүвэрлэсэн 120 иргэний хэргийн шийдвэрт контент анализ хийхэд, гэрлэлт цуцалсан кэйсүүдийн 77.5%-д нь (93 кэйс) шүүх хүүхэдтэй уулзах журмыг нарийвчлан тогтоолгүйгээр, "Эцэг,

эх цаашид хүүхэдтэй уулзах журам, хуваарийг өөрсдөө харилцан тохиролцох" гэсэн ерөнхий заалтаар хэргийг шийдвэрлэсэн байна.

Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т "Эцэг, эх хүүхдээ хүмүүжүүлэхэд тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээнэ" гэж заасан бөгөөд мөн хуулийн 26.6-д "Гэрлэлтээ цуцлуулсан эцэг, эхийн хэн нэг нь нөгөөдөө үүргээ биелүүлэхэд нь саад учруулахыг хориглоно" гэж тусгасан байдаг. Шүүхүүд гэрлэлт цуцлах маргааныг шийдвэрлэхдээ Иргэний хууль болон Гэр бүлийн тухай хуулийн эдгээр заалтыг үндэслэн хүүхдийн асрамжийг тогтоохдоо эцэг, эхийн ёс суртахууны байдал, хүүхдэд тавих анхаарал халамж, нас, өсөж торних орчныг голчлон үнэлж байна.

Гэвч практик амьдрал дээр хуулийн энэхүү ерөнхий бүтэц нь хамаарах хувьсагч болох "Уулзалтын эрхийн бодит хэрэгжилт" (Y_2)-д ноцтой сөрөг үр дагаврыг дагуулж байна. Гэрлэлтээ цуцлуулж буй эцэг, эхийн дунд сэтгэл зүйн зөрчил, таарамжгүй харилцаа өндөр байдаг тул шүүхийн шийдвэрт уулзах цаг хугацаа, давтамж, байршлыг нарийвчлан зааж өгөөгүй тохиолдолд "харилцан тохиролцох" зарчим бүрэн нуран унадаг. Улмаар хүүхдээ авч үлдсэн тал нь нөгөө талдаа саад учруулах, хүүхдийг өшөө авалтын барьцааны хэрэгсэл болгон ашиглах хууль зүйн гажгийг үүсгэж байна. Энэ нь хууль тогтоомжийн нарийвчлал (X_1) сул байгаагаас шалтгаалан хамаарах хувьсагч болох "Хүүхдийн дээд ашиг сонирхлын хангагдах түвшин" (Y_1) практик дээр ноцтой зөрчигдөж буйн гол илрэл юм.

4.1.1.2 Үндсэн зарчим, ойлголтын харьцуулалт ба "Хүүхдийн дээд ашиг сонирхол" зарчмын хэрэгжилт

Монгол Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улс нь хоёулаа НҮБ-ын "Хүүхдийн эрхийн конвенц" (UNCRC)-д нэгдэн орсон орнууд бөгөөд олон улсын эрх зүйн түвшинд "Хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд хамгаалах" үндсэн зарчмыг хүлээж авсан байдаг. Гэвч үл хамаарах хувьсагч болох "Хууль эрх зүйн зохицуулалтын нарийвчлал" (X_1)-ийн түвшинд энэхүү зарчмыг өөрийн орны үндэсний хууль тогтоомж болон шүүхийн практикт хэрхэн буулгаж, ойлгож буй байдал нь онол болон практикийн хувьд маш том ялгаатай байна.

БНХАУ-ын Ардын шүүхийн шийдвэрийн цахим сан (中国裁判文书网)-аас түүвэрлэн авсан 150 кэйсийн анализыг үзэхэд, Хятадын шүүхийн шийдвэрүүдийн 68.7%-д нь (103 кэйс) уулзалтын эрхийг зөвхөн "эцэг эхийн нэг талын хүсэлт" гэж харалгүйгээр, "хүүхдийн сэтгэл зүйн тогтвортой байдал, эрүүл өсөж торних дээд ашиг сонирхол" (Y_1)-ыг хангах нарийвчилсан механизмын дагуу шийдвэрлэдэг болох нь тоон өгөгдлөөр нотлогдсон. БНХАУ-ын Иргэний хуулийн 1084, 1085, 1086 дугаар зүйлд энэхүү зарчмыг дараах нарийвчилсан, бодит шалгуур үзүүлэлтүүд болгон хуульчилж өгсөн нь эрх зүйн зохицуулалтын нарийвчлал (X_1)-ийн давуу талыг илэрхийлдэг. Үүнд:

(1)Хүүхдийн насны заагт тулгуурлан асрамж, уулзалтыг тогтоох нарийвчилсан зарчим: Хятадын шүүхийн практикт хүүхдийн насыг формал бус, маш тодорхой зааг шалгуур болгодог. Тухайлбал, 2 хүртэлх насны хүүхдийг эхэд нь үлдээх ерөнхий зарчмыг хатуу баримталдаг бөгөөд энэ нь хүүхдийн махан бие, физиологийн хэрэгцээг хамгаалж буй хэлбэр юм. Харин 8-аас дээш насны хүүхдийн асрамж болон уулзалтын журмыг шийдвэрлэхдээ түүний саналыг шүүх хуралдаан дээр заавал сонсож, хүүхдийн

бие даасан үзэл бодлыг хүндэтгэдэг. Энэ нь олон улсын конвенцоор тунхагласан хүүхдийн "оролцооны эрх"-ийг хууль зүйн өндөр түвшинд хангаж, шүүгчийн үзэмжээр бус хуулийн тодорхой заалтаар хэрэгжүүлж буйн тод илрэл юм.

(2) Тэжээн тэтгэлгийг орлогын хувь хэмжээгээр тодорхойлох тогтолцоо: Хүүхдийн тэжээн тэтгэлгийг тогтоохдоо эцэг эхийн сарын тогтмол орлогын тодорхой хувиар (ихэвчлэн 20%-30% хүртэл) тооцдог бөгөөд хүүхдийн боловсрол, эрүүл мэндийн зардлыг бодитоор хуваалцах механизмыг хуульчилсан нь маш тодорхой байдаг. Эдийн засгийн энэхүү баталгаа нь уулзалтын эрхийг саадгүй хэрэгжүүлэх, эцэг эхийн зөрчлийг бууруулах суурь дэвсгэр болдог.

(3) Хуулийн 1086 дугаар зүйлд заасан уулзалтын эрхийн бие даасан статус: Хятадын Иргэний хуульд уулзалтын эрхийг гэр бүлийн харилцааны энгийн нэгэн нөхцөл биш, бие даасан эрх зүйн институт болгон хуульчилсан. Шүүхүүд уулзалтын журмыг тогтоохдоо сар бүрийн хэд дэх долоо хоногийн амралтын өдрүүдэд, зуны болон өвлийн амралтын хугацаанд, мөн уламжлалт баяруудаар (Цагаан сар, Намрын баяраар) хүүхэд хамт амьдардаггүй эцэг/эхтэйгээ хэдэн хоногийг өнгөрүүлэхийг цаг хугацаа, байршил, хүүхдийг хүлээлгэн өгөх орчинтой нь цуг маш тодорхой зааж өгдөг.

Харин Монгол Улсын эрх зүйн тогтолцооны хувьд "Хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалах" зарчим Гэр бүлийн тухай хуулийн ерөнхий тунхаглалын шинжтэй заалтуудад туссан боловч, шүүхийн практикт хүүхдийн санал бодлыг дуугаргах, оролцоог хангах тогтолцоо маш сул байна. Практикт "хүүхдийг маргаанд татахгүй" гэсэн нэрийн дор түүний дуу хоолойг бүрэн хаах, эсхүл шүүгч өөрийн үзэмжээр (judicial discretion) зарчмыг хэт ерөнхий тайлбарлах тохиолдол түгээмэл байна. Хүүхдийн насны зааг, тэжээн тэтгэлэг болон уулзалтын журмыг хуулиар нарийвчлан зааж өгөөгүй нь "Хүүхдийн дээд ашиг сонирхол" хэмээх олон улсын стандартыг амьдрал дээр бодитой хэрэгжүүлэх боломжгүй болгож байна.

Ийнхүү БНХАУ-ын Иргэний хуулийн нарийвчилсан институтийн заалтууд болон шүүхийн практик нь гэрлэлт цуцалсны дараа эцэг эхийн дунд үүсэх дараагийн маргааны давтамжийг эрс бууруулж, хамаарах хувьсагч болох "Хүүхдийн дээд ашиг сонирхлын хангагдах түвшин" (Y_1)-ийг хангах болон хүүхдийн сэтгэл зүйн тогтвортой байдлыг хамгаалах үндсэн хөшүүрэг болж байна. Энэхүү нарийвчилсан харьцуулалт нь хууль тогтоомжийн нарийвчлал (X_1) өндөр байх нь олон улсын конвенцын үзэл баримтлалыг практикт амьд болгох хамгийн гол нөхцөл гэдгийг нотолж байна.

4.1.1.3 Торхой зохицуулалтын харьцуулалт: Агуулга, Журам, Хязгаарлалт

(1) Агуулга, хэлбэр, давтамж

Монгол Улсын "Гэр бүлийн тухай" хууль уулзалтын эрхийн агуулгыг ерөнхий байдлаар тодорхойлж, хүүхэдтэй уулзах, харилцах эрхтэй гэж заадаг ч, уулзалтын хэлбэр (биечлэн уулзах, холбоо барих), давтамж, хугацааны жишиг заалт, нарийвчилсан стандарт бага. Шүүхийн практикт өдөр, цаг, газар, баярын хуваарийг нарийвчлан тогтоох нь харьцангуй ховор.

Харин Хятад Улсын Иргэний хууль болон шүүхийн тайлбар уулзалтын эрхийн агуулгад биечлэн уулзах, холбоо барих, мэдээлэл авах эрхийг илүү тодорхой хамруулж, шүүхийн шийдвэрүүдэд уулзалтын өдрийг, цаг, газар, баяр, амралтын хуваарийг нэлээд нарийвчилсан байдлаар тогтоох хандлага түгээмэл. Зарим тохиолдолд үе шаттай гүйцэтгэлийн хуваарь гаргаж, анхны шатанд хяналттай уулзалт, дараа нь энгийн уулзалт руу шилжихийг зохицуулдаг.

(2) Хязгаарлах, зогсоох, сэргээх зохицуулалт

Монгол Улсын хуульд уулзалтын эрхийг хязгаарлах, зогсоох тухай шууд заалт хомс, голдуу эцэг, эхийн эрхийг хязгаарлах, асран хамгаалах эрхийг хураах тухай ерөнхий заалтаар дамжин хэрэгждэг. Энэ нь шүүхийн практикт нэг ижил нөхцөлд өөр өөр хатуу, зөөлөн шийдвэр гаргах боломжийг нээдэг.

Харин Хятад Улсын Иргэний хуульд уулзалтын эрхийг хязгаарлах, зогсоох нарийн нөхцөл, зарчим заагдсан: Хүүхдийн эрх ашигт ноцтой хор уршиг учрах эрсдэлтэй тохиолдолд, хүчирхийлэл, мансуурах, архидалт, хүүхдийг хууль бус үйлдэлд татан оролцуулах гэх мэт. Мөн нөхцөл байдал өөрчлөгдвөл уулзалтын эрхийг сэргээх, үе шаттайгаар хэвийн болгох зохицуулалт орсон нь эрхийг эцсийн байдлаар үгүйсгэхээс илүү, хүүхдийн эрхийг хамгаалсан нөгөө талын оролцоог эргэж сэргээх боломжийг нээлттэй үлдээж байна.

(3) Шийдвэр гүйцэтгэл, албадлагын арга

Монгол Улсад уулзалтын эрхийн шийдвэрийг гүйцэтгэх институтийн механизм сул, торгууль, албадлагын арга хэрэгслийг хэрэглэдэг ч практикт ховор, системтэй биш. Хүүхдийн эрхийг хамгаалах нэрийн дор шүүх, шийдвэр гүйцэтгэх байгууллага албадлагын арга хэрэглэхээс татгалзах, "итгэлцэлд тулгуурлах" арга барил давамгайлдаг.

Харин Хятадад шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой албадлагын олон төрлийн арга (торгууль, найдваргүй этгээдийн жагсаалт, зээлийн хязгаарлалт гэх мэт) уулзалтын эрхийн хэрэгт ч тодорхой хэмжээгээр хэрэглэгдэж байна. Гэвч энэ нь заримдаа эцэг, эхийн харилцааг хурцатгах, хүүхдийн сэтгэлзүйд ачаалал нэмэх эрсдэлтэй тул албадлага, зуучлал, сэтгэлзүйн дэмжлэгийг хэрхэн тэнцвэржүүлэх вэ гэдэг нь цаашдын маргаантай сэдэв хэвээр байна.

Иймд, Монгол Улс ба Хятад Улсадын уулзалтын эрхийн эрх зүйн тогтолцоонууд ижил төстэй зорилго (хүүхдийн эрхийг хамгаалах, эцэг, эхийн оролцоог хадгалах)-той боловч хууль зүйн нарийвчилсан зохицуулалт, процедур, гүйцэтгэлийн механизмаар мэдэгдэхүйц зөрүүтэй байна. Энэ нь дараагийн дэд хэсгүүдэд шүүхийн практик, нийгэм-соёлын орчны харьцуулалт, хууль зүйн шилжилт, нутагшуулалтын боломжийг хэлэлцэх онол-практикийн суурь болно.

4.1.2 Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албадлага ба дэмжлэгийн механизм (X₂)-ийн харьцуулсан үнэлгээ

Хүүхдийн уулзалтын эрх бодит амьдрал дээр хэрхэн хэрэгжиж буйг тодорхойлогч дараагийн чухал үл хамаарах хувьсагч бол "Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албадлага ба дэмжлэгийн механизм" (X₂) юм. Шүүхээс уулзалтын журмыг хэдийгээр нарийвчлан тогтоосон ч (X₁), түүнийг албадан гүйцэтгэх эрх зүйн санкци болон нийгэм-сэтгэл зүйн

дэмжлэг үзүүлэх институтийн бүтэц сул байвал хамаарах хувьсагч болох "Уулзалтын эрхийн бодит хэрэгжилт" (Y_2) амьдрал дээр хангагдаж чаддаггүй болох нь хоёр улсын практик кэйсүүдээс тод харагдаж байна.

Энэхүү үзүүлэлтийн хүрээнд Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны практикт тулгарч буй процессын гацаа, санкцийн дутагдалтай байдал болон БНХАУ-ын Ардын шүүхийн албадлагын хатуу арга хэмжээнүүд (торгууль, баривчилгаа, асрамжийн эрхийг шилжүүлэх үндэслэл)-ийг олон нийтийн оролцоотой зуучлах механизмтай хэрхэн уялдуулж буй туршлагыг дараах дэд хэсгүүдээр гүнзгийрүүлэн харьцуулж, үндсэн үр дүнг тодорхойлов.

4.1.2.1 Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн практик дахь бэрхшээл, санкцийн дутагдалтай байдал

Үл хамаарах хувьсагч болох "Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албадлага ба дэмжлэгийн механизм" (X_2)-ийн хүрээнд Монгол Улсын практикт хийсэн судалгааны үр дүнгээс харахад, гэрлэлт цуцалсны дараах хүүхдийн уулзалтын эрхийг албадан хэрэгжүүлэх шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн шатанд хамгийн том процессын гацаа болон эрх зүйн хоосон орон зай үүссэн байна.

Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн холбогдох заалтуудын дагуу хүүхэдтэй холбоотой шийдвэрийг гүйцэтгэхдээ хүүхдийн эрх ашиг, сэтгэл зүйд хохирол учруулахгүйгээр ажиллах ерөнхий зарчимтай. Гэвч бодит амьдрал дээр хамт амьдарч буй эцэг эсвэл эх нь шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй, нөгөө талыг хүүхэдтэй нь уулзуулахгүй байх санаатай үйлдлийг гаргахад шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн зүгээс хэрэглэх хууль зүйн үр ашигтай албадлагын арга хэмжээ болон хатуу санкци маш сул байна.

Шүүхийн практик болон кэйс анализад хийсэн дүн шинжилгээгээр дараах үндсэн бэрхшээлүүд тогтоогдлоо. Үүнд:

(1) Хуулийн албадлагын хүч болон санкци байхгүй байдал: Хамт амьдарч буй тал хүүхдээ нуух, эсхүл "хүүхэд өөрөө уулзах дургүй байна" гэх шалтагаар шүүхийн шийдвэрийг санаатайгаар тасалдуулахад, гүйцэтгэх албанаас захиргааны торгууль тавихаас цаашгүй байна. Энэхүү бага хэмжээний торгууль нь эрхээ зөрчүүлж буй эцэг/эхийн эрхийг хамгаалж чадахгүй бөгөөд уулзалтын эрхэд саад учруулж буй талд ямар нэгэн хууль зүйн бодит дарамт болж чадахгүй байна.

(2) Нигжлэг, нийгэм-сэтгэл зүйн дэмжлэгийн бүтэц сул байдал (X_2): Хүүхэд уулзуулах ажиллагаа нь механик шинжтэй явагддаг бөгөөд процесст хүүхдийн эрхийн улсын байцаагч, гэр бүлийн сэтгэл зүйч эсвэл зуучлагч мэргэжлийн түвшинд оролцох институтийн бүтэц алга байна. Үүнээс шалтгаалан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа амьдрал дээр зөвхөн формал шинжтэй болж, хамаарах хувьсагч болох "Уулзалтын эрхийн бодит хэрэгжилт" (Y_2) нуран унахад хүрч байна.

(3) Хүүхдийн асрамжийн эрхийг өөрчлөх хууль зүйн үр дагавартай уян хатан холбоос байхгүй байдал: Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хооронд логик уялдаа алга байна. Хэрэв нэг тал шүүхээс тогтоосон уулзалтын журмыг удаа дараа санаатайгаар зөрчвөл, энэ үйлдлийг

"хүүхдийн асрамжийн эрхийг нөгөө талд шилжүүлэх (өөрчлөх) үндэслэл" болгон шүүх шууд авч үздэг хууль зүйн хатуу хариуцлагын тогтолцоо Монголулсад бүрдээгүй байна.

Ийнхүү шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албадлага болон дэмжлэгийн механизм (X_2) сул байгаа нь гэрлэлт цуцалсан маргаан дахь салсан эцэг, эхчүүдийн дундах зөрчлийг улам дэвэргэж, хамаарах хувьсагч болох "Хүүхдийн дээд ашиг сонирхлын хангагдах түвшин" (Y_1)-ийг практикт маш доогуур түвшинд барихад хүргэж буй гол хүчин зүйл болох нь эмпирик судалгаагаар батлагдлаа.

4.1.2.2 БНХАУ-ын шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албадлагын хатуу арга хэмжээ ба олон нийтийн оролцоотой зуучлах механизм

Үл хамаарах хувьсагч болох "Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албадлага ба дэмжлэгийн механизм" (X_2)-ийн хүрээнд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын эрх зүйн практикт хийсэн дүн шинжилгээ нь Монгол Улстай харьцуулахад хуулийн албадлагын хатуу санкци болон нийгмийн институтийн дэмжлэгийг хослуулсан маш үр дүнтэй бүтэцтэй болох нь харагдаж байна.

БНХАУ-ын Ардын шүүхийн практикт хүүхдийн уулзалтын эрхийг хэрэгжүүлэхэд саад учруулж буй талд дараах хууль зүйн хатуу хариуцлага, албадлагын арга хэмжээг шат дараатайгаар хэрэглэдэг. Үүнд:

(1) Санхүүгийн болон иргэний эрх зүйн хатуу санкци: Хэрэв хамт амьдарч буй эцэг/эх шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй, уулзалтын эрхэд саад учруулбал Ардын шүүхээс торгох, хувийн дансыг царцаах арга хэмжээ авахаас гадна "Орлогоосоо давсан тансаг хэрэглээг хязгаарлах жагсаалт"-д оруулж, хурдны галт тэрэг болон онгоцоор зорчих эрхийг нь хаадаг байна. Энэхүү албадлага нь зөрчил гаргагч талд амьдралын бодит дарамт болж, шүүхийн шийдвэрийг биелүүлэх хөшүүрэг болдог.

(2) Эрүүгийн хариуцлага болон асрамжийн эрхийг өөрчлөх үндэслэл: Хүүхэд уулзуулах ажиллагааг удаа дараа санаатайгаар тасалдуулсан тохиолдолд БНХАУ-ын Эрүүгийн хуулийн холбогдох заалтын дагуу "Шүүхийн шийдвэр, тогтоолыг биелүүлэхээс татгалзах гэмт хэрэг" гэж үзэж, 15 хүртэл хоногоор саатуулах буюу эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг. Түүнчлэн, уулзалтын эрхэд саад учруулж буй үйлдлийг шүүхээс "хүүхдийн асрамжийн эрхийг нөгөө талд шилжүүлэн өөрчлөх" хамгийн гол үндэслэлүүдийн нэг болгон авч үздэг нь хуулийн албадлагын хүчийг дээд түвшинд барьж байна.

(3) Олон нийтийн оролцоотой зуучлах болон дэмжлэгийн бүтэц (X_2): Хятадын практикт шүүхийн шийдвэрийг механикаар гүйцэтгэхээс илүүтэйгээр хүүхдийн сурч буй сургууль, цэцэрлэг болон оршин суугаа газрын Хөршийн хороо зэрэг олон нийтийн институтийн бүтцийг уулзалтын явцад зуучлагч, хянагчаар оролцуулдаг. Энэ нь хүүхдийг эцэг эхийнх нь хэрүүл маргаанаас тусгаарлаж, сургуулийн орчинд тайван уулзах нийгэм-сэтгэл зүйн таатай дэвсгэрийг бүрдүүлдэг.

Ийнхүү БНХАУ-ын шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албадлагын хатуу хариуцлага болон институтийн дэмжлэгийн механизм (X_2) өндөр байгаа нь хамаарах хувьсагч болох "Уулзалтын эрхийн бодит хэрэгжилт" (Y_2)-ийг тогтвортой өсгөж, улмаар салсан эцэг эхийн маргаанаас үүдэлтэй хүүхдийн сэтгэл зүйн хохирлыг бууруулж, "Хүүхдийн дээд ашиг сонирхлын хангагдах түвшин" (Y_1)-ийг бодитой хангаж байна. Хятадын энэхүү

институтийн туршлага нь Монгол Улсын гэр бүлийн эрх зүйн шинэчлэлд практик ач холбогдолтой загвар болж байна.

4.1.2.3 Маргаан шийдвэрлэх загвар, олон талт механизмын харьцуулалт

Монгол Улсад уулзалтын эрхийн маргааныг шийдвэрлэх үндсэн загвар нь шүүхийн маргаан шийдвэрлэх журам бөгөөд эвлэрүүлэн зуучлал, гэр бүлийн зуучлал хязгаарлагдмал хүрээнд ашиглагдаж байна. Шүүхийн гаднах эвлэрүүлэн зуучлалын тогтолцоо хууль зүйн хувьд бий ч:

- Гэр бүлийн мэргэшсэн зуучлагч бий болгох тогтолцоо сул;
- Хүүхдийн эрхийг төвд тавьсан аргачлал дутмаг;
- Уулзалтын эрхийг урьдчилан нарийвчлан тохиролцох, хэрэгжилтийг хянах загвар хөгжөөгүй.

Хятадад уулзалтын эрхийн маргааныг шийдвэрлэхдээ:

- Гэр бүлийн шүүхийн дотоод зуучлал (法院调解);
- Шүүхийн өмнөх шатны олон нийтийн зуучлал (人民调解);
- Зарим тохиолдолд мэргэжлийн гэр бүлийн зуучлалын төвүүд зэрэг олон түвшний загварыг ашиглаж байна.

Энэ нь уулзалтын эрхийн маргааныг заавал хурц сөргөлдөөнөөр биш, зөвшилцөл, харилцан ойлголцолд тулгуурлан шийдвэрлэх боломжийг нэмэгдүүлдэг.

Гэсэн ч, Монгол Улсын нөхцөлд ийм олон шатлалтай зуучлалыг шууд нэвтрүүлэхэд:

- Мэргэжлийн хүний нөөц, сургалтын чадавх;
- Санхүүжилт, байгууллагын бүтэц;
- Уламжлалт “гэр бүлийн асуудлыг гэртээ шийдэх” соёл зэрэг хүчин зүйлс тодорхой саад, хязгаар болдог.

Тиймээс зуучлалын тогтолцоог хөгжүүлэхдээ Хятад улсын загварыг лавлагаа, санаа авах түвшинд ашиглаж, Монгол Улсын өөрийн уламжлалт олон нийтийн зохицуулалттай хослуулах шаардлагатай.

Дүгнэж хэлбэл, Монгол Улс ба Хятад Улсад шүүхийн практик, гүйцэтгэлийн механизмын харьцуулалт нь: Монгол Улсад эрх зүйн албадлага сул, нийгмийн дэмжлэг хомс, шүүхийн практик үзэмж давамгайлсан, Хятадад эрх зүйн нарийвчилсан удирдамж, албадлагын арга хүчтэй, мэргэшсэн тогтолцоо илүү хөгжсөн ч бүс нутгийн ялгаа, албадлагын сөрөг үр нөлөө зэрэг асуудал байна. Энэ нь Монгол Улсад уулзалтын эрхийн тогтолцоог шинэчлэхдээ Хятад улсын туршлагын давуу талыг шүүн тунгааж авах, сул талыг зайлсхийх шаардлагатайг тодорхой харуулна.

4.1.3 Нийгэм-соёлын орчны харьцуулалт

4.1.3.1 Гэр бүлийн ойлголт, хүүхдийн байр суурийн харьцуулалт

Монгол Улс, Хятад Улсын нь хоёулаа Азийн уламжлалт соёлтой, гэр бүлийн эв, ураг төрлийн холбоог эрхэмлэдэг нийтлэг шинжтэй. Гэвч гэр бүлийн бүтэц, хүүхдийн

байр суурийн талаарх ойлголт, түүний уулзалтын эрхэд үзүүлэх нөлөө зарим талаар ялгаатай.

Монгол Улсын уламжлалт нүүдэлчин соёлд хүүхэд нь өрх айл, ураг овгийн хөдөлмөрийн нэгж, үр удмын залгамжлагч, ахмадын хамгаалалт дунд өсдөг. Салалт ховор, сөрөг үнэлэгддэг үзэгдэл байсан тул дараах уулзалтын эрхийн тухай тусгай ойлголт бүрэлдээгүй.

Хятадад уламжлалт Конфуци-ийн гэр бүлийн загвар, “хүндэтгэл” гүн нөлөөтэй ч сүүлийн хэдэн арван жилд хотжилт, жижиг гэр бүл, “ганц хүүхдийн бодлого” зэргийн нөлөөгөөр хүүхдийн байр суурь “гэр бүлийн төв” болж өөрчлөгдсөн. Хүүхдэд материаллаг болон сэтгэлзүйн ихээхэн анхаарал хандуулах хандлага (“эрхлүүлсэн хүүхэд”) түгээмэл бөгөөд энэ нь уулзалтын эрхийн маргаанд хүүхдийн дуу хоолой, эрх ашгийг нийгмийн түвшинд илүү “анхаарлын төвд” авчрах нэг хүчин зүйл болдог.

4.1.3.2 Хүүхдийн эрхийн талаарх ойлголтын харьцуулалт

Хүүхдийн эрхийн талаарх албан ёсны тунхаглал хоёр улсад төстэй: хоёулаа “Хүүхдийн эрхийн тухай конвенц”-ыг соёрхон баталж, үндэсний хууль тогтоомждоо хүүхдийн эрхийн ерөнхий зарчим, хамгаалалтын арга хэмжээг тусгасан.

Практик түвшинд:

- Монгол Улсад хүүхдийн эрхийн талаарх ойлголт сүүлийн жилүүдэд эрчимтэй нэмэгдэж, олон нийтийн кампанит ажил, ТББ-уудын үйл ажиллагаа нөлөөтэй болсон ч маргаанд хүүхдийн эрхийг эцэг, эхийн зөрчлийн дараагийн түвшний асуудал гэж харах хандлага үлдэж байна. Хүүхдийн санал бодлыг дуугаргах, оролцоог хангах тогтолцоо сул, “хүүхдийг маргаанд татахгүй” гэсэн нэрийн дор түүний дуу хоолойг бүрэн хаах тохиолдол ч бий.

- Хятадад хүүхдийн эрхийн талаар төрийн бодлого, хэвлэл мэдээлэл, боловсролын системээр дамжсан системтэй сурталчилгаа өрнөж, “хүүхдийн эрх ашиг нэн тэргүүнд байх” гэсэн үг хэллэг бодлогын баримт бичиг, шүүхийн шийдвэрт тогтмол хэрэглэгддэг болсон. Гэсэн ч уламжлалт эрх мэдлийн бүтэц, шалгалт-төвтэй боловсролын системийн дарамт, эцэг, эхийн өндөр хүлээлттэй огтлолцож, хүүхдийн эрх чөлөө, сэтгэлзүйн эрүүл мэндийг зөрчих эрсдэл байсаар байна. Уулзалтын эрхийн маргаанд хүүхдийн санал бодлыг формал түвшинд сонсох боловч, түүнийг бодит шийдвэр гаргалтад ямар жинтэй тусгах вэ гэдэг дээр нэг мөр стандарт бүрэн тогтоогдоогүй.

4.1.3.3 Нийгмийн дэмжлэгийн тогтолцооны харьцуулалт

Монгол Улсад уулзалтын эрхийн хэрэгжилтийг дэмжих нийгмийн тогтолцоо хөгжлийн эхэн шатандаа байна.

- Гэр бүлийн зөвлөгөө, сэтгэлзүйн үйлчилгээ, мэргэшсэн гэр бүлийн зуучлал цөөн төвд, ихэвчлэн Улаанбаатар зэрэг том хотуудад төвлөрсөн;
- Орон нутагт ийм үйлчилгээ бараг үгүй, шүүх, сум, багийн захиргаанд тулгуурласан зөөлөн хэлбэрийн олон нийтийн зохицуулалт гол үүргийг гүйцэтгэдэг;
- Хүүхэд хамгааллын байгууллага, сургууль, эрүүл мэндийн байгууллагын

хоорондын уялдаа сул, уулзалтын эрхийн асуудлыг системтэйгээр хамтарч шийдэх механизм тодорхойгүй.

- Харин Хятад Улсад:
- Том хот, хөгжингүй бүс нутагт гэр бүлийн үйлчилгээний төв, эмэгтэйчүүд, хүүхдийн үйлчилгээний байгууллагууд, мэргэшсэн эвлэрүүлэн зуучлал, сэтгэлзүйн зөвлөгөөний тогтолцоо илүү хөгжсөн;
- Гэр бүлийн шүүхийн дэргэд мэргэжлийн баг (шүүгч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эвлэрүүлэгч) бүрдүүлэх оролдлого хийгдэж байна;
- Гэвч бүс нутгийн ялгаа их, хөдөө, алслагдсан бүсэд ийм үйлчилгээний хүртээмж сул, уулзалтын эрхийн маргааныг уламжлалт арга, ерөнхий шүүхийн журмаар шийдвэрлэх нь түгээмэл.

Ийнхүү харьцуулбал, Монгол Улсад уулзалтын эрхийн нийгмийн дэмжлэгийн тогтолцоо ерөнхийдөө сул, жигд бус хөгжсөн бол Хятад Улсад зарим бүс нутагт нэлээд ахиц гарсан ч нийтлэг, тэгш хүртээмжтэй биш байна. Энэ нь Монгол Улсад Хятад улсын туршлагыг ашиглахдаа “иж бүрэн системийг шууд хуулбарлах” бус, өөрийн нөөц, бүтцэд нийцсэн дэс дараатай, зорилтот хөгжлийн загвар боловсруулах шаардлагатайг илтгэнэ.

4.1.4 Харьцуулсан судалгааны онолын дүгнэлт

4.1.4.1 Хууль зүйн шилжилт, нутагшуулалтын боломж, хязгаар

Монгол Улс ба Хятад Улсад уулзалтын эрхийн тогтолцоог харьцуулсан дүнгээс үзэхэд Хятад улсын загвараас Монгол Улсад хууль зүйн шилжилт хийх боломжтой хэд хэдэн элемент тодорч байна. Энэ нь үл хамаарах хувьсагч болох "Хууль эрх зүйн зохицуулалтын нарийвчлал" (Х₁)-ийг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой. Үүнд:

- Уулзалтын эрхийг Иргэний хуульд хийсэнтэй адил тусгай институт болгон хуульчлах;
- Уулзалтын агуулга, хэлбэр, давтамжийг харьцангуй нарийвчилсан байдлаар хуульчилж, шүүхийн практикт баримтлах “жишиг стандарт” боловсруулах;
- Гэр бүлийн хэрэгт тусгайлсан мэргэшсэн шүүх, журам, эвлэрүүлэн зуучлалын тогтолцоо бий болгох;
- Шийдвэр гүйцэтгэлийг хангах зөөлөн ба хатуу албадлагын хосолсон механизм (анхааруулга, торгууль, тодорхой хязгаарлалт гэх мэт) нэвтрүүлэх боломжтой.

Гэвч хууль зүйн шилжилтийн онолын үүднээс дараах хязгаар, эрсдэлийг харгалзах шаардлагатай. Энэ нь үл хамаарах хувьсагч болох "Албадлага ба дэмжлэгийн механизм" (Х₂)-ийг нутагшуулахад тулгарч буй хязгаарлалтууд юм:

1. Институтийн төвөгшил: Гэр бүлийн шүүх болон нийгмийн дэмжлэгийн цогц тогтолцоо нь санхүү, хүний нөөц, сургалтын өндөр шаардлагатай тул Монгол Улсад шууд бүхэлд нь нэвтрүүлэхэд бэрхшээлтэй.
2. Соёлын онцлог: Хятад Улсад өргөн хэрэглэгддэг нийгмийн зээлийн арга нь Монгол Улсын эрх зүйн соёл, хүний эрхийн ойлголт, нийгмийн бүтэцтэй бүрэн нийцэхгүй эсвэл эсэргүүцэлтэй тулгарах магадлалтай.
3. Эрх зүйн текст ба практикийн зөрчил дахин давтагдах эрсдэл: Хятадад ч уулзалтын эрхийн хууль зүйн нарийвчилсан зохицуулалт практикт бүрэн хэрэгжээгүй нөхцөлд ижил загварыг Монгол Улсад хурдан нэвтрүүлбэл “цаасан дээрх эрх давтагдах,

практикт зөрчил давтагдах” боломжтой бөгөөд энэ нь хамаарах хувьсагч болох "Уулзалтын эрхийн бодит хэрэгжилт" (Y_2)-ийг бууруулах эрсдэлтэй.

Иймээс Монгол Улсад Хятад улсын туршлагыг эрх зүйн шилжилтийн онолын үүднээс:

- Дэс дараалсан (эцэст нь иж бүрэн системд хүрэх урт хугацааны шаталсан шинэчлэл),
- Сонгох (зөвхөн тодорхой тохирох тогтолцоог шилжүүлэн авах),
- Нутагшуулсан (Монгол Улсын соёл, нийгмийн бүтэцтэй нийцүүлэн өөрчилсөн) хэлбэрээр нэвтрүүлэх нь илүү зочимжтой гэж үзэж болно.

4.1.4.2 Хүүхдийн эрхийг хамгаалах тогтолцооны үндэслэл

Харьцуулсан судалгаанаас харахад хүүхдийн уулзалтын эрхийг хамгаалах институтийн төстэй ба ялгаатай талтай.

Төстэй тал:

- Хүүхдийн эрхийг хамгаалах зарчмыг хууль тогтоомжид тунхагласан;
- Эцэг, эхийг хүүхдийн амьдралд оролцуулахыг зорьдог;
- Уулзалтын эрхийн хэрэгжилтийг шүүхээр баталгаажуулах үндсэн загвартай.

Ялгаатай тал:

- Монгол Улсад хүүхдийн эрхийг хамгаалах тогтолцоо зарчим төвтэй, практик механизм сул;
- Хятадад эрх зүйн зохицуулалт, институтийн зохион байгуулалт илүү нарийвчилсан ч албадлагын хүчтэй тогтолцоо давамгайлж, заримдаа “эрх хамгаалах” ба “хяналтын” үйл ажиллагаа давхцах эрсдэлтэй.

Энэ харьцуулалтаас гарч буй онолын гол сургамж нь: Хүүхдийн эрхийг хамгаалах институтийг төлөвлөхдөө “эрх – хариуцлага – албадлага – дэмжлэг” гэсэн дөрвөн элементийг тэнцвэржүүлэх шаардлагатай. Зөвхөн эрх тунхагласан (Монгол Улсын өнөөгийн байдал) тохиолдолд гүйцэтгэл сул, эрх “хоосон” үлдэнэ (Y_2 сул). Зөвхөн албадлага хүчтэй (Хятад улсын зарим практик) бол хүүхдийн эрхийг хамгаалах нэрийн дор эцэг, эхийн харилцааг хурцатгах, хүүхдийг зөрчил дунд оруулах эрсдэлтэй бөгөөд энэ нь хамаарах хувьсагч болох "Хүүхдийн дээд ашиг сонирхлын хангагдах түвшин" (Y_1)-д сөргөөр нөлөөлж болзошгүй.

Тэнцвэртэй тогтолцоо: * Эрхийг тодорхой, ойлгомжтой хуульчлах (X_1);

- Хариуцлагыг эцэг, эхэд тодорхой хуваарилах;
- Албадлагыг хэмжээтэй, шаталсан, хүүхдийн эрхэд ээлтэй байдлаар хэрэглэх (X_2);
- Мэргэжлийн, нийгмийн дэмжлэгийг тогтолцоотойгоор хангах дээр суурилна (X_2).

4.1.4.3 Харьцуулсан судалгааны арга зүйн сургамж

Монгол Улс ба Хятад Улсын уулзалтын эрхийн харьцуулсан энэхүү судалгаа нь харьцуулсан эрх зүйн арга зүйн хувьд хэд хэдэн чухал сургамжтай.

1. Функционалист арга нь өөр өөр эрх зүйн тогтолцоо ижил асуудлыг хэрхэн шийдэж байгааг ойлгоход ихээхэн тус дөхөмтэй боловч, зөвхөн “шийдэл”-ийг өөрөө харьцуулаад, түүнд тулгуурлаж буй соёл, нийгмийн суурь нөхцөл болон бодит

хэрэгжилтийн механизмыг хамтад нь авч үзэхгүй бол “амжилттай загвар” хэмээн нэрлэгдэж буй зүйлийг буруу ойлгох эрсдэлтэй.

2. Хэрэв соёлын харьцангуй үзлийг үл харгалзвал, гаднын туршлагыг амархан “норматив загвар” болгон шүтэж, тухайн улсын туршлага Монгол Улсын нөхцөл байдалд үнэндээ тохирох эсэхийг хангалттай судлалгүйгээр яаравчлан хууль зүйн хувьд шилжүүлэн нэвтрүүлэхэд хүрч, нэг төрлийн дарамт, “эрх зүйн колоничлол”-ын шинжийг бий болгож болзошгүй. Монгол Улс ба Хятад Улсын жишээ харуулж байгаачлан, хоёр улс социалист уламжлал, соёлын ойр хөрстэй байсан ч нийгмийн бүтэц, институцийн чадавх, нөөцийн байдал зэргээрээ мэдэгдэхүйц ялгаатай тул бие биеийнхээ туршлагыг энгийнээр шууд хуулбарлах боломжгүй.
3. Харьцуулсан судалгаанд үнэлгээний төвийг сахисан байр суурь баримтлах нь онолын түвшинд онцгой ач холбогдолтой. Энэхүү судалгаанд Хятад улсын тогтолцоог нэг талыг барьсан эерэг “загвар” гэж үзэхийн оронд давуу болон сул тал, эрсдэлийг нь давхар авч үзэж, Монгол Улсын нөхцөл байдалд ямар элемент нь тохирох, аль нь тохирохгүйг ялган тодорхойлохыг зорьсон. Ийм хандлага нь ирээдүйн харьцуулсан судалгаанд “шүүмжлэлтэй суралцах” (critical learning) арга барилыг чухалчлах ёстойг онцолж байна.

Иймээс Монгол Улсын уулзалтын эрхийн харьцуулсан судалгаа нь зөвхөн хоёр улсын бодлогын санал боловсруулахад хувьномын хувь нэмэр оруулахад зогсохгүй, бүс нутгийн түвшинд хүүхдийн эрхийг хамгаалах (Y_1), гэр бүлийн эрх зүйн шинэчлэлтэй холбоотой харьцуулсан эрх зүйн онол, арга зүйн хэлэлцүүлэгт тодорхой хувь нэмэр оруулах боломжтой гэж үзэж болно.

4.1.5 Нийтлэг сорилт, онцлог шинж, харилцан суралцах боломж

4.1.5.1 Нийтлэг тулгамдсан сорилтууд

Монгол Улс болон Хятад Улс уулзалтын эрхийн тогтолцооны хувьд ижил шинжтэй хэд хэдэн асуудалтай байна.

“Эрх ба гүйцэтгэл” хооронд зөрөлдөөн байсаар байгаа нь түгээмэл бөгөөд хоёр улсад хоёул хүүхдийн эрх, уулзалтын эрхийг хуульд тунхагласан ч, практик хэрэгжилтийн үед шүүхийн шийдвэр бүрэн биелэхгүй, олон тохиолдолд хүүхэд эцэг, эхтэйгээ тогтвортой, системтэй уулзах нөхцөл бүрдэхгүй байна. Энэ нь хамаарах хувьсагч болох "Уулзалтын эрхийн бодит хэрэгжилт" (Y_2) хоёр улсын практикт аль алинд нь тодорхой хэмжээний сорилттой тулгарч буйг илтгэнэ.

Хүүхдийн санал бодлыг хамгаалахтай холбоотой мэргэжлийн, системтэй үнэлгээний тогтолцоо сул хөгжсөн нь бас нэг нийтлэг тал юм. Хүүхдийн дуу хоолойг сонсох хэрэгцээ, хууль зүйн шаардлага нэмэгдэж байгаа ч, гаднын зохисгүй нөлөөллөөс ангид байлгаж, сэтгэлзүйн мэргэжлийн үнэлгээ дээр тулгуурлан, тогтвортой хэлбэрээр хүүхдийн саналыг шийдвэр гаргалтад тусгах институцийн шийдэл хангалттай бүрдээгүй байна. Үүн дээр нийгмийн дэмжлэгийн тогтолцоо, мэргэшсэн үйлчилгээний хомсдол (X_2) давхцдаг.

Уулзалтын эрхийн гүйцэтгэлд оролцох ёстой нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, гэр бүлийн зуучлагчдын тоо, мэргэжлийн түвшин, үйлчилгээний хүртээмж хоёр улсад

ерөнхийдөө дутмаг бөгөөд ялангуяа алслагдсан бүс нутагт энэ хүндрэл илүү хурц хэлбэрээр илэрч байна.

4.1.5.2 Тогтолцооны тус тусын онцлог, давуу тал

Монгол Улсын хувьд:

- Хууль тогтоомжийн бүтэц харьцангуй энгийн, уян хатан, шүүхийн үзэмжээр тухайн маргааны онцлогт нийцүүлэн шийдвэр гаргах боломж нээлттэй;
- Уламжлалт зохицуулалт, эвлэрэн шийдвэрлэх хэлбэрүүд тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлж чадна;
- Хүүхдийн эрхийн талаарх нийгмийн ойлголт ахиж байгаа нь ирээдүйн эрх зүйн шинэчлэлд таатай суурь болж байна.

Сул тал нь эрх зүйн тодорхой бус байдал, гүйцэтгэлийн механизмын сул хөгжил, мэргэшсэн тогтолцооны хомсдолд төвлөрч байна.

Харин Хятад Улсын хувьд:

- Уулзалтын эрхийг Иргэний хуульд тусгай институт болгон хуульчилсан, эрх зүйн нарийвчилсан зохицуулалттай;
- Гэр бүлийн шүүх, эвлэрүүлэн зуучлал, нийгмийн үйлчилгээний институтийн шинэчлэл тодорхой ахицтай;
- Шийдвэр гүйцэтгэлд албадлагын арга, нийгмийн зээлийн механизмыг ашиглаж, шүүхийн шийдвэрийн заавал биелүүлэх шинжийг тодотгож байна.

Сул тал нь бүс нутгийн ялгаа, албадлагын арга хэмжээг хэтэрхий түшиглэх эрсдэл, хүүхдийн эрхийг хамгаалах нэрийн дор эцэг, эхийн харилцааг хурцатгах магадлалтай.

4.1.5.3 Харилцан суралцах, нутагшуулах боломжит хувилбар

Харьцуулсан шинжилгээний үндсэн дээр хоёр улсын хооронд харилцан суралцах боломжийг дараах байдлаар тодорхойлж болно. Монгол Улсын хувьд Хятад Улсын туршлагаас:

- Уулзалтын эрхийг хуульчлах түвшинд илүү тодорхой болгох (тусгай заалт, агуулга, журам, хязгаарлалт, сэргээх механизм);
- Гэр бүлийн хэрэгт мэргэшсэн шүүхийн бүтэц, эвлэрүүлэн зуучлал, нийгмийн үйлчилгээний нэгдсэн загвар бий болгох;
- Шийдвэр гүйцэтгэлд шаталсан, хэмжээтэй албадлагын арга (анхааруулга, торгууль гэх мэт) нэвтрүүлэх зэрэг чиглэлээр суралцах боломжтой.

Хятад улсын хувьд Монгол Улсын нөхцөл, туршлагаас:

- Албадлагын арга хэмжээг хэрэглэхдээ хүүхдийн сэтгэлзүй, эцэг, эхийн харилцааны урт хугацааны үр дагаврыг илүү нухацтай харгалзах;
- Орон нутгийн уламжлалт, хамтын шийдвэр гаргалтын зарим хэлбэрийг (олон нийтийн, ахмадын оролцоо) хүүхдийн эрхийн орчин үеийн стандартад нийцүүлэн, соёлд суурилсан дэмжлэгийн механизм болгон ашиглах;
- Уулзалтын эрхийн гүйцэтгэлийг хэмжих, үнэлэх чанарын болон тоон үзүүлэлт, мониторингийн систем хөгжүүлэх зэрэг чиглэлд суралцах боломжтой.

Монгол Улсад цаашид уулзалтын эрхийн тогтолцоог шинэчлэхдээ Хятад улсын туршлагыг болзолтой, шүүмжлэлтэйгээр ашиглах, өөрийн нийгэм-соёлын онцлог, институтийн чадавх, хүний нөөц, эдийн засгийн нөхцөлд нийцүүлэн нутагшуулалтын загвар боловсруулах нь оновчтой гэж дүгнэж болно.

4.1.6 Төлөөлөх кейсүүдийн харьцуулсан шинжилгээ ба судалгааны үр дүнг нотлох нь

Шүүхийн практикт тулгуурлан судалгааны боловсруулалтыг гүнзгийрүүлэх зорилгоор Монгол Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын шүүхийн практикт шийдвэрлэгдсэн төлөөлөх кейсүүдэд харьцуулсан шинжилгээ хийлээ. Энэхүү шинжилгээ нь судалгааны ажлын дүгнэлт болон бодлогын санал зөвлөмжийн эмпирик (бодит практик) үндэслэл болох юм.

Кейс 1 (Монгол Улс): Эцэг "А" нь хүүхэдтэй уулзах эрхээ тогтоолгохоор шүүхэд нэхэмжлэл гаргахад шүүхээс "талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр сард 2-оос доошгүй удаа уулзуулсугай" гэсэн ерөнхий зарчмын шийдвэр гаргасан байна. Гэвч шийдвэр гүйцэтгэх шатанд асран хамгаалагч тал "хүүхэд өөрөө уулзахыг хүсэхгүй байна" гэх шалтгаанаар уулзуулахаас татгалзаж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нэг жилийн турш гацаж, үр дүнгүй болжээ.

Үзүүлэлтийн шинжилгээ: Шүүхийн шийдвэрийн агуулга хэт ерөнхий, уулзах цаг, хугацаа болон байршлыг нарийвчлан заагаагүй нь гүйцэтгэлийн шатанд дараагийн маргаан үүсэх гол үндэс болсон байна. Шийдвэр гүйцэтгэгчийн зүгээс зөвхөн ятгах, ухуулах зэрэг зөөлөн арга хэрэглэж, хууль тогтоомжийн хүрээнд шаталсан хариуцлагын механизм дутагдсанаар хүүхдийн эрх бодит байдал дээр хэрэгжих боломжгүй хууль зүйн үр дагаварт хүрчээ.

Кейс 2 (БНХАУ): Эх "В" нь хүүхэдтэй уулзах эрхээ тогтоолгохоор нэхэмжлэл гаргасан. Шүүхийн шийдвэрт "Сар бүрийн хоёр дахь Бямба гарагийн 10:00 цагаас Ням гарагийн 17:00 цаг хүртэл" уулзахаар нарийвчлан зааж, уулзалт эхлэх, дуусах болон хүүхэд хүлээлгэн өгөх цэгийг (шүүхийн гэр бүлийн өрөө) тодорхойлсон байна. Асран хамгаалагч тал уулзалтад саад учруулахыг оролдоход шүүхээс "Урьдчилан сануулах" захиргааны арга хэмжээ авч, торгууль ногдуулахыг албан ёсоор мэдэгдсэнээр шүүхийн шийдвэр амжилттай хэрэгжсэн байна.

Үзүүлэлтийн шинжилгээ: Уулзалтын цаг хугацаа, процедурыг шүүхийн шийдвэрт нарийвчлан тогтоосон нь талуудын дунд үл ойлголцол, субъектив үзэмжээр хандах эрсдэлийг мэдэгдэхүйц бууруулсан байна. Шийдвэр гүйцэтгэх явцад зөвхөн ятгах бус, захиргааны болон эрх зүйн хөшүүргийг хослуулан ашиглах нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн бодит үр нөлөөг дээшлүүлдэг болох нь энэхүү кейсээр батлагдаж байна.

Кейс шинжилгээний нэгдсэн дүгнэлт ба нотолгоо:

Дээрх төлөөлөх кейсүүдийн харьцуулсан шинжилгээ нь энэхүү судалгааны ажлын хүрээнд дэвшүүлсэн дараах үндсэн дүгнэлтүүдийг бодит практикийн түвшинд нотолж байна. Үүнд:

1. Тодорхой бус байдал нь зөрчлийн эх үүсвэр: Монгол Улсын шүүхийн практикт гарсан кейс нь шүүхийн шийдвэр ерөнхий байх тусам гүйцэтгэлийн шатанд эцэг эхийн

зөрчил улам хурцаддаг бөгөөд уулзах эрхийн журмыг заавал нарийвчлан хуульчлах шаардлагатайг нотолж байна.

2. Шаталсан албадлагын механизмын үр нөлөө: БНХАУ-ын шүүхийн практик нь эрх зүйн зөөлөн болон хатуу албадлагын хослол (сануулах, торгуулах) нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд үр дүнтэй хүчтэй хөшүүрэг болдог бөгөөд үүнийг Монгол Улсын нөхцөлд дасан зохицуулж нутагшуулах боломжтойг харууллаа.

3. Мэргэжлийн үнэлгээний хэрэгцээ: Хүүхдийн сэтгэл зүйн үнэлгээг ашиглахгүйгээр зөвхөн асран хамгаалагч талын дамжуулсан хүүхдийн аман тайлбарт тулгуурлах нь хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалахад хангалтгүй бөгөөд шүүхийн практикт сэтгэл зүйч, нийгмийн ажилтныг заавал оролцуулах шаардлагатайг баталж байна.

4.2. Монгол Улсын эрх зүйн шинэчлэл, бодлогын санал

Энэхүү судалгааны ажлын хүрээнд хийсэн Монгол Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын гэрлэлт цуцалсан маргаан дахь хүүхдийн уулзалтын эрхийн хэрэгжилтийн харьцуулсан анализ, шүүхийн шийдвэрүүдийн эмпирик өгөгдөл нь Монгол Улсын гэр бүлийн эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох онол болон практикийн үндэслэл болж байна. Судалгаагаар нотлогдсон үл хамаарах хувьсагчууд болох "Хууль эрх зүйн зохицуулалтын нарийвчлал" (X_1) болон "Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албадлага, дэмжлэгийн механизм" (X_2)-ийн сул байдлыг арилгах нь хамаарах хувьсагч болох "Хүүхдийн дээд ашиг сонирхлын хангагдах түвшин" (Y_1)-ийг олон улсын стандартад нийцүүлэн дээшлүүлэх цорын ганц зам юм.

Иймд Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон шүүхийн практикт хэрэгжүүлэх боломжтой эрх зүйн шинэчлэлийн үндсэн чиглэл, бодлогын тодорхой саналуудыг Хятад улсын институтийн туршлагыг өөрийн орны нийгэм-соёлын хөрсөнд нутагшуулах (legal transplation) онолын үүднээс дараах дэд бүлгүүдэд хуваан боловсруулж дэвшүүлэв.

4.2.1 Монгол Улсын уулзалтын эрхийн эрх зүйн шинэчлэлийн санал

4.2.1.1 Хууль тогтоомжийн шинэчлэл

(1) Уулзалтын эрхийг тусгай институт болгон хуульчлах

Одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж буй «Гэр бүлийн тухай» хуульд уулзалтын эрхийг зөвхөн зарчмын шинжтэй цөөн хэдэн заалтаар тогтоосон байдаг тул хуульд нэмэлт өөрчлөлт оруулахдаа: уулзалтын эрхийг тусгай зүйл заалт эсхүл тусгай бүлгээр илүү дэлгэрэнгүй зохицуулах; уулзалтын эрхийн талаар эрх зүйн тодорхой, нэг мөр тодорхойлолт гаргаж, энэхүү эрх нь нэг талаас хүүхдийн эрх, нөгөө талаас хүүхэдтэй хамт амьдрахгүй байгаа эцэг, эхийн эрх гэсэн хос шинж чанартай болохыг тодруулах; уулзалтын эрхийг хүүхэд эцэг, эхтэйгээ харилцаагаа хадгалах, гэр бүлийн холбоо бүрэн тасрахыг урьдчилан сэргийлэхэд чиглэсэн эрхийн нэг бүрэлдэхүүн хэсэг гэж үзэж, энэ замаар хүүхдийг бие даасан эрхийн субъект болох байр суурийг бэхжүүлэх шаардлагатай.

Уулзалтын эрхийн зохицуулалтыг нарийвчлан тодорхойлохын зэрэгцээ, асран хамгааллын тогтолцоог ч илүү тодорхой, нарийвчилсан түвшинд хуульчлах нь зүйтэй. Жишээлбэл, «Гэр бүлийн тухай» хуульд асран хамгаалагчийн нөхцөл, шалгуур, дараалал, шүүхээр асран хамгаалагчийг томилох журам, мөн асран хамгааллыг хүчингүй болгох

болон өөрчлөхийн материаллаг ба процессуал үндэслэлүүдийг нэмэх, үүнийг дагаад асран хамгааллын тогтолцоо болон уулзалтын эрхтэй холбоотой маргааны хоорондын уялдаа холбоо, харилцан нөлөөллийг илүү тодорхой болгох нь “хүүхдийн эрх ашиг нэн тэргүүнд байх” зорилгыг хэрэгжүүлэхэд онцгой ач холбогдолтой.

(2) Агуулга, хэлбэр, давтамжийг нарийвчлан тогтоох:

Агуулгын хувьд уулзалтын эрхийг хэд хэдэн үндсэн элементэд хуваан тодорхойлох боломжтой. Үүнд, нүүр тулсан биечлэн уулзалт, утсаар, интернэтээр, захидлаар зэрэг хэлбэрээр харилцах, мөн хүүхдийн байдлын талаарх мэдээлэл авах зэрэг орно. Уулзалтын тоо болон үргэлжлэх хугацааг заавал хуульд заасан хатуу, тогтмол заалт болгох шаардлага зайлшгүй биш боловч “жишиг заалт” (guideline) хэлбэрээр чиглүүлэх стандартыг тогтоож болно. Жишээлбэл, сард уулзах доод тоо, амралтын өдрүүдийн уулзалт, баярын өдрүүдийн уулзалт, амралтын хугацаанд уулзах зохицуулалт зэрэг бөгөөд эдгээрийг хуульд тусган, шүүх болон талууд тодорхой уулзалтын хуваарь гаргахдаа эдгээр жишиг стандартыг суурь баримжаа болгохыг хуульчлан заах боломжтой. тогтоохдоо эдгээр жишиг стандартыг суурь баримжаа болгон ашиглахыг хуульчилна.

(3) Процедур, шүүхэд хандах замыг тодорхой болгох:

«Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай» хуулийн түвшинд: уулзалтын эрхтэй холбоотой маргааныг бие даасан хэрэг хэлбэрээр шийдвэрлэх боломжтойг тодорхой зааж өгөх; ийнхүү төрлийн хэргийн шийдвэр, тогтоолд уулзалтын нарийвчилсан журам, хугацаа болон гүйцэтгэлийн хяналтын талаар заавал тусгай хэсэг оруулах шаардлагыг тогтоох; мөн одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй уулзалтын журмыг өөрчлөх, тодруулах, түүнчлэн уулзалтын эрхийн шийдвэрийг гүйцэтгэхийг шаардах нэхэмжлэлийг хялбаршуулсан буюу түргэн шуурхай журмаар шийдвэрлэх зориулалттай тусгай процедур (жишээлбэл, товч шүүлт, түргэн шийдвэрлэх журам гэх мэт)-ыг бий болгох санал дэвшүүлэх боломжтой.

(4) Хязгаарлах, зогсоох, сэргээх зохицуулалтыг шинэчлэх

«Гэр бүлийн тухай» хуульд: уулзалтын эрхийг хязгаарлах, зогсоох боломжтой түгээмэл үндэслэлүүдийг (жишээлбэл, хүүхдийн бие махбод ба сэтгэл зүйд ноцтой аюул учирч болзошгүй нөхцөл байдал, гэр бүлийн хүчирхийлэл, удаан хугацаанд үргэлжилсэн архидалт, мансууруулах бодис хэрэглэх, хүүхдийг хууль бус үйлдэлд татан оролцуулах гэх мэт) нэрлэн заах; уулзалтын эрхийг хязгаарлах, зогсоох нь ердийн бус, онцгой шинжтэй бөгөөд түр хугацааны арга хэмжээ байх ёстойг тодорхой заах, мөн нөхцөл байдал өөрчлөгдвөл талууд уулзалтын эрхийг сэргээхийг шүүхээс хүсэх эрхтэй байхыг хуульчлан тогтоох; уулзалтын эрхийг сэргээх, түүнчлэн үе шаттайгаар хэвийн түвшинд эргэн шилжүүлэх журам (жишээлбэл, эхний шатанд хяналттай, гуравдагч этгээдийн байлцуулалттай уулзалт зохион байгуулж, дараагийн шатанд энгийн уулзалт руу шилжих гэх мэт)-ыг бий болгох шаардлагатай.

(5) Гүйцэтгэлийн механизмыг хуульчлах

«Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай» хууль болон «Гэр бүлийн тухай» хуульд: уулзалтын эрхийн тухай шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд эдийн засгийн торгууль, албан ёсны бичгээр анхааруулах, тодорхой хүрээнд эрх хязгаарлах зэрэг

зөөлөн албадлагын арга хэмжээг (жишээлбэл, тухайн этгээдийн хүүхдийн тэтгэмжийн талаарх зарим хөнгөлөлтийг дахин хянах гэх мэт) нэвтрүүлэх; шийдвэр гүйцэтгэх явцад нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, аймаг, сум болон түүнээс доош түвшний нийгмийн ажилтан заавал оролцохыг хуульд тусгах; уулзалтын эрхийн талаарх шийдвэрийг гүйцэтгэхдээ дагаж мөрдөх ёстой тодорхой хил хязгаарыг тогтоож, жишээлбэл, хүүхдийг хүч хэрэглэн албадан авч явахыг хориглох, эсвэл хүүхдэд удаа дараа байцаалт мэт асуулт тавьж сэтгэлзүйн дарамт үзүүлэхийг хориглох замаар хүүхдийн эрхийг зөрчихгүй байх, шинэ төрлийн сэтгэлзүйн хохирол үүсгэхгүй байх нөхцөлийг баталгаажуулах нь зүйтэй.

(6) Уулзалтын эрхийг санаатайгаар зөрчих, буруугаар ашиглах зан үйлд шаталсан хариуцлагын тогтолцоо бүрдүүлэх

Монгол Улсын одоогийн эрх зүйн зохицуулалтанд уулзалтын эрхийг санаатайгаар саатуулах, эсвэл уулзалтын эрхийг “хүүхдийг өөртөө татах”, “нөгөө талыг шийтгэх” хэрэгсэл болгон ашиглах зэрэг ноцтой зөрчилд ногдуулах хариуцлагын тогтолцоо тодорхой бус байна. Иймээс хуульд дараахыг тусгах шаардлагатай. Үүнд: олон удаа, ямар нэгэн үндэслэлгүйгээр шүүхийн тогтоосон уулзалтын журмыг биелүүлэхээс татгалзах зан үйл; хүүхдийг нөгөө эцэг, эхтэй нь уулзахаас санаатайгаар татгалзуулах, нөгөө талын эсрэг дайсагнал, сөрөг хандлага хүүхдийн сэтгэл зүйд зориуд төлөвшүүлэх зан үйл; уулзалтын явцад хүүхэд болон нөгөө талд хүчтэй сэтгэлзүйн дарамт, айдас, үзэн ядалт үүсгэх замаар уулзалтын эрхийг ноцтойгоор буруугаар ашиглах зан үйл зэрэг зонхилох хэлбэрүүдийг тодорхой нэрлэн зааж, эдгээрт шаталсан хариуцлагын механизм (анхааруулга өгөх, эвлэрүүлэн зуучлалд албадан хамруулах, бага хэмжээний торгууль оногдуулах, уулзалтын журмыг дахин хянаж өөрчлөх, давтан тохиолдолд уулзалтыг хяналттайгаар явуулах хэлбэр рүү шилжүүлэх, онц ноцтой тохиолдолд уулзалтын эрхийг тодорхой хугацаагаар хязгаарлах гэх мэт)-ыг хуульчлан тогтоох шаардлагатай.

Ийм шаталсан, тохиромжтой хэмжээтэй хариуцлагын тогтолцоог бүрдүүлэхдээ Хятад Улсын шийдвэр гүйцэтгэлийн практикт хэрэглэгдэж буй зарим арга хэмжээг (жишээлбэл, торгууль, албадан гүйцэтгэл гэх мэт) лавлагаа болгон ашиглаж болох боловч Монгол Улсын хүний эрхийн үзэл баримтлал, нийгэм-соёлын орчинд нийцүүлэн тохируулга хийх, нийгмийн зээлийн хатуу хориг, өргөн цар хүрээтэй “хар жагсаалт” зэрэг механизмыг шууд хуулбарлан нэвтрүүлэхээс зайлсхийх нь зүйтэй. Үүнтэй зэрэгцээд, уулзалтын эрхтэй холбоотой зөрчил үүссэн тохиолдолд сэтгэлзүйн зөвлөгөө, гэр бүлийн зуучлал, нийгмийн ажлын дэмжлэгийг заавал хослуулан хэрэгжүүлснээр “зөвхөн шийтгэх” хандлагаас ангид байж, хүүхдийн эрх ашгийн үүднээс урт хугацаанд эвлэрэл, хамтын эцэг, эхийн харилцааг дэмжих боломжийг бүрдүүлэх ёстой.

4.2.1.2 Шүүхийн практик, байгууллагын шинэчлэл

(1) Хүүхдийн санал бодлыг тусгах мэргэшсэн журам

Шүүхийн дотоод журам, эрх зүйн актаар:

- Тодорхой наснаас дээш (жишээлбэл, 8–10 наснаас) хүүхдээс уулзалтын тухай санал бодлыг мэргэжлийн ярилцлагын протоколын дагуу сонсох;
- Ярилцлагыг шүүгч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч хамтарсан баг хийж, хүүхдийн мэдээллийг зөвхөн тухайн хэрэгт ашиглах;
- Хүүхдийн санал бодлыг эцэг, эхийн нөлөөлөл, айдас, сэтгэлзүйн дарамтыг

харгалзан, мэргэжлийн үнэлгээгээр тайлбарлах журам тогтоох.

(2) Шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлал, гэр бүлийн зөвлөгөө

Шүүх дээр:

- Уулзалтын эрхийн маргаанд зориулсан эвлэрүүлэн зуучлалын нэгж байгуулж, мэргэшсэн зуучлагч, нийгмийн ажилтныг татан оролцуулах;
- Гэр бүлийн маргааны эхний шатанд уулзалтын журам, хамтын эцэг, эхийн талаар сургалт, зөвлөгөө өгдөг богино хөтөлбөр (workshop) явуулах;
- Эвлэрүүлэн зуучлалаар батлагдсан уулзалтын тохиролцоог шүүхийн шийдвэрийн нэг хэсэг болгон баталгаажуулах тогтолцоо бий болгох.

4.2.1.3 Нийгмийн дэмжлэг, олон талт оролцооны бодлогын чиглэл

(1) Нийгмийн үйлчилгээ, сэтгэлзүйн дэмжлэгийг өргөжүүлэх

- Томоохон хот, аймгийн төвүүдэд гэр бүл, хүүхдийн үйлчилгээний төв ажиллуулж, маргаантай гэр бүлд сэтгэлзүйн зөвлөгөө, эцэг, эхийн боловсрол, уулзалтын үед хүүхдэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ санал болгох;
- Орон нутагт сум, багийн түвшинд нийгмийн ажилтныг уулзалтын эрхийн хэрэгжилтийн хяналт, дэмжлэгийн гүүр болгон чадавхжуулах.

(2) Олон нийтийн ойлголт, хандлагыг өөрчлөх

- Хэвлэл мэдээлэл, сургуулийн сургалтын хөтөлбөр, нийгмийн кампанит ажлаар дамжуулан дараа ч хамтын эцэг, эх, хүүхдийн уулзалтын эрхийн ач холбогдлыг танилцуулах;
- Хүүхдийг эцэг, эхийн зөрчилдөөний хэрэгсэл болгохгүй байх, “уулзалт”-ыг өш хонзон, шийтгэл биш, хүүхдийн эрхийн нэг хэсэг гэдгийг онцолсон мэдээлэл, сургалтыг тогтмол явуулах.

(3) Салбар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх

- Шүүх, прокурор, хүүхэд хамгааллын байгууллага, сургууль, эрүүл мэндийн байгууллага, орон нутгийн захиргааны хооронд уулзалтын эрхийн хэрэгжилтийн талаар мэдээлэл солилцох, хамтарсан ажиллах протокол боловсруулах;
- Уулзалтын эрхийн хэргийн талаар жилийн тайлан, дүн шинжилгээ гаргаж, асуудлыг бодлогын түвшинд тогтмол хэлэлцдэг болгох.

Ийнхүү 4.2-д дэвшүүлсэн эрх зүйн болон институтийн шинэчлэлийн санал нь Монгол Улсад уулзалтын эрхийн тогтолцоог “зарчим төвтэй, гүйцэтгэл сул” төлөвөөс “эрх тодорхой(X_1), гүйцэтгэл дэмжигдсэн(X_2), хүүхдийн эрхэд ээлтэй(Y_1)” чиглэл рүү шилжүүлэхэд чиглэнэ.

4.2.2 Хятад улсын туршлагыг Монголд нутагшуулах боломж, хязгаар

4.2.2.1 Нутагшуулах боломжтой чиглэл

Монгол Улс болон Хятад Улс харьцуулалтаас үзэхэд, Хятадын уулзалтын эрхийн тогтолцоонд Монгол Улсд сонгон авч, нутагшуулах боломжтой хэд хэдэн агуулга байна. Юуны өмнө, хууль зүйн зохицуулалтын тодорхой байдлыг нэмэгдүүлэх боломжтой. Хятад Улсын «Иргэний хууль»-д уулзалтын эрхийг бие даасан эрх зүйн институц

хэлбэрээр тодорхой заасан туршлагыг авч үзэн, Монгол Улсын «Гэр бүлийн тухай» хуульд уулзалтын эрхийн дараах үндсэн элементүүдийг тусгай зүйл, бүлэг болгон тодорхой тусгах хувилбар нээлттэй байна. Үүнд: 1. Уулзалтын эрхийн тодорхойлолт; 2. Эрхийн агуулга (нүүр тулсан уулзалт, холбоо харилцааг хадгалах, мэдээлэл авах гэх мэт); 3. Хязгаарлах, түр зогсоох, сэргээх нөхцөл; 4. Уулзалтын журмыг тогтоолгох, өөрчлүүлэхээр шүүхэд хандах зам, журам зэрэг орно. Мөн гүйцэтгэлийг дэмжих үе шаттай, аажим арга хэмжээг нэвтрүүлэх боломжтой. Зээлийн мэдээлэлд үндэслэсэн хатуу хориг зэрэг Хятадын албадлагын зарим хэлбэрийг заавал шууд хуулбарлах шаардлагагүй ч, уулзалтын тухай шүүхийн шийдвэрийг удаа дараа биелүүлээгүй тохиолдолд шат дараатай зөөлөн арга хэмжээ авах боломж бий. Жишээлбэл, албан бичгээр анхааруулга өгөх, бага хэмжээний торгууль ногдуулах; хэрэв гүйцэтгэлийн байдал сайжрахгүй хэвээр байвал шүүхээс тухайн хэргийн гүйцэтгэлд тавих хяналтаа чангатгах, нийгмийн ажилтны оролцоо, дэмжлэгийг нэмэгдүүлэх зэргээр “зөөлөн, шаталсан” гүйцэтгэлийн дэмжих механизмыг бүрдүүлж болох юм.

4.2.2.2 Эрсдэл, хязгаар, болгоомжлох шаардлагатай талууд

Хятад улсын «Иргэний хууль»-д туссан нарийвчилсан зохицуулалтыг богино хугацаанд бүхэлд нь Монгол Улсад шууд нэвтрүүлбэл, дотоодын эрх зүйн тогтолцоог хэт төвөгтэй болгож болзошгүй. Мөн хууль хэрэглэгчид болох иргэн, өмгөөлөгч, шүүгч, шийдвэр гүйцэтгэгчдийн хувьд ойлгож хэрэглэх босгыг мэдэгдэхүйц өндөрсгөх, цаашлаад мэргэшсэн хүний нөөц, төсвийн бодит чадавхаас давсан “цаасан шинэчлэл” бий болгох эрсдэл дагуулна.

Хятад улсад хэрэглэж буй зарим арга хэмжээ (жишээ нь, “найдаргүй этгээдийн жагсаалт”, нийгмийн зээлийн хязгаарлалт зэрэг) нь Монгол Улсын нийгэм-соёлын орчинд хүний эрх, хувийн нууц, нэр төр, алдар хүндийг хамгаалахтай холбоотой хууль зүйн маргаан өдөөх, олон нийтийн зүгээс “төрийн хэт хяналт”, “зээлийн дарамт” гэж хүлээн авах, түүнчлэн гэр бүл салалтын маргаанд оролцож буй эцэг, эхийн хоорондын зөрчлийг улам гүнзгийрүүлж, хүүхдийг тухайн сөргөлдөөний гол төвд оруулах магадлалтай.

“Хүүхдийн эрхийг хамгаална” гэсэн нэрийн дор албадлагын арга хэмжээг хэтрүүлэн хэрэглэх эрсдлийг үл тоомсорлож болохгүй. Хятадын туршлагыг авахдаа албадлагын арга хэмжээг зөвхөн “хууль хэрэгжүүлэх” үүднээс бус, хүүхдийн сэтгэлзүйн байдал, эцэг, эхийн харилцаанд урт хугацаанд үзүүлэх нөлөөтэй нь уялдуулан авч үзэх ёстой. Монгол Улсын нөхцөлд хэт хатуу, ширүүн албадлагын арга нэвтрүүлэх нь хүүхдийн эрхийг бодитоор хамгаалахаас илүүтэйгээр тэдний сэтгэлзүйн дарамтыг нэмэгдүүлж, шинэ төрлийн хохирол учруулах аюултай.

4.2.2.3 Эрх зүйг нутагшуулах аргачлал:

Дээрх эрсдэл, хязгаарлалтыг харгалзан Монгол Улсад Хятад улсын туршлагыг нутагшуулахдаа дараах зүйлсийг анхаарах нь зүйтэй.

(1) Сонгон нутагшуулалт

Хятад улсын туршлагыг бүхэлд нь хуулбарлах бус, Монгол Улсын нөхцөлд хэрэгжих онцгой ач холбогдолтой, зардал багатай, үр дүн өндөр элементүүдийг сонгон нэвтрүүлэх. Жишээлбэл:

- Шүүхийн өмнөх гэр бүлийн зөвлөгөө, сургалт;
- Уулзалтын үе шаттай гүйцэтгэлийн загвар;
- Хүүхдийн санал бодлыг тусгах мэргэжлийн ярилцлагын протокол гэх мэт.

(2) Өөрчилсөн, Монгол улсын онцлогт илүү тохирох арга замаар нутагшуулалт

Хятад улсын туршлагаас авах зарим элемент (жишээлбэл, шийдвэр гүйцэтгэлийн албадлагын арга, гэр бүлийн үйлчилгээний төвийн загвар)-ыг Монгол Улсын Улсын нүүдэлчин уламжлал, орон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүтэц, ахмадын зөвлөл, олон нийтийн эвлэрүүлэн зуучлал зэрэг уламжлалт зохицуулалтын хэлбэртэй уялдуулж, өөрчлөн нутагшуулах.

Өөрөөр хэлбэл, Хятад улсын туршлага Монгол Улсын уулзалтын эрхийн тогтолцооны шинэчлэлд “бэлэн хуулбар загвар” бус, харин сургамж, санаа, лавлагааны сан байх ёстой. Нутагшуулалтын зорилго нь “Хятад улсын тогтолцоотой ижил болох” бус, харин Монгол Улсын нийгэм-соёл, институтын нөхцөлд нийцсэн, хүүхдийн эрхийг илүү сайн хамгаалах өөрийн загвар бүтээхэд чиглэнэ.

4.2.3 Бүс нутгийн шүүхийн хамтын ажиллагааны механизм

4.2.3.1 Хил дамнасан гэр бүлийн маргаанд хамтран ажиллах хэрэгцээ

Монгол Улс, Хятад Улс хооронд хөдөлмөрийн шилжилт, хил дамнасан гэр бүл, хоёр улсын харьяаттай хүүхдийн тоо нэмэгдэхийн хэрээр маргаан, асран хамгаалалт, уулзалтын эрхтэй холбоотой хил дамнасан гэр бүлийн маргаан гарах боломж нэмэгдэж байна. Нэг улсын нутаг дэвсгэрт амьдарч буй хүүхдийн нөгөө улсад байгаа эцэг, эхтэй уулзах эрх, шүүхийн шийдвэрийг нөгөө улсад хүндэтгүүлж, хэрэгжүүлэх асуудал нь дан ганц дотоод эрх зүйн төдийгүй хоёр улсын шүүхийн хамтын ажиллагааны асуудал болж байна.

Ийм нөхцөлд Монгол Улс ба Хятад Улсын хооронд “*шүүхийн шийдвэрийг харилцан хүлээн зөвшөөрөх, гүйцэтгэх, хүүхдийн асран хамгаалалт, уулзалтын эрхтэй холбоотой мэдээлэл солилцох, хүүхэд хамгааллын хэрэгт хил дамнасан эрх зүйн туслалцаа үзүүлэх, хэрэгцээ*” бодитойгоор үүсэж байгаа бөгөөд энэ нь бүс нутгийн шүүхийн хамтын ажиллагааны тусгай сэдэв болох шаардлагатай.

4.2.3.2 Шүүхийн харилцан туслалцаа, шийдвэр хүлээн зөвшөөрөх механизм

Одоогийн байдлаар Монгол Улс, Хятад Улс хооронд иргэний болон эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх тодорхой гэрээ, хэлэлцээрүүд байгаа ч гэр бүлийн хэрэг, хүүхдийн эрхийн маргаанд чиглэсэн тусгай зохицуулалт хязгаарлагдмал байна. Цаашид:

- Хоёр улсын хооронд иргэний болон гэр бүлийн хэргийн талаар эрх зүйн туслалцааны нэмэлт хэлэлцээр байгуулах;
- Маргаан, асран хамгаалалт, уулзалтын эрхийн талаар гаргасан шүүхийн шийдвэрийг тодорхой нөхцөл дор харилцан хүлээн зөвшөөрөх, гүйцэтгэх механизмыг нарийвчлан тогтоох;
- Хүүхдийн эрхийг хамгаалах, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар мэдээлэл, сайн туршлага солилцох тогтолцоог хөгжүүлэх шаардлагатай.

4.2.3.3 Сургалт, туршлага солилцоо, хамтарсан судалгаа

Бүс нутгийн шүүхийн хамтын ажиллагааг зөвхөн эрх зүйн баримт бичгээр хязгаарлалгүй, сургалт, судалгаа, мэргэжлийн сүлжээгээр дамжуулан гүнзгийрүүлэх боломжтой. Үүнд:

- Монгол Улс ба Хятад Улсын шүүх, хууль сахиулах байгууллага, хүүхэд хамгааллын байгууллагын хооронд хамтарсан сургалт, семинар, туршлага солилцох уулзалт тогтмол зохион байгуулах;
- Гэр бүлийн хэрэг, уулзалтын эрхийн талаар маргаан-суурьтай сургалт (case-study), хамтарсан гарын авлага, протокол боловсруулах;
- Их дээд сургууль, судалгааны байгууллагуудын түвшинд Монгол Улс ба Хятад Улсын гэр бүлийн эрх зүй, хүүхдийн эрхийн талаар хамтарсан судалгаа, оюутан, судлаач солилцох хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Бүс нутгийн хэмжээнд (жишээлбэл, Төв Азийн, Зүүн Азийн хүрээнд) хүүхдийн эрх, гэр бүлийн маргааныг шийдвэрлэхэд чиглэсэн олон талт хамтарсан сүлжээ, форум байгуулах.

Ийнхүү Монгол Улс ба Хятад Улсын уулзалтын эрхийн тогтолцоо, гэр бүлийн эрх зүйн практикийн харьцуулсан судалгаа нь зөвхөн Монгол Улсын дотоод шинэчлэлд төдийгүй, бүс нутгийн шүүхийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, хил дамнасан гэр бүлийн маргааныг хүүхдийн эрхэд ээлтэйгээр шийдвэрлэх суурь баримт материал болж чадна.

4.2.4 Урт хугацааны хөгжлийн чиглэл

4.2.4.1 Эрх зүйн тогтолцооны тасралтгүй сайжруулалт

Уулзалтын эрхийн эрх зүйн шинэчлэл нь нэг удаагийн хууль өөрчлөх үйл явц бус, тасралтгүй хөгжиж байх ёстой ажиллагаа юм. Үүний тулд:

1. Үр нөлөөний үнэлгээний тогтолцоо бий болгох
 - “Гэр бүлийн тухай” хууль болон уулзалтын эрхтэй холбоотой зохицуулалтын хэрэгжилтэд тогтмол үнэлгээ, мониторинг хийх;
 - Шүүхийн шийдвэр, шийдвэр гүйцэтгэлийн статистик, хүүхдийн эрхийн байдал, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг хослуулсан индикаторын багц боловсруулах;
 - Үр нөлөөний үнэлгээний дүнг хууль тогтоомж шинэчлэх, бодлого боловсруулах үед системтэй ашиглах.
2. Олон улсын стандарттай уялдуулах
 - “Хүүхдийн эрхийн тухай конвенц” болон тухайн конвенцын хэрэгжилтийн талаар НҮБ-ын хорооноос өгсөн зөвлөмжийг тогтмол харгалзан, уулзалтын эрхийн зохицуулалтыг олон улсын стандартад ойртуулах;
 - Олон улсын түвшний сайн туршлагыг (Европын зарим улс, бүс нутгийн жишээ) харьцуулсан судалгаагаар дамжуулан авч үзэж, Монгол Улсын нөхцөлд тохируулан ашиглах.
3. Хуулийн шинэчлэлийг үе шаттай, оролцоонд тулгуурлан хийх
 - Хууль шинэчлэхэд зөвхөн эрх зүйн мэргэжилтэн бус, шүүгч, өмгөөлөгч,

нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, ТББ, эцэг, эх, хүүхдийн төлөөлөл оролцсон өргөн хүрээтэй хэлэлцүүлэг зохион байгуулах;

- Шинэчлэлийг туршилтын төслөөр эхлүүлж (жишээлбэл, тодорхой шүүх, аймагт), үр дүнг нь үнэлсний дараа улс даяар хэрэгжүүлэх.

4.2.4.2 Хүний нөөц, мэргэшлийн урт хугацааны бодлого

Уулзалтын эрхийн хамгаалалт, шийдвэр гүйцэтгэл, нийгмийн дэмжлэгийн чанар нь мэргэшсэн хүний нөөцөөс шууд хамаарна. Иймээс:

1. Шүүгч, өмгөөлөгч, шийдвэр гүйцэтгэгчийн сургалт

- Гэр бүлийн хэрэг, хүүхдийн эрхийн чиглэлээр тусгай сургалтын хөтөлбөр боловсруулж, шүүхийн шинэ ажилтнуудыг тогтмол сургах;
- Одоогийн шүүгч, өмгөөлөгчдөд уулзалтын эрхийн онол, олон улсын стандарт, сэтгэлзүй, харилцааны ур чадвар хослуулсан тасралтгүй сургалт зохион байгуулах.

2. Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, зуучлагчийг бэлтгэх

- Их, дээд сургуулиудад гэр бүл, хүүхэд хамгааллын чиглэлээр мэргэшсэн хөтөлбөр, уулзалтын эрхийн хэрэгжилтэд оролцох зориулалттай сургалт нэвтрүүлэх;
- Нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийг шүүхийн хэрэг, шийдвэр гүйцэтгэлд тогтмол оролцуулахын тулд тусгай мэргэшлийн гэрчилгээ, стандарт тогтоох.

3. Орон нутагт чадавх бүрдүүлэх

- Аймаг, сумын түвшинд хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан, зөвлөх нарыг тогтмол сургах, сэлбэх бодлого баримтлах;
- Хөдөөгийн нөхцөлд тохирсон, зардал бага, үр дүнтэй арга (холимог сургалт, цахим зөвлөгөө, бүсчилсэн баг)-ыг хөгжүүлэх.

4.2.4.3 Нийгмийн оролцоо, соёлын өөрчлөлтийн урт хугацааны зорилт

Эцэст нь уулзалтын эрхийн тогтолцоог тогтвортой болгохын тулд хууль зүйн шинэчлэлээс гадна нийгмийн соёл, хандлагын өөрчлөлт зайлшгүй шаардлагатай.

1. Хүүхдийн эрхийн соёлыг төлөвшүүлэх

- Сургуулийн боловсролын хөтөлбөрт хүүхдийн эрх, гэр бүлийн харилцаа, зөрчлийг үл хүчирхийллийн аргаар шийдвэрлэх гэх мэт агуулгыг тогтвортой оруулах;
- Хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр “ дараах хамтын эцэг, эх”, “хүүхдийн уулзалтын эрх”-ийг эерэг жишээ, бодит түүхээр дамжуулан сурталчлах.

2. Иргэний нийгмийн оролцоог дэмжих

- Хүүхдийн эрх, гэр бүлийн асуудлаар ажилладаг ТББ, мэргэжлийн холбоодыг уулзалтын эрхийн бодлогын хэлэлцүүлэг, сургалт, судалгаа, үйлчилгээнд оролцуулах;
- Төр-ТББ-сургуулийн гурвалсан хамтын ажиллагаагаар аймаг, сум бүрт сургалт, зөвлөгөө, мэдээллийн өдөр зохион байгуулж, үеийн хүүхэд хамгааллын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх.

3. Эерэг жишээ, дүр төрхийг бий болгох

- Хамтран хүүхэд өсгөж буй, дараа ч хүүхдийн эрхийг хамтдаа хамгаалж чадсан эцэг, эхийн амжилттай жишээг олон нийтэд хүргэх;
- Хүүхдийн уулзалтын эрхийг хүндэтгэсэн, хамтын эцэг, эхийг дэмжсэн хандлагыг нийгмийн “шинэ хэвийн байдал” болгож төлөвшүүлэх зорилго тавих.

Ингэж хууль зүйн, институтийн, хүний нөөцийн болон соёлын түвшинд урт хугацааны зорилт, алхмуудыг уялдуулан хэрэгжүүлснээр Монгол Улсад хүүхдийн уулзалтын эрхийг хамгаалах тогтолцоо тогтвортой, үр нөлөөтэй, хүүхдэд ээлтэй чиглэл рүү аажим боловч бодитой шилжих нөхцөл бүрдэнэ.

ДҮГНЭЛТ

Энэхүү магистрын судалгааны ажлын хүрээнд Монгол Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын гэр бүлийн эрх зүйн тогтолцоо дахь гэрлэлт цуцалсны дараах хүүхэдтэй уулзах эрхийн зохицуулалтыг харьцуулан шинжиллээ. Үүний үр дүнд Монгол Улсад тулгарч буй эрх зүй болон институцийн тулгамдсан асуудлуудыг тодорхойлж, БНХАУ-ын дэвшилтэт туршлагыг өөрийн орны хөрсөнд нутагшуулах боломж, хязгаарлалтыг онол-практикийн түвшинд үнэлэн, холбогдох бодлогын саналуудыг боловсруулав.

Судалгааны ажлын үр дүнг нэгтгэн дүгнэж, өөрийн үнэлгээг хийхэд: Ажлын эхэнд дэвшүүлсэн онол-практикийн сорилтуудыг харьцуулсан эрх зүй болон эмпирик моделийн хүрээнд бүрэн оношилж, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх бодлогын гарцыг БНХАУ-ын туршлагад суурилсан "сонгомол нутагшуулалтын загвар"-аар тодорхойлж чадсан тул энэхүү судалгааны ажил нь урьдчилан дэвшүүлсэн үндсэн зорилго, зорилтууд болон хүлээгдэж байсан судалгааны үр дүндээ БҮРЭН ХҮРСЭН хэмээн үнэлж байна. Судалгааны үндсэн үр дүнд тулгуурлан дараах нэгдсэн дүгнэлтүүдийг дэвшүүлж байна. Үүнд:

Нэг. Монгол Улсын “Гэр бүлийн тухай хууль” болон холбогдох эрх зүйн актуудад хүүхэдтэй уулзах эрхийн ойлголтыг зарчмын хувьд хүлээн зөвшөөрсөн боловч уг эрхийн тодорхой агуулга, хэрэгжүүлэх нарийвчилсан журам, хязгаарлах болон сэргээх механизмын системтэй зохицуулалт дутагдалтай байгаа нь судалгааны загварын "Хууль эрх зүйн зохицуулалтын нарийвчлал" (X_1) хувьсагч хангалтгүй байгааг харуулж байна. Бодит байдалд өнөөгийн мөрдөгдөж буй эрх зүйн хэм хэмжээний хүрээнд дараах тулгамдсан асуудлууд байна гэж дүгнэж байна. Үүнд:

- **Онолын тодорхойгүй байдал:** Уулзах эрх нь хүүхдийн бие даасан эрх үү, эсхүл тусдаа амьдарч буй эцэг, эхийн эрх үү гэдэг нь хууль зүйн онол болон хууль тогтоомжийн түвшинд тодорхой бус байна;
- **Жишиг стандарт дутмаг байдал:** Уулзалтын хэлбэр, давтамж, хугацаа болон баяр ёслолын өдрүүдэд баримтлах хуваарийн жишиг стандарт байхгүйгээс шүүхийн шийдвэрт “харилцан тохиролцох”, “саад учруулахгүй байх” гэх мэт практикт хэрэгжих боломжгүй, хэт ерөнхий, бүрхэг томъёолол давамгайлж байна;
- **Суурь зарчмын уялдаа сул байдал:** Уулзах эрхийг хязгаарлах, зогсоох, эсхүл сэргээх үндэслэл, шалгуур нь “хүүхдийн дээд ашиг сонирхлыг тэргүүн ээлжинд хамгаалах” зарчимтай практик түвшинд нарийн уялдаагүй байна;
- **Шийдвэр гүйцэтгэлийн механизмын сул тал:** Судалгааны загварын "Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албадлага, дэмжлэгийн механизм" (X_2) сул байгаагаас шалтгаалан шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатанд хүүхэдтэй уулзах эрхийг албадан гүйцэтгүүлэх тусгайлсан журам, шаталсан хариуцлагын тогтолцоо байхгүйгээс шүүхийн шийдвэрүүд амьдрал дээр хэрэгжихгүй "цаасан дээрх тунхаг" болон үлдэж, улмаар "Уулзалтын эрхийн бодит хэрэгжилт" (Y_2) буурахад хүрч байна.

Хоёр. Хятад Ард Улсын "Иргэний хууль", “Дээд шүүхийн шүүхийн тайлбар” болон гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шинжлэхэд, тус улс хүүхэдтэй уулзах

эрхийг бие даасан эрх зүйн институт болгон нарийвчлан хуульчилсан нь Монгол улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулахад дараах томоохон давуу талуудыг бий болгож байна. Үүнд:

- **Зохицуулалтын нарийвчилсан байдал:** Уулзах эрхийн тодорхойлолт, агуулгыг хуульчлан зааж, уулзалтын журмыг тогтоох, өөрчлөх, хязгаарлах болон сэргээх ажиллагааны үндсэн зарчим, процедурыг тодорхой болгосон;
- **Үзэл баримтлалын нэгдэл:** Шүүхийн шийдвэрт “хүүхдийн дээд ашиг сонирхлыг тэргүүн ээлжинд хамгаалах” болон “эцэг, эхийн хамтын хариуцлага”-ыг хангах үзэл баримтлалыг системтэйгээр хэрэгжүүлж байна;
- **Институцийн харилцан уялдаа:** Гэр бүлийн төрөлжсөн шүүх, эвлэрүүлэн зуучлах механизм болон нийгмийн үйлчилгээний тогтолцоог хооронд нь уялдуулан институцийн дэвшилтэт бүтцийг бий болгосон;
- **Шийдвэр гүйцэтгэлийн уян хатан байдал:** Шийдвэр гүйцэтгэлийн шатанд урьдчилан сануулах, торгууль ногдуулах, "найдваргүй гүйцэтгэгчийн жагсаалт"-д бүртгэх зэрэг зөөлөн болон хатуу албадлагыг хослуулан хэрэглэж буй нь Монгол Улсын практикт жишиг болохуйц туршлага юм.

Гурав: Монгол Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын уулзалтын эрхийн тогтолцоог харьцуулан шинжлэхэд практик дахь ижил төстэй сорилтууд болон зарчмын ялгаатай талууд тогтоогдов. * Хоёр улсын эрх зүйн практикт тулгарч буй нийтлэг сорилтууд: Уулзах эрхийг хууль зүйн түвшинд хүлээн зөвшөөрсөн боловч бодит амьдрал дээрх хэрэгжилт хангалтгүй; хүүхэдтэй хамт амьдарч буй тал өөрийн хяналтад байгаа давуу байдлаа ашиглан нөгөө талын уулзах эрхэд санаатай болон санамсаргүйгээр саад учруулах хандлага түгээмэл; маргааныг шийдвэрлэх явцад хүүхдийн санал бодлыг сэтгэл зүйн оношилгоо, нийгмийн судалгааны үндсэн дээр мэргэжлийн түвшинд үнэлэх механизм сул; шүүхийн шийдвэр гүйцэтгэх явцад болон гэр бүлийн харилцаанд дэмжлэг үзүүлэх нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эвлэрүүлэн зуучлагч нарын тоо хангалтгүй, чадавх сул байна.

- Зарчмын ялгаатай талууд: Монгол Улсын эрх зүйн зохицуулалт нь илүү ерөнхий, тунхаглалын шинжтэй бөгөөд хэргийг шийдвэрлэхэд шүүгчийн үзэмж өндөр, бодит албадлагын механизм дутмаг байхад; БНХАУ-ын эрх зүйн зохицуулалт нь маш нарийвчилсан, институцийн бүтэц харьцангуй бэхэжсэн төдийгүй шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх арга хэрэгсэл нь олон талт, үр нөлөөтэй байна.

Дөрөв. Эрх зүйн рецепци болон нутагшуулалтын онолд тулгуурлан БНХАУ-ын хүүхэдтэй уулзах эрхийн тогтолцоог Монгол Улсад нэвтрүүлэх боломжийг онол-практикийн хувьд үнэллээ. Үүний үр дүнд уулзах эрхийг бие даасан институт болгон хуульчлах, уулзалтын агуулга, хэлбэр, давтамжийн жишиг стандартыг тогтоох, мэргэшсэн зуучлал ба сэтгэл зүйн үйлчилгээг шүүхийн ажиллагаанд нэвтрүүлэх, түүнчлэн шаталсан зөөлөн албадлагын системийг бий болгох нь Монгол Улсын эрх зүйн хөрсөнд хэрэгжих бүрэн боломжтой гэж үзэв. Харин БНХАУ-ын нийгмийн зээлийн системд суурилсан хатуу шийтгэл, хувийн нууц болон хүний эрхтэй зөрчилдөхүйц хэт хяналтын загвар, мөн Монгол Улсын одоогийн төсөв, хүний нөөцийн боломжоос давсан нүсэр бүтцийг шууд хуулбарлан нэвтрүүлэхээс татгалзах нь зүйтэй байна. Иймээс хоёр улсын соёлын ижил төстэй тал болон эрх зүйн уламжлалыг харгалзан, БНХАУ-ын

дэвшилтэт туршлагыг сонголттой бөгөөд Монгол Улсын нөхцөл байдалд дасан зохицуулж, өөрчлөлттэйгөөр нутагшуулах нь хамгийн оновчтой шийдэл юм.

Тав. Судалгааны үр дүнд үндэслэн Монгол Улсад хүүхэдтэй уулзах эрхийн хамгаалалтыг сайжруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгохын тулд дараах үндсэн чиглэлүүдээр шинэчлэл хийхийг санал болгож байна. Нэгдүгээрт, Гэр бүлийн тухай хуульд уулзах эрхийн тодорхойлолт, процедур, хязгаарлах болон сэргээх нөхцөлийг бие даасан бүлэг, заалтаар тусгайлан хуульчлах шаардлагатай байна. Хоёрдугаарт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль тогтоомжид хүүхэдтэй уулзах эрхийг хэрэгжүүлэхэд зориулсан тусгай журам, шаталсан хариуцлагын механизм буюу урьдчилан сануулах, торгууль ногдуулах, эвлэрүүлэн зуучлалд албадан хамруулах зэрэг зохицуулалтыг бүрдүүлэх нь зүйтэй. Гуравдугаарт, шийдвэр гаргах ажиллагаанд хүүхдийн санал бодлыг сонсох, мэргэжлийн сэтгэл зүйн үнэлгээ хийх стандарт ажиллагааны журмыг нэвтрүүлэх хэрэгтэй байна. Түүнчлэн, шүүхийн дэргэд гэр бүлийн зуучлал, үйлчилгээний төрөлжсөн нэгж байгуулж, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийн оролцоог хангахын зэрэгцээ холбогдох салбар хоорондын хамтын ажиллагааны нэгдсэн сүлжээг бэхжүүлэх нь тулгамдсан асуудал болоод байна.

Эцэст нь дүгнэхэд, энэхүү судалгааны ажил нь Монгол Улсын гэрлэлт цуцлах маргаан дахь хүүхэдтэй уулзах эрхийн асуудлыг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын эрх зүйн тогтолцоотой харьцуулан шинжилж, тулгамдсан асуудлыг оношлон тогтоосон цогц судалгаа боллоо. Цаашид энэхүү чиглэлийг илүү өргөн хүрээний практик жишээ, онолын судалгаагаар баяжуулан хөгжүүлэх нь Монгол Улсын гэр бүлийн эрх зүйн шинэчлэлд болон бүс нутгийн харьцуулсан эрх зүйн ухааны салбарт чухал ач холбогдолтой юм.

САНАЛ ЗӨВЛӨМЖ

Энэхүү судалгааны ажлын үр дүнд тулгуурлан Монгол Улсад гэрлэлт цуцалсны дараах хүүхэдтэй уулзах эрхийг бодитоор хамгаалах, хэрэгжилтийн үр нөлөөг сайжруулах зорилгоор холбогдох байгууллага, мэргэжилтнүүдэд хандан дараах системтэй санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга зам болон анхаарах асуудлын удирдамжийн хамт дэвшүүлж байна.

I. Хууль тогтоомжийн түвшинд

1. Эрхийг шинээр томъёолж, хуульд тусгай бүлэг болгон оруулах

- **Хэрхэн хэрэгжүүлэх арга зам:** УИХ болон Хууль зүй, дотоод хэргийн яамнаас "Гэр бүлийн тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгын төсөлд "Уулзалтын эрх" гэсэн тусгай зүйл эсхүл дэд бүлэг шинээр оруулна. Уг эрхийг хүүхдийн харилцаагаа хадгалах суурь эрх болон тусдаа амьдарч буй эцэг эхийн үүрэг гэж тодорхойлно. Үүнд биечлэн уулзах, цахим хэлбэрээр харилцах, хүүхдийн сургууль, эрүүл мэндийн мэдээллийг авах эрхийг нарийвчлан жагсаана. "Хүүхдийн дээд ашиг сонирхол"-ыг шүүх заавал баримтлах суурь зарчим болгон хуульчилна.
- **Анхаарах асуудал:** Хуулийн заалтыг хэт ерөнхий тунхаглалын шинжтэй томъёолохоос зайлсхийх хэрэгтэй. Эрх зүйн хэм хэмжээ бүр нь процедурын хувьд шүүгч хэрэглэхэд тодорхой, маргаангүй байх шаардлагатай.

2. Уулзалтын хэлбэр, давтамжийн жишиг стандартыг хууль болон дэд журамд боловсруулах

- **Хэрхэн хэрэгжүүлэх арга зам:** Хуулийг дагалдуулан шүүхийн практикт ашиглах "уулзалтын жишиг хуваарь" (Guideline)-ийн журмыг боловсруулна. Үүнд сургуулийн насны хүүхдийн хувьд сар бүрийн тодорхой амралтын өдрүүдэд уулзах, баяр ёслолын өдрүүдэд ээлжлэн уулзах, амралтын үеэр хамт амьдрах боломжоор хангах жишгийг тогтооно.
- **Анхаарах асуудал:** Эдгээр жишиг стандартыг хатуу заалт болгон тулгаж болохгүй. Хүүхдийн нас, эрүүл мэнд, газарзүйн байршил болон эцэг, эхийн бодит боломжид нийцүүлэн шүүх уян хатан хэрэглэх эрх мэдлийг шүүгчид үлдээх нь зүйтэй.

3. Хязгаарлах, түр зогсоох болон сэргээх нөхцөлийг нарийвчлах

- **Хэрхэн хэрэгжүүлэх арга зам:** "Гэр бүлийн тухай" хуульд уулзалтын эрхийг хязгаарлах боломжтой нөхцөлүүдийг (хүчирхийлэл, донтох эмгэг, эцэг эхээс хөндийрүүлэх хам шинж буюу нөгөө талын эсрэг дайсагнасан хандлага төлөвшүүлэх үйлдэл) тодорхой нэрлэн заана. Нөхцөл байдал сайжирвал гуравдагч этгээдийн хяналттай уулзалтаас эхлэн ердийн хуваарьт шилжих шаталсан механизмыг хуульчилна.
- **Анхаарах асуудал:** Уулзах эрхийг хязгаарлах нь эцэг эхийг "шийтгэх" хэрэгсэл биш бөгөөд зөвхөн "хүүхдийн аюулгүй байдлыг хангах" зорилготой тул шийдвэрийг сэтгэл зүйн оношилгоонд суурилж гаргахыг хуулийн заалтад заавал тусгах ёстой.

4. Шийдвэр гүйцэтгэлийн эрх зүйн механизм болон шаталсан хариуцлагыг тодорхой болгох

- **Хэрхэн хэрэгжүүлэх арга зам:** “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хуульд уулзалтын эрхийг хэрэгжүүлэх тусгай журам нэмж, хүүхэдтэй уулзах эрхийг "хөрөнгө хураах" ердийн гүйцэтгэлээс ангид, хүмүүнлэгийн процедур болгоно. Шийдвэрийг биелүүлээгүй талд: 1-р шатанд: Албан ёсны сануулга өгөх; 2-р шатанд: Торгууль ногдуулах; 3-р шатанд: Эвлэрүүлэн зуучлал эсхүл сэтгэл зүйн зөвлөгөөнд албадан хамруулах зэрэг зөөлөн албадлагын системийг хуульчилна.
- **Анхаарах асуудал:** БНХАУ-ын нийгмийн зээлийн системд суурилсан хэт хатуу шийтгэл (хар жагсаалтад бүртгэх гэх мэт)-ийг манай улсын эрх зүйн хөрсөнд шууд хуулбарлан нэвтрүүлэхээс зайлсхийх хэрэгтэй. Энэ нь хүний эрхийн зөрчил үүсгэх эрсдэлтэй.

II. Шүүхийн практик болон шийдвэр гүйцэтгэлийн түвшинд

1. Хүүхдийн санал бодлыг мэргэжлийн түвшинд тусгах журам хэрэгжүүлэх

- **Хэрхэн/хэрэгжүүлэх арга зам:** Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүхийн дотоод журам гаргаж, Стандарт ажиллагааны журам (SOP)-ыг тогтооно. Тодорхой наснаас (8–10-аас дээш) хүүхдийн санал бодлыг шүүгч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч оролцсон төвийг сахисан, аюулгүй орчинд, эцэг эхийн нөлөөллөөс ангид сонсож, ярилцлагын тэмдэглэлийг шийдвэр гаргах үндэслэл болгоно.
- **Анхаарах асуудал:** Хамт амьдарч буй талын зүгээс "хүүхэд өөрөө уулзахыг хүсэхгүй байна" гэх мэдэгдлийг дангаар нь нотлох баримт болгохыг хатуу хориглоно. Үүний цаана сэтгэлзүйн дарамт, нөлөөлөл байгаа эсэхийг мэргэжлийн сэтгэл зүйчийн дүгнэлтээр заавал баталгаажуулсны дараа шийдвэр гаргана.

2. Уулзалтын шийдвэрийн гүйцэтгэлийг үе шаттай, хүүхдэд ээлтэй байдлаар зохион байгуулах

- **Хэрхэн хэрэгжүүлэх арга зам:** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас уулзалтыг зохион байгуулахдаа эцэг эхийн гэр оронд биш, харин сургууль, хороо эсхүл "Гэр бүлийн үйлчилгээний төв"-ийн өрөө зэрэг төвийг сахисан, аюулгүй орчинд хүүхдийг шилжүүлэн өгөх зарчмыг баримтална.
- **Анхаарах асуудал:** Шийдвэр гүйцэтгэх явцад хүүхдийг хүч хэрэглэн авах, айлган сүрдүүлэх, эсхүл олон удаагийн байцаалт маягийн асуултаар дарамтлахыг гүйцэтгэлийн журамд тодорхой тусган хатуу хориглох хэрэгтэй.

III. Нийгмийн дэмжлэг болон үйлчилгээний түвшинд

1. Гэр бүл, хүүхдийн үйлчилгээний төвийг үе шаттайгаар бий болгох

- **Хэрхэн хэрэгжүүлэх арга зам:** Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас Улаанбаатар хотын дүүрэг, аймгийн төвүүдэд гэр бүлийн үйлчилгээний нэгжүүдийг байгуулж, гэр бүл цуцалсан эцэг эхчүүдэд зориулсан хууль зүйн зөвлөгөө, “салалтын дараах хамтын эцэг эх байх ур чадвар” (Co-parenting)-ын сургалтыг албадан хамруулах хэлбэрээр явуулна.
- **Анхаарах асуудал:** Төсвийн нэмэлт ачаалал үүсгэхгүйн тулд одоогийн ажиллаж буй Хүүхэд хамгааллын төвүүдийн материаллаг баазад түшиглэн, шүүхтэй мэдээлэл солилцох албан ёсны протоколыг стандартчилах замаар ажлыг эхлүүлнэ.

2. Мэргэжлийн боловсон хүчний оролцоог тогтолцоотой болгох

- **Хэрхэн хэрэгжүүлэх арга зам:** Суурь нэгжийн түвшинд хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтныг чиг үүрэгжүүлж, уулзалтын эрхийн хэрэгжилтэд хяналт тавих, шүүхэд тогтмол тайлагнах үүргийг хүлээлгэнэ. Шүүх, шийдвэр гүйцэтгэх байгууллага, сургууль, эмнэлгийн хооронд мэдээлэл солилцох нэгдсэн сүлжээг бэхжүүлнэ.
- **Анхаарах асуудал:** Салбар хоорондын уялдаа холбоо сул байгаагаас мэдээлэл дундаа гацах эрсдэлтэй тул байгууллага хоорондын хамтын ажиллагааны "Нэгдсэн цахим сан"-г ашиглах эрх зүйн үндсийг бүрдүүлэх шаардлагатай.

IV. Бодлого болон олон нийтийн хандлагын түвшинд

1. Хүүхдийн эрх болон хамтын эцэг эхийн соёлыг төлөвшүүлэх

- **Хэрхэн хэрэгжүүлэх арга зам:** Боловсролын яамнаас Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт гэр бүлийн харилцаа, хүүхдийн эрх болон эцэг эхийн хариуцлагын талаарх суурь ойлголтыг үе шаттай оруулна. Хэвлэл мэдээллээр дамжуулан уулзалтын эрх бол "өс хонзон" биш хүүхдийн өөрийнх нь эрх гэдгийг сурталчилна.
- **Анхаарах асуудал:** Нийгэмд тогтсон "хүүхэд зөвхөн ээжтэйгээ/аавтайгаа байх ёстой" гэсэн хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд урт хугацаа шаардагдах тул бодлогын нөлөөллийн ажлыг тогтмол, системтэй явуулах хэрэгтэй.

2. Мэргэжлийн оролцогчдын чадавхыг бэхжүүлэх

- **Хэрхэн хэрэгжүүлэх арга зам:** Шүүгч, өмгөөлөгч, шийдвэр гүйцэтгэгч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарт зориулсан гэр бүлийн хэрэг, хүүхдийн эрхийн нарийн мэргэшсэн сургалтыг тогтмолжуулна. Их, дээд сургуулиудад хүүхэдтэй уулзах эрхийн чиглэлээр эмпирик судалгаа хийхийг дэмжиж, төрийн бодлого боловсруулах үйл явцыг шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээллээр хангана.
- **Анхаарах асуудал:** Сургалтыг зөвхөн онолын түвшинд хийж болохгүй, бодит кэйс (тохиолдол) дээр ажиллах, БНХАУ-ын шүүхийн шилдэг практикийг судлах практик сургалтыг түлхүү зохион байгуулах удирдамжийг баримтална.

V. Бүс нутгийн шүүхийн хамтын ажиллагааны түвшинд (Монгол Улс болон БНХАУ-ын шүүхийн харилцан туслалцаа)

Хил дамнасан гэр бүлийн маргааны эрх зүйн туслалцааны гэрээг шинэчлэх

- **Хэрхэн хэрэгжүүлэх арга зам:** Монгол Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд хил дамнасан гэр бүлийн маргаан дахь асран хамгаалалт болон уулзах эрхийн шийдвэрийг харилцан хүлээн зөвшөөрөх, гүйцэтгэх тухай иргэний хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ, хэлэлцээрийг практик шаардлагад нийцүүлэн шинэчилнэ. Хоёр улсын шүүх, хүүхэд хамгааллын байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох, шилдэг туршлага хуваалцах хамтарсан сургалт, семинарын механизмыг тогтмолжуулна.
- **Анхаарах асуудал:** Олон улсын гэрээг шинэчлэхэд дипломат харилцаа болон хугацааны хүчин зүйл нөлөөлөх тул эхний ээлжинд хоёр улсын Хил орчмын

шүүхүүдийн түвшинд "Санамж бичиг" байгуулах замаар практик хамтын ажиллагааг эхлүүлэх нь оновчтой.

VI. Судалгааны үр дүнгийн хэрэглээ ба хүлээгдэж буй үр нөлөө

1. Хууль тогтоох байгууллагад:

- Санал болгосон "Уулзах эрхийг хязгаарлах болон сэргээх шаталсан механизм"-ыг Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд процедурын хэм хэмжээ болгон тусгаж, өнөөгийн эрх зүйн зохицуулалтын хоосон орон зайг нөхөхөд ашиглах боломжтой.

2. Шүүх засаглалд:

- Шүүгчид гэрлэлт цуцалсан маргааныг шийдвэрлэхдээ энэхүү судалгаагаар тогтоосон харьцуулсан үзүүлэлтүүд болон шалгууруудыг "хүүхдийн дээд ашиг сонирхлыг үнэлэх" стандарт аргачлал болгон ашигласнаар шүүгчийн субъектив үзэмжээр шийдвэр гаргах байдлыг үр дүнтэй хязгаарлана.

3. Шийдвэр гүйцэтгэх байгууллагад:

- БНХАУ-ын туршлагаас нутагшуулж, Монгол Улсын онцлогт тохируулан өөрчилсөн "Урьдчилан сануулах" болон "Төвийг сахисан орчинд хүлээлгэн өгөх" загварыг шийдвэр гүйцэтгэгч нарын өдөр тутмын үйл ажиллагааны зааварт нэвтрүүлснээр уулзах эрхийн гүйцэтгэлийн бодит үр нөлөө мэдэгдэхүйц дээшилнэ.

VII. Эрх нь зөрчигдсөн талуудын хүсэл сонирхлыг хангах нь

1. Хүүхдийн хүсэл сонирхол, сэтгэл зүйн хамгаалалт:

- Эмпирик судалгааны үр дүнгээс үзэхэд хүүхдүүд эцэг эхийнхээ хэн нэгнийг "ялагч" эсвэл "ялагдагч" болгохыг хүсдэггүй, харин аюулгүй, тайван орчинд хоёулантай нь гэр бүлийн харилцаатай байхыг эрмэлздэг. Тиймээс энэхүү судалгаанаас санал болгож буй "Гэр бүлийн үйлчилгээний төв"-ийн болон "дундаж орон зайн" загвар нь хүүхдийн сэтгэл зүйн дарамтыг арилгахад шууд чиглэсэн бөгөөд тэдний суурь ашиг сонирхлыг хангахад зориулагдсан болно.

2. Эцэг, эхийн хууль ёсны эрх ашгийг тэнцвэржүүлэх нь:

- Хүүхэдтэйгээ хамт амьдардаггүй эцэг, эхчүүдийн хамгийн том сорилт нь зөвхөн хэлбэр төдий уулзах бус, харилцаа тасрахаас сэргийлэх байдаг. Судалгаанд тусгасан "Хүүхдийн хөгжил, эрүүл мэндийн мэдээллийг авах эрхийг хуульчлах" санал нь тэдний хүүхдийнхээ амьдралд бодитой оролцох гэсэн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж байгаа бөгөөд энэ нь цаашид тэдний зүгээс хүүхдийн тэтгэлэг болон бусад үүргээ сайн дураараа биелүүлэх эерэг хөшүүрэг болно.

НОМ ЗҮЙ

Монгол хэлээрх

Монгол Улсын Үндсэн хууль. (1992). Төрийн мэдээлэл эмхэтгэл, №1.

Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль. (1999). Төрийн мэдээлэл эмхэтгэл, №37.

Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хууль. (2016). Төрийн мэдээлэл эмхэтгэл, №23.

Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. (2017). Төрийн мэдээлэл эмхэтгэл.

Гадаад хэлээрх

Archard, D., & Skivenes, M. (2009). Balancing a child's best interests and a child's views. *The International Journal of Children's Rights*, 17(1), 1–21.

Committee on the Rights of the Child. (2013). *General Comment No. 14 on the right of the child to have his or her best interests taken as a primary consideration (CRC/C/GC/14)*. United Nations.

United Nations. (1989). *Convention on the Rights of the Child*. United Nations.

中华人民共和国反家庭暴力法. (2015). 北京: 全国人民代表大会常务委员会.

中华人民共和国未成年人保护法. (2020 修订). 北京: 全国人民代表大会常务委员会.

中华人民共和国民法典: 婚姻家庭编. (2020). 北京: 中国法制出版社.

最高人民法院. (2020). 关于适用《中华人民共和国民法典》婚姻家庭编的解释(一). *最高人民法院公报*.

何兵. (2021). 民法典实施后家事审判的实践难题与对策. *人民法院报*, 2021年11月02日理论版.

刘俊海. (2021). 民法典视野下未成年人保护制度完善研究. *法学研究*, (2), 23–35.

吴莉. (2020). 监护权、抚养权与探望权的体系定位与冲突协调. *中外法学*, (3), 741–760.

孙国华. (2016). *婚姻家庭法*. 北京: 法律出版社.

张小虎. (2021). “失信被执行人制度”在探望权执行中的适用风险及规制. *法学评论*, (6), 142–153.

- 杨立新. (2021). *民法典婚姻家庭编释义与适用*. 北京: 中国法制出版社.
- 张文娟. (2022). 未成年人案件中心理评估意见在裁判中的运用——以探望权案件为中心. *法律科学*, (4).
- 戴安斌. (2022). 家事案件中“软性执行”机制的适用边界——以探望权执行为中心. *政治与法律*, (1).
- 朱芬. (2022). 家庭暴力背景下父母探望权的限制规则. *法律适用*, (8).
- 许身健. (2021). 互联网时代离异父母与未成年子女“虚拟探望权”研究. *南昌大学学报(人文社会科学版)*, (6).
- 赵丽. (2020). 儿童视角下家事审判的程序友好化改造. *青少年犯罪问题*, (4).
- 赵晋. (2018). 探望权执行困境及其制度回应. *法学家*, (4).
- 陈苇. (2019). 以儿童最佳利益原则审视探望权制度. *法律科学*, (2), 85-99.
- 魏晓娜. (2022). 电子探望的法律规制与制度建构. *法学论坛*, (5).

ХАВСРАЛТ

Хавсралт 1 Асуулгын судалгааны нээлттэй хариултуудын нэгтгэл

№	Хариулт
1.	Гэрлэлт цуцлах маргаанд хүүхдийн уулзалтын эрхийг зөвхөн цаасан дээр биш, бодит амьдрал дээр хэрэгжүүлэх механизмыг хуульчлах шаардлагатай.
2.	Хүүхдийн уулзалтын эрхийг шийдвэрлэхдээ эцэг, эхийн зөрчлөөс илүү хүүхдийн сэтгэл зүйн байдлыг нэн тэргүүнд тавих хэрэгтэй.
3.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатанд хүүхдийг албадан уулзуулах нь хүүхдэд сэтгэл зүйн дарамт болдог тул нийгмийн ажилтны оролцоог нэмэгдүүлэх нь зүйтэй.
4.	БНХАУ-ын туршлагаас харахад гэр бүлийн төрөлжсөн шүүх байгуулах нь маргааныг хүүхдэд ээлтэй байдлаар шийдвэрлэхэд тустай гэж үзэж байна.
5.	Хүүхдийн наснаас хамаарч (8-аас дээш нас) түүний санал бодлыг шүүх хуралдаанд заавал сонсдог журам тогтоох шаардлагатай.
6.	Монгол Улсын Гэр бүлийн тухай хуульд "уулзалтын эрх" гэсэн нэр томъёог илүү нарийвчлан тодорхойлж, хэлбэр, давтамжийг нь тодорхой зааж өгөх хэрэгтэй.
7.	Эцэг, эхийн хэн нэг нь уулзалтын эрхийг санаатайгаар боогдуулсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг чангатгах шаардлагатай.
8.	Хил дамнасан (Монгол-Хятад) гэр бүл цуцлалтын маргаанд хүүхдийн эрхийг хамгаалах хоёр талт гэрээг боловсронгуй болгох нь чухал.
9.	Гэр бүлийн зуучлагч болон сэтгэл зүйчийн дүгнэлтийг шүүхийн шийдвэрийн үндэслэл болгодог системийг нэвтрүүлэх.
10.	Уулзалтын эрхийг хэрэгжүүлэхдээ хүүхдийн сурч боловсрох, амрах цаг хугацаанд саад болохгүй байхаар хуваарийг оновчтой тогтоох.
11.	БНХАУ-ын адил "уулзалтын эрхийг түр зогсоох болон сэргээх" зохицуулалтыг Монголын хууль тогтоомжид тусгах нь зүйтэй.
12.	Нийгмийн халамж, хамгааллын байгууллагаас дараах хяналтыг тогтмол хийж, хүүхдийн эрх зөрчигдөж байгаа эсэхийг магадлах.
13.	Хүүхдийн тэтгэмж төлөлт болон уулзалтын эрхийг хооронд нь холбож болохгүй, энэ нь хоёр тусдаа эрх ашиг юм.
14.	Гэр бүлийн маргаан шийдвэрлэх явцад хүүхдийн өмгөөлөгч эсвэл тусгай төлөөлөгч томилох практикийг нэвтрүүлэх.

15. Эцэг, эхчүүдэд зориулсан "салалтын дараах хүүхэд хүмүүжил"-ийн сургалтыг албан журмаар явуулдаг болох.

16. Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нарт хүүхэдтэй харилцах арга зүйн тусгай сургалт орох шаардлагатай.

17. Уулзалтын эрхийг хэрэгжүүлэхдээ цахим харилцаа (видео дуудлага) ашиглах боломжийг хуульчлан баталгаажуулах.

18. Хүүхдийн амьдарч буй орчин өөрчлөгдөх бүрт уулзалтын журмыг уян хатан байдлаар дахин хянах боломжийг олгох.

19. БНХАУ-ын "失信 (найдваргүй этгээд)"-ийн жагсаалт шиг хатуу биш ч гэлээ, шүүхийн шийдвэр биелүүлээгүй талд эдийн засгийн хөшүүрэг хэрэглэх.

20. Гэрлэлт цуцлах маргаан бол зөвхөн хоёр хүний асуудал биш, хүүхдийн ирээдүйг шийдэж буй нийгмийн асуудал гэж хандах цаг болсон.

Хавсралт 2 Судалгааны ярилцлагын удирдамж



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ

Гэрлэлт цуцлах маргаанд хүүхдийн эрхийг хамгаалах нь (Монгол болон БНХАУ-ын эрх зүйн зохицуулалтын харьцуулалт)	Судалгааны ярилцлагын удирдамж
Энэхүү удирдамж нь судлаачид зориулагдсан бөгөөд ярилцлагын явцад зорилтод бүлэгт тохирсон үг хэллэг хэрэглэх ба асуултын дарааллыг судлаач өөрөө тодорхойлж болно.	
УДИРДАМЖИЙН БҮТЭЦ ХЭСЭГ 1: Танилцуулга ХЭСЭГ 2: Сэдвийн ерөнхий мэдээлэл ХЭСЭГ 3: Үндсэн асуултууд ХЭСЭГ 4: Чөлөөт ярилцлага	

ХЭСЭГ 1: Танилцуулга	1 минут
-----------------------------	----------------

- СУДЛААЧ ӨӨРИЙГӨӨ БОЛОН СУРГУУЛИА ТОВЧ ТАНИЛЦУУЛАХ
- СУДАЛГААНД ОРОЛЦОГЧИЙН ТАНИЛЦУУЛГА
- СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДОД АНХААРУУЛАХ
 - Зөв/буруу хариулт гэж үгүй

- Бусдын санаа бодолд хүндэтгэлтэй хандах
- Хувь хүний нууцыг хадгална
- Тэмдэглэл хөтөлж буй болон дуу хураагуур ашиглахыг тайлбарлах

ХЭСЭГ 2: Сэдвийн ерөнхий мэдээлэл	2 минут
--	----------------

- **СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АГУУЛГЫГ ТАНИЛЦУУЛАХ**

- Судлаач нь судалгаанд оролцогчдод сэдвийн талаар ерөнхий ойлголт өгнө.

ХЭСЭГ 3: Асуулт асуух	10 минут
------------------------------	-----------------

1.Монгол Улсын шүүхийн практикт хүүхдийн уулзалтын эрхийг шийдвэрлэхэд тулгарч буй гол хүндрэл юу вэ?

2.БНХАУ-ын Иргэний хууль дахь хүүхдийн эрхийг хамгаалах заалтуудаас Монголд нутагшуулах боломжтой ямар зохицуулалт байна вэ?

3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатанд уулзалтын эрхийг бодитой хэрэгжүүлэхэд нийгмийн ажилтны оролцоо ямар түвшинд байна вэ?

4."Хүүхдийн эрх ашиг нэн тэргүүнд байх" зарчим Монгол Улсын шүүхийн практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?

5.БНХАУ-ын гэр бүлийн мэргэшсэн шүүхийн тогтолцоо Монгол Улсад тохирох уу?

ХЭСЭГ 4: Чөлөөт ярилцлага	5 минут
----------------------------------	----------------

- Нэмэлт санал болон дүгнэлтүүд.

ТАЛАРХАЛ ИЛЭРХ